

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 7
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 – 85
1.	<i>“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг</i>	9 – 20
2.	<i>Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	20 – 45
3.	<i>“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох</i>	45 – 62
4.	<i>“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон Сангийн сайдын мэдээллийг сонсох</i>	62 – 85

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 9 дүгээр сарын 16-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 52 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Чөлөөтэй: Х.Булгантуяа, Д.Пүрэвдаваа, Г.Тэмүүлэн, Д.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Б.Чойжилсүрэн.*

***Нэг. ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан
Монгол Улсын Ерөнхийлөгчийн хорио***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Ганболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Ж.Алдаржавхлан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Ганболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Х.Ганхуяг: Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын

Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 3
Бүгд: 20
85.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дахь заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 19
Бүгд: 20
5.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын дэд даргын зөвлөх Р.Даваадорж оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Ж.Баясгалан, Р.Батболд, Н.Алтанхуяг, Г.Ганбаатар, Ж.Алдаржавхлан, Б.Заяабал, Д.Батбаяр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж, Улсын Их Хурлын дэд даргын зөвлөх Р.Даваадорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, П.Ганзориг, Д.Жаргалсайхан, Ж.Батсуурь, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.9-д заасны дагуу хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Дээрх горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Үүрийнтуяа, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 19
Бүгд: 23
17.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Х.Ганхуяг: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 3
Бүгд: 23
87.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.*“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Эрүүл мэндийн яамны Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Отгонбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч Х.Өлзий-Орших, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Ж.Баясгалан, Р.Батболд, Б.Мөнхсоёл, П.Ганзориг, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон Сангийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга В.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ариунбилэг, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эрчим хүчний яамны Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга Ш.Ганзориг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Эрүүл мэндийн яамны Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Отгонбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч Х.Өлзий-Орших, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон Сангийн сайдын мэдээллийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Да.Цогтбаатар, П.Ганзориг, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын

газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эрчим хүчний яамны Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга Ш.Ганзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон Сангийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 23 минут үргэлжилж, 29 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 79.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 52 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Байнгын хорооны эрхэм гишүүд энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.2 хувьтай байгаа тул Төсвийн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Жуковын Алдаржавхлан, Ринчиндоржийн Батболд, Хөххүүгийн Болормаа, Цэрэнпилийн Даваасүрэн, Чинбатын Номин, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Норовын Алтанхуяг, Жигжидийн Батжаргал, Гомбын Ганбаатар, Баатаржавын Мөнхсоёл, Пүрэвжавын Сайнзориг, Тилеуханы Аубакир, Жадамбаагийн Баясгалан, Хассуурийн Ганхуяг, Пүрэвбаатарын Мөнхтулга, Даваагийн Цогтбаатар нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээр асуудал. ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг.

Хоёр. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Гурав. “Монгол Улсын төсвийн тухай хууль батлуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох.

Дөрөв. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон Сангийн сайдын мэдээллийг сонсох.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоол хэсэгчлэн хориг тавьсан асуудлыг хэлэлцье.

**Нэг. “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан
Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг**

Ажлын хэсэг оруулъя. Санал хураалттай.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Алтанхуягийн Үйлстөгөлдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Гочоогийн Ганболд Ерөнхийлөгчийн зөвлөх, Жаргалсайханы Мөнхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Алтанхуягийн Үйлстөгөлдөр танилцуулна.

А.Үйлстөгөлдөр даргын микрофоныг нээе. 5 номерын микрофоныг нээе.

А.Үйлстөгөлдөр: Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд дараах үндэслэлээр Монгол Улсын Ерөнхийлөгч хэсэгчилсэн хориг тавьсныг танилцуулъя.

Нэг. Монгол Улс тусгай хамгаалалтад авсан газар нутгийг нэмэгдүүлж байгаль орчноо хамгаалах бодлого баримтлах ёстой.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 5 дугаар заалтад алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 46, 47 дугаар тогтоолуудад өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэхээр тусгасан.

Энэхүү яаралтай өргөн мэдүүлж, өөрчлөлт оруулахаар дурдсан Монгол Улсын Их Хурлын 46, 47 дугаар тогтоолууд нь зарим газар нутгийг улсын тусгай

хамгаалалтад авч тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.

Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх бодлого тууштай хэрэгжих нь зүйтэй боловч энэ хүрээнд алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг, түүний хилийн заагийг өөрчилж, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг багасгах хууль зүйн нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасны дагуу экологийн аюулгүй байдлыг хангах, түүний тэнцвэрийг хадгалах, байгаль орчин, ой, усны сан бүхий газрыг хамгаалах, цөлжилттэй тэмцэх нь үндэсний аюулгүй байдлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэн ховор, ховор болон эко системд онцгой үүрэгтэй амьтан, ургамал бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч тэд эдгээрийн амьдрах орчныг тэтгэхэд биотехникийн аргыг түлхүү хэрэглэхээр тусгасан байдаг.

Иймд байгаль орчны талаарх төрийн бодлого цаашид өнөөгийн улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх зарчмыг тууштай баримтлах нь зүйтэй.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд тогтоолд нийцүүлэх нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина хэмээн тус тус Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд заасан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт энэ хуулийн 46.4-д заасны дагуу илгээсэн хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих асуудлыг шийдвэрлэнэ гэж заасан байдаг.

Тэгвэл Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд энэ тогтоолыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй хэмээн заасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох хэсэгт заасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг зөрчих шинжийг агуулсан байна.

Иймд дээр дурдсан үндэслэлээр “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан хоригийг холбогдох хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ үү гэсэн байна.

Х.Ганхуяг: А.Үйлстөгөлдөр даргад баярлалаа.

Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Г.Ганбаатар гишүүнээр тасаллаа.

Ж.Алдаржавхлан гишүүнийг нэмье. Л.Мөнхбаясгалан гишүүний микрофоныг асаая. Г.Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Төсвийн байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе.

Та бүхэн маань сайхан амарсан уу? Бид өчигдөр чуулганы нээлт болоод өнөөдөр Төсвийн байнгын хороо анхныхаа хурлыг хийж байна.

Анхны хурлаараа бид бүхэн 2025 оны 07 дугаар сарын 09-нд Улсын Их Хурлын 85 дугаар тогтоолоор батлагдсан “Алт-3” хөтөлбөр дээр Ерөнхийлөгчийн 07 сарын 28-ны өдрийн Улсын Их Хурлын тогтоол дээр хэсэгчилсэн хориг тавьсан асуудлыг өнөөдөр хэлэлцэх асуудлын эхэнд хэлэлцэж байгаа юм байна.

Яах вэ, ер нь Ерөнхийлөгчийн хориг дээр гол нь байгаль орчны асуудлыг л тусгасан юм байна л даа. Тогтоолтой нь өнөөдөр л танилцаж байна. Үгүй ээ. Юутай нь. Хоригтой нь.

Хамгийн гол нь яах вэ, алтыг олборлож болно. Гэхдээ ард нь байгаль орчныхоо асуудлыг, тусгай хамгаалалттай газар нутгийнхаа асуудлыг яасан юм бэ. Байгаль орчны талаарх төрийн бодлого ер нь яаж явах юм бэ л гэдэг л. Үүнийгээ тууштай байгаа ч гэсэн ийм л зүйл байгаа юм байна. Үүнийг нь хувь хүнийхээ хувьд дэмжиж байна.

Гэхдээ нэг асуулт нь. Бид нарт ийм туршлага байна уу? Бид ер нь юуг алдаж юуг онож байна вэ?

Мэдээж яах вэ, аливаа байгалийн баялаг. Байгалийн баялаг ч юу байх вэ дээ. Байгалийн нөөц шүү дээ. Нөөцийг дэлхийн зах зээл дээр үнэтэй байх үед нь борлуулах нь зөв. Тэр агуулгаараа “Алт-3” дугаар аяныг хувь хүнийхээ хувьд маш сайн дэмжсэн. Одоо эргээд байгаль орчныг хамгаалах асуудалтайгаа тусгай хамгаалалттай газар нутагтайгаа бас зөрчилдсөн хэсэг энэ тогтоол дээр үүсэж байгаа юм байна.

Тэгэхээр бид юуг энд олборлолоо гэхэд. Одоо Улсын Их Хурлын тогтоол хэрвээ хоригийг хүлээж Улсын Их Хурал энэ хоригийг хүлээж авахгүй гэвэл бид эргээд тэр байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ, байгаль орчны хохирлыг нь тэр тооцсон чиглэлийн юм нь байна уу гэж асуух. Ерөнхийлөгчийн Тамгын газар, холбогдох зөвлөхүүдээс энэ асуултыг асууя.

Яг ямар хэмжээний эдийн засгийн хохирол учрахаар энэ тал дээр тооцоод энэ хоригийг тавихдаа ямар эдийн засгийн тооцоолол хийсэн юм болоо? Дараа нь тодруулъя.

Х.Ганхуяг: Хэн хариулах вэ? 5 номер.

А.Үйлстөгөлдөр: Г.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Алтны олгосон байгаа лицензүүдийн тоо багадаагүй юм билээ. Өнөөдөр ашиглалтын тусгай зөвшөөрөл нь хүчинтэй 80 гаруй алтны үндсэн орд байгаа. Гэтэл эдгээрээс нь 14 ордод нь л олборлолт хийгдээд байгаа юм билээ. Үлдсэн 68 нь эдийн засгийн эргэлтэд ороогүй байгаа.

Тооцоод үзэхээр 230 тонны нөөц байгаа гэж үзэж байгаа. Тэгээд лицензүүдээ амь оруулж чадахгүй, эдийн засгийн эргэлтэд оруулж чадахгүй асуудлууд байгаа.

Тэгэхээр эдийн засгийн эргэлтэд үүнийг оруулъя. Эрх зүйн орчныг нь сайжруулъя. Компаниудынхаа дарамтыг багасгая. Тэгээд гаднын хөрөнгө оруулалт татах бүрэн боломжууд гарч ирээд байгаа юм билээ. Алтны үнэ өсөөд байгаа учраас.

Тэгэхээр бид олгосон лицензүүдийнхээ үр нөлөөг авах, эдийн засгийн эргэлтэд оруулах хангалттай боломж байгаа гэж үзэж байгаа.

Тэгэхээр үүнтэй холбоотой заалтууд орсон байгаа гэж үзэж байгаа.

Тийм учраас хэсэгчилсэн хориг тавьсан.

Тэгэхээр ийм боломжууд бид нарт байсаар байтал заавал тусгай хамгаалалттай газар, дархан цаазтай газар, голын ай сав, мөн тэгээд бүр хилийн зурвас зарим нь орж байгаа. Тэгээд үүнийг судлаад үзэхээр бүр 3 төрийн тусгай хамгаалалттай, төрийн тохилогтой хайрхныг дайрах аюул нүүрлэж байгаа асуудал юм билээ.

Тэгэхээр үндсэндээ бидэнд энэ боломж бололцоо хангалттай байна. Тэгээд алт олборлолтын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хариуцлагатай уул уурхайг дэмжих, бусад холбогдох эрэл хайгуулын асуудал ч байна. Бусад лицензийн боломжийн асуудлууд байна. Үүнийг эрчимжүүлэхийг дэмжиж байгаа.

Тэгэхээр тооцоо судалгаануудыг хараад үзэхэд бүрэн боломжтой байна л гэж үзэж байгаа юм. Баярлалаа танд.

Х.Ганхуяг: Г.Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Ерөнхий үндэслэл нь би одоо зөв ойлгов уу? Алтан дээр олгосон лиценз чинь хангалттай байгаа юм байна. Байгаа лицензүүдээ эдийн засгийнхаа эргэлтэд оруулсны дараа нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, төрийн 3 тахилгатай хайрхан энэ дотор нь орж байгаа юм байна. Үүнийгээ бас болиоч ээ гэсэн асуудал байгаа юм байна. Тийм үү?

Яах вэ, миний асуултын агуулга нь юу гэхээр ер нь байгаль орчинд учруулж байгаа хохирол. Алтыг нь авч байгаа ч гэсэн нөгөө талдаа учруулж байгаа хохирол тэр чиглэлийн тооцоо байна уу гэж асуусан байхгүй юу.

Бас нэг зүйлийг зүгээр ташрамд хэлэхэд хилийн бүсийн зурвас орсон гэж. Энэ дээр би маш эсрэг байр суурьтай байдаг хүн шүү. Яагаад вэ гэхээр аливаа улс орнууд хилийн бүсийнхээ, ялангуяа яваандаа хилийн бүс нутагт маргаан гарах вий гэдэг үүднээс нэн тэргүүнд хилийн бүс орчмынхоо нутагт хайгуул хийж, түүнийгээ эдийн засгийн эргэлтэд оруулдаг маш олон туршлага байдаг. Үүнийг энэ талаас нь дэмжих боломжгүй.

Түүнээс төрийн тусгай хамгаалалттай.../минут дуусав/

Х.Ганхуяг: Нэмэх үү? Нэмээд 1 минут.

Г.Ганбаатар: Тэр төрийн тохилогтой хайрхан хийгээд бусад байгаль орчныг хамгааллын асуудал дээр нь дэмжиж байна.

Х.Ганхуяг: Хариулах уу? Ажлын хэсэг. Ажлын хэсгийн 5 номер.

А.Үйлстөгөлдөр: Г.Ганбаатар гишүүн танд дараа нь энэ 46, 47 дугаар тогтоолтой холбоотой хамрагдаж байгаа газар нутгуудтай холбоотой, түүн дээр хийгдсэн зарим судалгааны мэдээллүүдийг тан руу явуулъя. Баярлалаа.

Х.Ганхуяг: Г.Ганбаатар гишүүн ээ, манайх ажлын албанаас энэ асуудал дээр нэлээн судалгаа хийсэн.

Тэгээд нэгдүгээр асуудал болохоор процессын алдаа гарсан. Одоо тусгай хэрэгцээний газрыг гаргах асуудлыг зөвхөн Засгийн газрын санаачилгаар Улсын Их Хурал баталдаг. Гэтэл төсвийн тодотголын үед орж ирсэн л дээ. Гишүүдийн санаачилгаар зарчмын зөрүүтэй саналаар орж ирсэн. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. Монгол Улс 2022 онд нэгдэж орсон олон улсын гэрээ байгаа. 190 гаруй орны Монреалийн гэрээ юм байна. Тэгээд түүгээр манайх тусгай хэрэгцээний газраа байнга нэмэгдүүлэх үүрэг хүлээсэн гэсэн хоёр үндсэн шалтгаан байгаа юм л даа.

Тэгэхээр бид 1 дүгээр зүйлийг ер нь хүлээж авахаас өөр аргагүй ээ л гэж.

Ж.Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Баярлалаа. Ерөнхийлөгчийн хоригийг ер нь дэмжиж байгаа.

Тэгэхдээ ганц, хоёр зүйлийг асуумаар санагдаад байгаа. Тэгэхдээ Ерөнхийлөгчийн Тамгын газраас асуух нь хаашаа юм. Тусгай хамгаалалттай газраас алт олборлоно гэдэг чинь Монгол Улс чинь ер нь үүцээ нээе ээ л гэсэн үг юм байна шүү дээ. Тийм ээ. Авдраа ухъя. Авдараа ухаж хэдэн төгрөг гаргаж ирье гэсэн санаа байгаа юм.

Тэгээд Ерөнхийлөгчийн Тамгын газрынхан тэрийг таслаад судалж үзсэн үү, үгүй юу? Монгол Улс ер нь тийм авдараа ухах хэмжээнд хүрсэн үү? Үүцээ задлах хэмжээнд хүрсэн үү, үгүй юу гэдэг. Та хэд ер нь яг юу гэж үзэж байгаа юм?

Хоёрдугаарт, тогтоолын төслийг санаачилсан нөхдүүд чинь гадаад валютын нөөцийг огцом нэмэгдүүлнэ гэсэн байна шүү дээ.

Тэр асуудал нь хаашаа эргэх юм бол? Тэр талаас та бүгд ер нь судалж үзсэн үү, үгүй юу? Ийм хоёр асуулт байна.

Х.Ганхуяг: 6 номер.

Г.Ганболд: Ерөнхийлөгчийн хоригийн үндсэн санааг сая Байнгын хорооны дарга хэллээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн байгууллагын, тэр дундаа Их Хурлын бүрэн эрх зөвхөн Засгийн газрын өргөн мэдүүлснээр тусгай хамгаалалттай газар нутгийг тэлэх, хумих тухай асуудлыг ярих ёстой гэдэг агуулгаар Ерөнхийлөгч хориг тавьсан.

Үндсэндээ Ерөнхийлөгч “Алт-3” аяныг дэмжсэн бусад заалтуудыг нь дэмжээд, ганцхан 5 дахь заалт дээр нь яагаад хэсэгчилсэн хориг тавьсан юм бэ гэхээр бусад алтны ордуудыг нээн илрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, Монголбанкны алтны нөөцийг нэмэгдүүлэхийг дэмжиж байгаа.

Хамгийн гол нь 5 дахь заалт нь зөвхөн Улсын Их Хурлын 46, 47 дугаар тогтоолоор тусгай хамгаалалтад авсан тэр лицензтэй аж ахуйн нэгжүүдийг

буцааж сэргээж алт олборлох тухай асуудал байгаа. Үүнийг тухайн үед уул уурхайн сайд тодорхой хэлж байсан. Гацуурт, Цагаан баавгайт, Гутайн даваа гэсэн 3 лицензтэй аж ахуйн нэгжүүдийг алт олборлох тухай асуудал. Үйлдвэрлэл нь баригдсан гэж.

Энэ 3 аж ахуйн нэгжүүдийг бид судалж үзэхэд тухайн үедээ яг эдийн засгийн үр ашиггүй гээд зогсоосон байсан аж ахуйн нэгжүүд. Өнгөрсөн 07 дугаар сарын үед алтны үнэ дэлхийн зах зээл дээр 40 гаруй хувь өссөнтэй холбоотой, энэ аж ахуйн нэгжүүдийн тухайн үедээ алтны үнэ өссөнтэй холбоотой бага зэргийн ашиг олохоор байсан болохоос биш улсын эдийн засагт тодорхой том хэмжээний хувь нэмэр оруулахааргүй байна. Үүнээс шалтгаалаад эдийн засгийн томоохон үр өгөөж байхгүй байна.

Тийм учраас 46, 47 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад тухайн газар нутгуудыг бид авахдаа Хүннүгийн үеийн булш бунхан, эртний түүхэн дурсгалт газрууд, байгалийн хосгүй үзэсгэлэнтэй газрууд дээр энэ лицензүүд байна гэж үзээд 2020 онд энэ лицензүүдийг улсын тусгай хамгаалалтад. Тэр дундаа Ноён уул бол дархан цаазтай газарт авсан байгаа.

Тэгэхээр цаашдаа эдийн засгийн богино хугацааны хүндрэлийг далимдуулан дархан цаазат болон тусгай хамгаалалттай газар нутгаасаа бид газар чөлөөлж алт олборлох ийм боломжуудыг нээх үүд хаалга нээгдэх юм гэж үзэж Ерөнхийлөгч зөвхөн 5 дугаар заалт дээр нь хориг тавьсан болохоос бусад заалтуудыг, алтны экспортыг, хил, гаалийг чангатгах, бусад тусгай хамгаалалттай газар нутгаас бус, бусад алтны уурхай, ордуудыг ашиглах дээр дэмжиж ажиллаж байгаа.

Зөвхөн энэ 5 дугаар заалт дээр, энэ 3 лицензтэй холбоотой асуудал дээр л хэсэгчлэн хориг тавьсан юм гэдгийг хэлье.

Х.Ганхуяг: Ж.Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Ер нь эдийн засагт айхтар авдараа ухах хэмжээнд хүрээгүй гэж үзэж байгаа юм байна шүү дээ? Тийм ээ. Би бас дэмжиж байна.

Ер нь цаашдаа Их Хурал дээр ийм тогтоолын төсөл санаачлахдаа манай Их Хурлын гишүүд маань анхаармаар юм байна. Алт гэдэг чинь нөгөө нүүрс шиг шууд ухаад авчихдаг эд биш. Нэлээн ажиллагаатай зүйл байна шүү дээ.

Тэгэхээр төсөв, эдийн засагтай холбоотой, татвартай холбоотой ийм асуудлууд дээр Төсвийн байнгын хороо ер нь цаашдаа маш сайн ажлын хэсэг гаргаж судалмаар юм шиг байна. Сэтгэлийн хөдөлгөөнөөр ийм тогтоол гаргадаг. Дараа нь тэрийгээ эргээд өөрсдөө буцаагаад буруутгаад сууж байна гэдэг чинь бас нэг талаасаа тийм байгаа юм. Энэ дээр цаашдаа анхаарч ажиллавал зүгээр байна гэж хүсэж байна.

Х.Ганхуяг: Ер нь төсвийн тодотголыг баталж байх процесст ажлын хэсэг дээр энэ санал дэмжигдээгүй. Байнгын хороон дээр дэмжигдээгүй.

Яг нөгөө чуулганаар хэлэлцүүлж байхад хэсэг гишүүд орилоод тэгээд. Ер нь яах вэ хэдэн гишүүн байгаа. Нэр дурдаад яах вэ.

Л.Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Улсын Их Хурлын 2025 оны 07 сарын 09-ний өдөр 85 дугаар тогтоол гэдэг дээр манай 126-тай парламент анхныхаа хуулийн хулгайг өлгийдөн авсан. Энэ 5 дахь хэсгийн 1 дээр Ерөнхийлөгч хориг тавьсанг үндэслэлтэй. Үүнийг бид хүлээж авах ёстой.

Яагаад гэхээр энэ асуудлыг Засгийн газар санаачлаагүй. Ажлын хэсэг санаачлаагүй. Тэгж байснаа гэнэт хэдэн гишүүд орилолдоод л баталсан гээд байгаа байхгүй юу.

Одоо энэ Улсын Их Хурлын 46, 47 дугаар тогтоол чинь, 2020 оны тогтоол чинь Хэнтий аймгийн Батширээт сумын Биндэр сумын нутагт орших Гутайн даваа, Хөмүүл голын эх байгалийн цогцолборт газар, Алтан Хөхий уул гээд ийм газрууд байгаа.

47 дугаар тогтоол бол дангаараа Ноён уулын төрийн тусгай хамгаалалтад авсан тогтоол байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр юу гэж тогтоол дээр гарсан бэ гэхээр энэ 46, 47 дугаар тогтоолд тусгай хамгаалалттай газрын хэмжээг багасгах асуудлыг Засгийн газар яаралтай боловсруулан Улсын Их Хуралд оруулж ирэх чиглэл өгсөн байхгүй юу. Үүн шиг хуулийн хулгайтай бид олон тааралдах байх л даа.

Тэгэхээр бид олон улсын гэрээ конвенц, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого зэрэгт бид 2030 он гэхэд тусгай хамгаалалттай газар нутгийг 30 хувьд хүргэх ёстой.

Монгол Улсад мөнгө хэрэгтэй. Монгол Улс “Үндэсний баялгийн сан”-гаа арвижуулах ёстой. Алтаа олборлох ёстой. Гэхдээ Үндсэн хуульд заасан түүх дурсгал, өв соёлоо хөндөж болохгүй. Ногоон байгалиа хөндөж болохгүй. Дэлхий нийт өнөөдөр байгалиа хамгаалах, байгалийн тэнцвэр алдагдаж байгаа, эко систем алдагдаж байгаа бүхний эсрэг явж байгаа.

Тэгэхээр “Алт-3” хөтөлбөрийн энэ далбаан доор хэн хэн үүнийг зохион байгуулалттай хийсэн бэ гэдгийг одоо бүүр тодруулж олж олон түмэнд зарламаар санагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр Улсын Их Хурал, Байнгын хороо эрхэм гишүүд ер нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээж авах ёстой. Энэ дээрээ санал нэгдэж өгөөч ээ гэж хүсэж байна.

Х.Ганхуяг: Үг хэлсэн үү? Тийм ээ.

Л.Мөнхбаясгалан: Үг хэллээ.

Х.Ганхуяг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Ерөнхийлөгчийн хоригтой холбоотойгоор үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ж.Батжаргал гишүүнээр тасаллаа. Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын тогтоолд хэсэгчилж Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хориг тавьсан байна.

Би хоригийг хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ тогтоол яаж гарсан бэ гэдэг асуудал байгаа юм. Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөл дотор байгаагүй заалт. Их Хурлын ажлын хэсэг боловсруулж оруулж ирсэн. Төсвийн байнгын хороон дээр энэ заалтыг унагасан юм. Дэмжихгүй гэж. Тэгээд чуулганы нэгдсэн хуралдаан дээр босож ирээд батлагдчихсан ийм заалт байгаа юм.

Угаасаа тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиараа Монгол Улсын Засгийн газар тусгай хамгаалалтад авах гаргах асуудлаа өөрөө өргөн барих эрх нь байгаад байгаа. Их хуралд захиалга өгөөд байх албагүй. Нэг.

Хоёр дахь зүйл нь, бид “Алсын хараа-2050” дотроо байгаль экологийнхоо асуудлыг хамгаалах, тэнцвэрт байдлыг нь хадгалах үүднээс тусгай хамгаалалттай газар нутгийнхаа хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх замаар 2030 он гэхэд 30 хувьд хүргэх ийм зорилттой. Өнөөдөр 21.4 байна уу даа. Тийм хувьтай байгаа. Үүнээсээ бууруулах гээд байгаа.

Тийм учраас энэ уур амьсгалын өөрчлөлт нэлээн тийм хүчтэй явж байгаа энэ цаг үед аль болохоор бид тусгай хамгаалалттай газар нутгийнхаа хэмжээг нэмэгдүүлж, экосистемийнхээ тэнцвэртэй байдлыг хадгалж, энэ үндэстнийхээ уламжлалт аж ахуй, өв соёлоо дээдэлж авч явах, байгальтайгаа харьцах тэр монгол ухаан сэтгэхүй, өвгөдийнхөө уламжлалыг дагах нь зүйтэй гэж би ингэж үздэг.

Тийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан энэ хоригийг манай Их Хурал хүлээж авах ёстой. Тэр тусмаа Төсвийн байнгын хороо хүлээж авах ёстой. Бид анхнаасаа энэ заалтыг дэмжээгүй заалт. Ийм саналтай байна.

Х.Ганхуяг: Ц.Даваасүрэн даргын микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Миний хэлэх гэсэн үгийг бараг Ж.Батжаргал гишүүн хэлчихлээ.

Тэгээд энэ бол бас яг тухайн үедээ нэлээн зохимжгүй. Засгийн газрын өөрөө санаачилж оруулж ирээд хийх юмыг Их Хурал санаачлаад, зааж өгөөд, бараг хаана ухах вэ, аль газрыг алтыг нь олборлох юм гэдэг ч юм уу, нэг тийм хандлага гарсныг манай Байнгын хороо унагасан юм.

Тэгээд чуулган дээр очоод босчихсон байхгүй юу. Тэгээд манай Их Хурлын гишүүд чуулганаар энэ хоригийг хэлэлцэхэд анхаарах хэрэгтэй. Хоригийг хүлээж авах хэрэгтэй. Ялангуяа энд чинь тусгай хамгаалалттай дархан цаазтай газар нутгууд ороод байгаа учраас л Их Хурал ийм юм санаачилж болохгүй ээ гэж тухайн үед манай Байнгын хорооны гишүүд хатуу байсан юм.

Тийм учраас манай Байнгын хорооны гишүүд бүгд энэ хоригийг хүлээж авах байх гэж би найдаж байна. Яагаад гэвэл Байнгын хорооны угаасаа санал тийм байсан учраас. Чуулган дээр очоод л манай санал унаад явсан байхгүй юу. Тэгээд өнөөдөр ингээд л эргээд л ороод ирж байна л даа.

Тэгэхдээ үүнийг дэмжээд явах нь зүйтэй. Бид бүүр үнэхээр аргаа тулаад ирвэл тэр Оюу Толгойн луйвраас мөнгөө авъя л даа. Тэндээс бид ерөөсөө борлуулалтын орлогын 5-хан хувийг хүртэж байгаа шүү дээ. Тэнд чинь энэ алтнаас хэд дахин их алт байгаа шүү дээ.

Одоо энэ Гачууртын алт чинь 50-хан тонн. Тэнд чинь 1800 тонн алт шүү дээ. 30 дахин их алт шүү дээ. 30 дахин их алтаа харахгүй 40, 50-хан тонны тухай бид хэрэлдээд л, эсвэл одоо тэрийгээ шохоорхоод сууж болохгүй л дээ.

Бэлэн байгаа, үйл ажиллагаа нь эхэлсэн байгаа. Одоо тэр “Онтрэ Гоулд”-ын талбайн асуудлыг бид шийдээд, харин тэндээс бид валютын нөөц, алтныхаа орлогыг олоод явах ёстой. 30 дахин их алтыг олж харахгүй мөртлөө дархан цаазтай газрынхаа 30-хан тонн алтыг л шуналтаад яваа байхгүй юу. Тэгэхээр энэ бол буруу.

Тийм учраас бид ер нь хэрвээ валютын нөөц, эдийн засгийн экспортын орлогын хомсдолд ороод ирэх юм тэр Оюу Толгойн гэрээгээ зөвтгөх асуудлыг ялангуяа Их Хурал ярих ёстой. Яагаад би тэгж байна вэ гэвэл энэ Их Хуралд тэр Оюу Толгойн шан хөрөнгө хүртсэн улсууд харьцангуй байхгүй шахуу. Цэвэр улсууд байгаа.

Тийм учраас тэр “Онтрэ Гоулд”-ын асуудлыг ер нь Засгийн газар яаралтай оруулж ирэх. Тэнд хамгийн их алт байгаа. Тэр талбай дээр. Тэгээд гэрээгээ шинэчлэх асуудлыг л бид харин ярьж явах нь зохистой байгаа юм. Энэ хоригийг бид хүлээж аваад явах хэрэгтэй.

Х.Ганхуяг: Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Хоёр санал хураалт явагдана.

Нэгдүгээр санал нь, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Саяын хэлсэн асуудлаар гэсэн үг. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүн дэмжиж, 85.0 хувийн саналаар Ерөнхийлөгчийн хориг дэмжигдсэн байна.

Хоёр дахь санал хураалт нь, харин гишүүд Та бүхэн маань бас бодолцохгүй бол болохгүй байгаа.

Энэ хүчин төгөлдөр болох хугацаан дээр Ерөнхийлөгч хориг тавьсан байгаа. Энэ нь болохоор Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын энэ тогтоолыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэдэг заалт дээр хориг тавьсан гэсэн үг.

Энэ Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад зааснаар хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах. Энэ бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн.

Монгол Улсын Их Хурлын 3 дугаар зүйлийн 3.2-т Улсын Их Хурал Төрийн эрх барих дээд байгууллагын хувьд хууль тогтоох эрх мэдлийг өөртөө дангаар хадгална гэж орсон байдаг.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлээр хуулийг дагаж мөрдөх журмын асуудлыг зохицуулсан заалтад заавал ч үгүй тусгадаг гэсэн үг. Одоо хууль батлахдаа бид энэ хуулийг хэзээнээс дагаж мөрдөх вэ гэдэг заавал ч үгүй ордог гэсэн үг.

Тэгэхээр энэ асуудлыг бид дэмжихгүй байх нь зүйтэй байна гэж бодож байна. Тэгээд санал хураалтад хэлцгээгээрэй. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтын дүнг танилцуулахад татгалзсан 19 гишүүн, 95.0 хувиар татгалзсан байна.

Санал хураалт явж дууслаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

**Хоёр.Онцгой албан татварын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүн
2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудал. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж танилцуулна.

Б.Пүрэвдорж даргын микрофоныг нээе. 5 номерын микрофоныг нээе.

Б.Пүрэвдорж: Эрхэм Байнгын хорооны дарга болон Улсын Их Хурлын гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Тэгэхээр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг миний бие болон Ш.Бямбасүрэн, Д.Пүрэвдаваа, Н.Батсүмбэрэл нарын гишүүд өргөн барьсан.

Энэ хуулиар Монгол Улсын шатахууны зах зээл дээр керосин, нафта зэрэг бүтээгдэхүүнүүдийг оруулж ирж, түүнийг хуурамчаар хольж, үйлдвэрийн бус аргаар хольж зах зээлд нэвтрүүлэх энэ үйл явц 2006 оноос хойш Монгол Улсад хийгдэж байгаа.

Тэгэхээр энэ хуурамч шатахуун нь иргэдийн эд хөрөнгийг эвдэх, мөн түүнчлэн иргэдэд эрүүл мэндийн хувьд маш хортой ийм бүтээгдэхүүнийг хийдэг. Өөрөөр хэлбэл томоохон шатахууны бааз дээр торхонд 75 хувьд нь дизелийн түлш хийлээ гэхэд 25 хувьд нь хольцуудыг хольж, доор нь сэнс байдаг. Тэр сэнсээр эргүүлж хольж байгаад тэгээд зах зээлд нийлүүлдэг. Энэ бүтээгдэхүүн нь иргэдийн машин тэргийг эвдэх, мөн түүнчлэн томоохон уул уурхайн компанийн тоног төхөөрөмжийг маш хурдан эвддэг.

Дээрээс нь зориулалтын бус учраас, Та бүхэн санаж байгаа бол хэдхэн жилийн өмнө өвлийн хүйтэнд Улаанбаатар хотын гэрлийн шон тас хар болсон байдаг. Энэ юуг илэрхийлж байна вэ гэвэл ерөөсөө хамгийн хямдхан энэ шатахуунуудыг төрийн өмчийн компаниудын автобусууд худалдаж авч, үүгээр нь тэр автобус нь явдаг. Тэр нь хар утаа хаядаг ийм л нөхцөл байдалтай байсан.

Тэгэхээр энэ хуурамч шатахуун бол хэт бага үнээр зах зээл дээр төрдөг учраас өнөөдрийн шатахууны компаниуд “Евро-5” зэрэг орчин үеийн чанарын шаардлага хангасан тэр бензин шатахууныг Монголд хэрэглэх боломжгүй болтол нь үнээр шахдаг ийм хууль бус бизнес юм.

Тэгэхээр энэ хууль бус бизнесийн үр үр дүнд нэгдүгээрт 2019, 2020 оны үед нийтдээ 200 мянга гаруй тонн керосин, нафта зэрэг бүтээгдэхүүн орж ирж 25 хувиар холигддог. Жишээ нь, 2023 онд 82 мянга 100 тонн, 2024 онд 54 мянга 400 тонн зэрэг орж ирсэн.

Тэгэхээр энэ 54 мянга 400 тонн орж ирж байна гэдэг чинь 25 хувиар холигдоно гэхээр ойролцоогоор 200 мянган тонн шатахуун энэ зах зээл дээр хуурамчаар борлуулагдаж байна гэсэн үг.

Тийм учраас энэ нь нэгдүгээрт Монгол Улсын татварын орлогод онцгой татваргүй оруулж ирж татварын орлогод нөлөөлж байгаа.

Мөн түүнчлэн иргэдийн машин тэрэг эвдэхэд маш их нөлөөлж байгаа учраас энэ асуудлыг, Онцгой татварын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2019 онд өргөн барьсан. 2021 онд энэ хуулийг хэлэлцэж Их Хурал баталсан. Гэвч 2023 онд хуурамч шатахууны асуудал Үндсэн хуулийн цэцээр ороод Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг ийм хууль бус дүгнэлт гаргасан гэж үздэг. Түүнийг нь Их Хурал хүлээж авч миний өргөн барьсан энэ хуулийг 2023 оны 7 сард хүчингүй болгосон. Үүнээс хойш энэ хольц илүү их Монгол Улсын хилээр нэвтрэх хандлага нэмэгдэж байна.

Тийм учраас энэ хуулийг дахин өргөн барьсан байгаа. Тэгээд Их Хурлын гишүүд, Төсвийн байнгын хорооны гишүүд Та бүхэн энэ хуулийг хэлэлцэж дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Х.Ганхуяг: Б.Пүрэвдорж даргад баярлалаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Р.Батболд гишүүнээр тасаллаа. Би өөрөө хамгийн сүүлд нь бас асуучихъя.

Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг нээе.

Д.Үүрийнтуяа: Надад хоёр асуулт байна. Нэгдүгээрт, энэ хуулийн төсөл дээр Засгийн газар татгалзсан санал өгсөн байна лээ.

Тэгэхээр яг ямар үндэслэлээр гэдгийг бас яг энэ хуралдааны тэмдэглэлээс тодорхой бус байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр яг татгалзсан үндэслэл нь юу юм бэ? Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулаад татгалзчихсан юм уу? Эсвэл судалгаа, дүгнэлт нь болоогүй байна гэж үзсэн юм уу? Энэ дээр тодруулах шаардлагатай гэж үзэж байна.

Хоёрт нь, та сая хууль санаачлагчийн хувьд тайлбартаа хэллээ. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гараад энэ хуулийг хүчингүй болгосон юм гэж. Тэгээд дахиад энэ хуулийг өргөн барьж байна гээд.

Өмнө нь Үндсэн хуулийн цэцээр хүчингүй болсон тэр хуулиас ямар өөрчлөлт орж байгаа вэ? Ямар нэгэн өөрчлөлтгүйгээр эсвэл ирж байгаа юу? Тухайн үед цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээгээд авчихсан.

Тэгэхээр одоо энэ ямар өөрчлөлттэйгөөр орж ирж байгаа вэ гэдгийг тодруулмаар байна.

Х.Ганхуяг: 5 номерын микрофон.

Б.Пүрэвдорж: Энэ хууль бус бизнес бол Монголын төр, засгийн бүх шатанд нөлөөлөх замаар энэ хууль бус бизнесээ хийдэг.

Ер нь торхны доор сэнс тавьж байгаад тэгээд сэнсээ эргүүлж хуйлруулах замаар шатахуун хийдэг байсан бол манайх Алтанширээ дээр 1.7 тэрбум доллароор шатахууны үйлдвэр барих ямар ч шаардлага байхгүй.

Үүнийг түрүүчийн хэд хэдэн парламентаар хэлэлцэж байхад маш их айдастай. Өөрөөр хэлбэл Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны албан тушаалтнууд танай энэ чинь үйлдвэр мөн юм уу гэхээр биш ээ, цех гэж байгаа юм. Цехээр шатахуун үйлдвэрдэг байсан бол одоо энэ дэлхий даяараа ийм том үйлдвэр барих ямар ч шаардлага байхгүй.

Тэгэхээр Засгийн газар бас тодорхой хэмжээний нөлөөнд орсон гэж. Байнга л нөлөөнд орж байдаг. Яг энэ хүмүүсийн. Энэ хуурамч шатахуун хийдэг хүмүүсийн нөлөөнд орж байна.

Тэгэхдээ нэг зүйлийг хэлэхэд хэд хэдэн яамд энэ хуурамч шатахуун дээр дэмжиж санал өгсөн. Жишээ нь, Сангийн яам дэмжиж санал. Хуурамч шатахуун бол болохгүй ээ гэдэг. Энэ татварын асуудал үүсгэж байгаа гэдгийг дэмжиж санал өгсөн байгаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр бизнесийг адил тэгш боломж олгоогүй гэдэг л нэг тийм ерөнхий зүйл гаргаад л, тэгээд л түүнийх нь дагуу гүжирдэж Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсан л гэж би үздэг.

Тийм учраас би ямарваа нэгэн өөрчлөлтгүйгээр, өөр агуулгагүйгээр яг хуучнаар нь өргөн барьсан.

Б.Заяабал: Д.Үүрийнтуяа гишүүнд нэмэлт минут өгье.

Д.Үүрийнтуяа: Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гараад, тэгээд Улсын Их Хурал хүлээгээд авсан байхад дахиад ямар ч өөрчлөлтгүйгээр юм уу, ямар ч нэмэлт судалгаагүйгээр орж ирэх нь болох юм уу? Хууль эрх зүйн хувьд. Энэ л байна л даа.

Цэцийн дүгнэлтийг Засгийн газрын хурлын тэмдэглэлд дурдсанаас үзэхэд “бүрэн бус судалгаа, тооцоонд үндэслэсэн байна” гэдэг л зүйлийг яриад байна л даа.

Тэгэхээр би тодруулах гээд байгаа нь хууль санаачлагчийн зүгээс Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдсаны дагуу энэ судалгаа, тооцооллын нарийвчилсан зүйл байгаа юу? Энэ удаа өргөн барихдаа нарийвчилсан зүйл байна уу гэдгийг л би тодруулах гээд байгаа юм л даа.

Яг энэ керосин, нафта зэрэг түүхий эдийг ашиглаад үйлдвэрлэл эрхлээд байгаа хэчнээн аж ахуйн нэгж яг байгаад байгаа юм. Тусгай зөвшөөрөлтэй.

Үнэхээр яг энэ орж ирж байгаа түүхий эд маань, хилээр орж ирж байгаа түүхий эд маань тэр чигтээ хуурамч шатахууны үйлдвэрлэлд ашиглагдаад байгаа юм уу? Энэ дээр судалгаа байгаа юм уу?

Б.Заяабал: Б.Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье. Хариулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр тухайн үед Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн энэ Их Хурал дээр үг хэлэхдээ дотоодод хуурамч шатахууны үйлдвэрлэл байгаа эсэх асуудлаар тусгай ажлын хэсэг байгуулагдаж ажилласан.

Энд хоёр асуудал яригддаг. Хилийн гадна боловсруулсан хуурамч шатахуун орж ирдэг гэсэн яриа бий. Шалгалтаар ийм асуудал огт тогтоогдоогүй. Харин дагалдах бүтээгдэхүүнүүдийг оруулж ирээд энд холилт хийх замаар шатахуун хийсэн асуудал гарсан.

Дээж авч шинжлэхэд стандартын бус байдал илэрсэн нь үнэн гэдэг ийм ажлын хэсгийнхээ дүгнэлтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн гэж.

Тэгэхээр мэдээж тодорхой хэмжээний судалгаанууд нь байгаа юм. Өөрөөр хэлбэл хуурамч шатахуун хийж байна гэсэн тэр бүх зүйлийг Та бүхэнд өгсөн материал дотор бүрэн тодотгож өгсөн байгаа гэдгийг хэлье.

Х.Ганхуяг: Ж.Баясгалан гишүүний микрофоныг өгье.

Ж.Баясгалан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгээд үүнтэй 100 хувь санал нэг байна. Одоо ялгаагүй бас л хэрэглэгч. Бид бол. Тэгээд миний машинд ч гэсэн тохиолдсон. Маш олон эргэн тойрны машин тохиолдож байгаа.

Ерөөсөө шатахуун хийгээд тэгээд машин зогсдог. Асахаа байсан. Ингээд диллер дээр очоод үзүүлэхээр ерөөсөө л түлшний системийг цэвэрлээд л машин буцаад хэвдээ орчихдог.

Тэгвэл та нар энэ бол. Түрүүн Б.Пүрэвдорж гишүүн хэллээ шүү дээ. Шат шатдаа байгаа. Үүнийг хамгаалж байгаа хүмүүс гэж эрх мэдэлтнүүд байгаа гэж хэлж байна. Яг л үнэн. Яагаад гэвэл дилерээс хэрвээ танай асуудлаас болоогүй юм бол, машины гэмтэл биш юм бол шатахуунаас болсон уу. Тийм ээ. Тэгвэл надад тийм албан бичиг хийгээд өгөөч ээ. Энэ шатахууны чанараас болсон гэдгийг бичээд өгөөч ээ гэхээр бичиж өгдөггүй.

Тийм юм бол танай дилерийн асуудал байна. Машины асуудал байна гэхээр. Машины асуудал биш ээ гээд мөнгөө нэхээд байдаг.

Энэ бол тэнд зогсож байгаа мянга мянган хүмүүс хэлж байгаа. Тэгээд л угаасаа хүн болгоны л хэлэх асуудал энд 100 хувь байгаа.

Одоо тэр нэг сэтгүүлч залуу яваад л гадуур тэр шатахуунуудыг хэмжээд байгаа шүү дээ. Тэгээд л хэмжээд үзэхээр ерөөсөө хэмжээндээ хүрдэггүй. Хотынхон ч хүрдэггүй. Хөдөөгийнхөн ч хүрдэггүй. Одоо ганц хүрч байгаа нь 95 байна. Яагаад гэвэл тэр нь үнэн чөлөөтэй болохоор. Ялангуяа 92 дээр энэ асуудал бол бүр маш хэцүү байгаа. 92-ын үнийг хэтэрхий барьснаас болоод дахиад энэ асуудал чинь гарч ирж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ талаар судалгаа байгаа юу? Энэ судалгаагаа сайн танилцуулаад яваарай. Тэгэхгүй бол яг түрүүчийн Д.Үүрийнтуяа гишүүний хэлсний адил яг хуучнаараа ороод ирэх юм бол дэмжигдэхгүй байх, бусад хүмүүс ойлгохгүй байх тэр юмнууд гарч ирнэ.

Тэгэхээр Б.Пүрэвдорж гишүүд одоо асуулт гэхээсээ илүү хэлэхэд дахиад тэр нэмж хийсэн судалгаануудаа гоё гишүүддээ танилцуулаад өгөөрэй. Одоо Төсвийн байнгын хороон дээр ч гэсэн ялгаагүй тэр танилцуулгуудаа өгөх юм бол бид бас түүнтэй танилцаж харах хэрэгтэй байна гэдэг ийм шууд үг хэлчихье.

Х.Ганхуяг: Үг хэллээ. Р.Батболд гишүүний микрофоныг өгье.

Р.Батболд: Байнгын хорооны хуралд оролцож байгаа гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Онцгой албан татварын энэ хуулийг дэмжиж байна. Бид машин тэргээ эвдүүлдэг, хуурамч шатахуун хэрэглээд байгаа гэдэг асуудал сүүлийн их олон жил яригдаад байна л даа.

Тэгээд эндээс хоёр асуулт асуух гэсэн юм. Нэг дэх нь болохоор Д.Үүрийнтуяа гишүүн сая асуугаад байна л даа. Энэ Үндсэн хуулийн цэц үүнийг хүлээж аваагүй байгаад байдаг.

Тэгэхээр яг хэвээрээ ороод ирж байгаа. Энэ нь дахиад цэц дээр очоод дахиад унаад буцаад хэрэгжихгүй болох вий гэдэг зүгээр юу байна шүү дээ. Бас нэг санаа зовох гэдэг юм уу. Нэгдүгээрт нь, тийм боломж нь ямар байдаг юм гэдэг асуулт.

Хоёрдугаарт, хольц гээд байгаа энэ бүтээгдэхүүнүүд байна. Энэ нафта гээд хоёр, гурван төрлийн. Керосин энэ тэр гээд. Хоёр, гурван төрлийн бүтээгдэхүүнүүд байна. Үүний Монгол Улсын өөрийнх нь хэрэглээ нь ямар байдаг юм? Яг дангаар нь хэрэглэдэг зүйл байдаг юм уу, байдаггүй юм уу? Хэчнээн тонныг нь яг хэрэглээнд явуулаад, үлдсэн нь яг хуурамч шатахуунд явж байгаа шүү гэдэг ийм судалгаа байна уу? Ийм хоёр асуулт асууя.

Х.Ганхуяг: 5 номерын микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Импортын мэдээнээс, гаалиас өгсөн мэдээнээс харахад хоёр, гуравхан компани маш их хэмжээгээр авч байгаа. Маш их хэмжээгээр. Цөөхнөөр авдаг ганц, хоёр компани байгаа. Тэр нь 200 килограмм, 300 килограмм авдаг компаниуд байдаг. Тэр нь жишээ нь Эрдэнэтэд ч юм уу, томоохон үйлдвэрүүдэд тодорхой хэмжээгээр хэрэглэгддэг ийм зүйл байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг их хэмжээгээр биш, яг энэ дотоодын үйлдвэрлэлд хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл хүнд аж үйлдвэрт хэрэглэгддэг, аль эсвэл үйлдвэрлэлийн үйл явцад зайлшгүй шаардлагатай тэр бүтээгдэхүүнүүдийг тодорхой квотоор олгох, татваргүйгээр олгох асуудлыг яг хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг дээр шийдэж болохоор оруулсан байгаа.

Үндсэн хуулийн цэцийн асуудлыг манай Р.Даваадорж зөвлөх. 6 номер хариулчих.

Х.Ганхуяг: 6 номерын микрофон өгье.

Р.Даваадорж: Төсвийн байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд өнөөдөр хуурамч шатахуунтай холбоотой энэ асуудал орж ирсэн. Энэ бол хууль тогтоогч та бүхэн бол маш том зургаар харах хэрэгтэй. Зөвхөн хуурамч шатахууны асуудлыг ярьж байгаа юм биш. Энэ онцгой албан татвараас зугтаж, бултаж байгаа компанийн үйл ажиллагааг бид ярьж байна шүү дээ.

Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэх юм бол онцгой албан татвартай тухайлах юм бол машин байна. Машин авч орж ирвэл онцгой албан татвар төлнө. Сэлбэгийг нь оруулаад ирэх юм бол онцгой албан татвар төлөхгүйгээр машин угсраад явж болно гэдэг шийдвэрийг гаргах юм уу, гаргахгүй юм уу гэдэг л асуудал шүү дээ.

Тэгэхээр ийм асуудал орж ирсэн учраас Та бүхэн зөв талаас нь харж, зөв зүйтэй шийдвэр гаргаасай. Хэрвээ энэ асуудал Улсын Их Хурал дээр унах юм бол дараа дараагийн онцгой албан татвартай асуудлууд ингээд л цувчихна гэсэн ийм нэг эмзэглэл байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн мэдээж харж зөв зүйтэй шийдвэр гаргах байх гэсэн зүйлийг хэлье. Мэдээж зөвхөн юу гэдэг юм Улаанбаатар хот болоод байгаа биш. Энэ бол хөдөө орон нутагт бид нарыг энэ хууль бичээд явж байхад маш олон хүмүүс бид нартай холбогдож, маш олон хүмүүс эд хөрөнгөөрөө хохирсон талаар ярьж байсан.

Тэгэхээр энэ дээр зөв зүйтэй шийдвэр гарах байх гэж би бодож байна. Бүх судалгаа баримтууд бол бүгд байж байгаа. Та бүхэн уншихад байгаа.

Х.Ганхуяг: Р.Батболд гишүүн.

Р.Батболд: Яах вэ, одоо цэцийг бол бид мэдэхгүй учраас би зүгээр тийм эрсдэл байх вий л гэж хэлж байгаа юм.

Хоёрдугаарт, энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээд явна. Тэгэхдээ хэлэлцүүлгийн явцад саяын миний хэлсэн асуултын дагуу тэр судалгааг нь сайн хийж орж ирэх хэрэгтэй байх. Тэгэхгүй бол нөгөө машин нь эвдрээд байдаг шүү дээ гээд л нэг иймэрхүү байдлаар явах юм бол энэ чинь бас аягүй зовлонтой болчихоод байгаа. Орж ирж байгаа тоо хэмжээ нь байгаад байдаг. Дотоодынхоо хэрэглээ нь яг хэд юм бэ гэдгийг нэг судлаад үзсэн нь дээр байх л гэж бодож байна. Тэрийг сайн хэлэхгүй бол ойлгохгүй шүү дээ наадах чинь. Яг хэдийг нь хэрэглээд байгаагаа мэдэхгүй. Их хэмжээгээр орж ирж байгаа нь яг хэрэглэгдээд байгаа юм уу, үгүй юу гэдгээ ч бид өөрсдөө бараг. Тийм. Түүн дээрээ ч гэсэн сайн судалсан нь дээр байх.

Х.Ганхуяг: Үг хэлчихлээ. Н.Алтанхуяг гишүүний микрофон өгье.

Н.Алтанхуяг: Энэ чинь одоо хуулийн асуудал юм уу? Б.Пүрэвдорж гишүүн. Хорлон сүйтгэх үйл ажиллагаа, гэмт хэргийн асуудал юм уу?

Хоёр, гурван компани орж ирдэг юм бол тэр их хэмжээгээр оруулж ирж байгаа компаниуд нь юунд, яаж хэрэглэдэг юм гээд л хууль хяналтын байгууллага нь аваад үзээд шийдчихэж болдоггүй юм уу? Миний нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт, энэ компаниудынх нь нэрийг хэлчхээч. Энэ иргэдийн машин техникийг, үнэтэй цэнтэй авсан юмыг нь аваачиж бензин саванд нь янз бүрийн юм хольж хорлон сүйтгэж байгаа гэмт хэрэг л байна шүү дээ. Тэгээд үүнийг Улсын Их Хурал хуулиа батлаад явуулахаар зэрэг лобби гэнэ үү, юу гэнэ вэ? Тэгээд баахан юм явж байгаад буцаад шинээр санаачилна гэдэг бол манай улс бүрэн дампуурч яваа юм биш үү? Бид ер нь хууль тогтоогоод.

Одоо тэгээд яах юм? Дахиад цэц нь ингэхээр бид дахиад санаачлах уу? Энэ хулгайч нартайгаа тэмцдэггүй юм уу? Хуультайгаа биш. Хуулийг чинь хулгайн аргаар алга болгочхоод байгаа юм байна шүү дээ. Би тэгж ойлголоо.

Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт хэлээч. Нээрээ бид Их Хурал бол арай дэндэнэ шүү. Иргэдийн машин техник, нэг муу халтуур хийдэг машиныг нь аваачиж энэ хогийн бензин, бензинийг хольж байгаад шахаад тэгээд зогсоочхоод байхад нь бид тэгээд л энд “эх орон гоё байна”, “албан тасалгааны цонхоор амьдрал сайхан харагдаж байна” гээд л ингээд л сууцгааж байдаг л нэг ийм л сонин юм боллоо шүү дээ.

Би бол Б.Пүрэвдорж гишүүн нэг энэ хуулийг анх оруулж байхад нь би бас ярьж байсан юм. Наадах чинь явах юм болов уу даа гэсэн. Үгүй ээ ер нь их том тэмцэлтэй хууль л даа. Хулгайч нартай л тэмцэж байгаа юм шүү дээ.

Та харин тэр мэрийгээ нэг жаахан тодорхой хэлээд өгөөч ээ. Нэг л их тийм гоё хууль батлуулаад л, хууль мөрдүүлээд л байх юм яриад байх юм. Энэ хулгайтай тэмцэж байгаа гээд хэлээд. Тэр компаниудынхаа нэрийг хэлчих.

Ер нь хэн үүнийг хийдгийг бас хэлчих.

Х.Ганхуяг: Б.Пүрэвдорж даргын микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Энэ хууль бус бизнесийг хийхийн тулд Монголын яг энэ шатахуун дээр хяналт тавьдаг хууль хяналтын байгууллага, яам, Тамгын газар энэ бүх зүйлийг бүгдийг нь худалдаж авдаг компани. Бүгдийг нь худалдаж авдаг. Бүгдийг нь үг дуугүй болгодог компани.

Энэ компаниудын нэр бол “Лекс Ойл”, “Трансгейт”, “Петролиум продакшн” гэж компаниуд байгаа.

Одоо сүүлийн үед цөөхөн болсон. Гурав, дөрөвхөн болсон. Олон компаниар оруулж ирдэг байж байгаад одоо энэ жил гэхэд “Лекс Ойл” гэдэг компани ерөнхийдөө оруулж ирсэн. “Трансгейт” гэж компани хоёр.

Тэгэхээр энэ компани Үндсэн хуулийн цэцийг хүртэл худалдаж авсан. Энэ компани өнгөрсөн парламентын Их Хурал дотор гишүүдэд хүртэл нөлөөлсөн.

Тийм учраас энэ компанийн асуудал нь буцаад хууль нь хүчингүй болж шийдэгдсэн гэсэн үг.

Тэгэхээр Монголын ард түмний эрүүл мэндийн төлөө, ямарваа нэгэн эвдрэлгүй машин тэргээ авч явахын төлөө. Дээрээс нь Монголчууд чинь цаашаа хөгжмөөр байна шүү дээ.

Бид Евро-5-ыг хэрэглэмээр байна шүү дээ. Гэтэл энэ компани хямдхан шатахуун оруулж ирээд зах зээл дээр зараад байхаар нөгөө бусад компаниуд ерөөсөө хөгжихгүй байна шүү дээ. Үүнээсээ шалтгаалаад бид хамгийн хортой шатахуунуудыг бид хэрэглэж байна шүү дээ. Үүнээс чинь болоод 92 гэдэг шатахуун л хэрэглэнэ. Түүнээс үнэтэй, чанартай тийм шатахууныг бид хэрэглэж чадахгүй байна шүү дээ.

Тэгээд нэг зүйлийг хэлье. Энэ шинэ парламент. Олон сайхан залуучуудтай болсон. Монголын төлөө зүтгэх ийм сайхан эр зоригтой хүмүүс ирсэн. Дээрээс нь 126 болсон.

Тэгээд нэг дураараа Монголын төрд нөлөөлөөд байдаг энэ цаг үе чинь өнгөрсөн л гэдгийг бас хэлмээр байна.

Х.Ганхуяг: Б.Пүрэвдорж гишүүн ээ. Уг нь таны хуулийг чинь өмнөх парламент ч дэмжээд л явуулчихаад байдаг.

Тэгээд одоо бид ингээд явуулчихлаа гэж бодоход дахиад нэг асуудал бол гарах юм байна. Энэ чинь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль гэж байдаг юм байна. Тэрний 15 дугаар зүйлийн 3-д зааснаар хэрэвзээ тэр нөгөө хүчингүй болгосон шийдвэр нь агуулгаараа 100 хувь буцаад сэргээд ороод ирвэл цэц шууд хэрэг үүсгээд явах боломжтой асуудал байгаа юм байна шүү.

Тэгэхээр агуулгаар нь жоохон өөрчилж л оруулж ирэх ёстой л байсан юм байна гэж харагдаад байна.

Тэгэхээр үүнийг бас Б.Пүрэвдорж гишүүн ээ ярилцах хэрэгтэй юм байна. Нэг бол хуулийн дүгнэлт гаргуулах хэрэгтэй юу, үгүй юу?

Г.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Бид чинь одоо энэ асуудлын өмнөхөн саяхан бас нэг Их Хурлын гишүүдийн санал авахгүйгээр нэг хэсэг нөхдүүдийн алтны уурхайн ч лобби юм уу хаашаа юм. Тэгээд тэр нэг Улсын Их Хурлын нөгөө “Алт-3” тогтоол гараад. Сая тэгээд Ерөнхийлөгчийн хориг, хэсэгчилсэн хориг тавиулаад тэрийгээ өөрчиллөө шүү дээ.

Одоо энэ асуудал чинь болохоор бас л нэг хувь компанийн хууль санаачлагчаас оруулж ирж байгаа, бас танилцуулж байгаа зүйл дээр нь хувь компанийн л лобби төрд ямар их байдгийг. Дээрээс нь манай Улсын Их Хурлын зарим гишүүд яагаад тийм хувийн компанийн лоббид өртөж олон нийтийн эрх ашгийн эсрэг ийм хууль баталдгийн л тод жишээ л гэж ойлгож байна.

2006 оноос хойш явсан юм бол энэ чинь олон жил, бараг 20 жил явчхаж байгаа юм байна шүү дээ.

Тэгэхээр энэ судалгаан дээр нь яг аж ахуйн нэгжүүд, иргэд, ялангуяа тэр уул уурхай, газар тариалан, хөдөө аж ахуйн компаниуд ямар хэмжээний эдийн засгийн хохирол учруулсан. Тэр чиглэлийн тооцоо нь байна уу?

Та бүгдийн хуучин хийж байсан хуулийн төслийн үзэл баримтлалын үндэслэл шаардлага дээр чинь яах вэ нийтдээ гол агуулга нь болохоор 63 тэрбум төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлэх орлого. Онцгой болоод гааль гээд. Энэ юмнаас л зайлсхийсэн нэг хэсэг нөхдүүдийн асуудал юм байна гэж би ойлголоо. Тэгээд энэ чиглэлийн тооцоо байна уу гэж.

Хоёрт нь, энэ Засгийн газрын тэмдэглэлийг сая хараад сууж байсан. Бид энд хууль дэмжигдээд явлаа. Тэр нефта, өөр юу гэдэг юм дайвар бүтээгдэхүүн ч гэдэг юм уу. Энэ дээр онцгой албан татвар тавьчихвал эргээд нефтийн үйлдвэр, Дорноговь аймагт баригдаж байгаа нефтийн үйлдвэр, ялангуяа газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүнд сөрөг нөлөө үзүүлэх юм биш биз гэсэн бас нэг ийм болгоомжлолын асуулт байна.

Бид энд тавьж болно. Тэгтэл нөгөө нефтийн үйлдвэр нь ороогүй байдаг. Түүнд шаардлагатай байгаа баахан дайвар бүтээгдэхүүн чинь энэ татварт орчих юм биш биз дээ гэсэн энэ хоёр чиглэлийн асуулт дээр хариулт аваадахъя.

Х.Ганхуяг: 5 номер.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яг энэ машин тэрэгний эвдрэлийн асуудал дээр маш даруухан тоо тавьсан. Өөрөөр хэлбэл жилдээ 100 орчим тэрбум төгрөгийн машин тэрэгний хохирол үзүүлдэг.

Тэгэхээр ер нь бол одоо портер машин, малчдын унаад байгаа портер машин 2 жил болоод л, жил хагас болоод л дизель аппаратур нь эвдэрч байгаа. Приус машиных нь карбюратор 3 жил болоод л эвдэрч байгаа. Тэр хооронд яадаг вэ гэхээр “За, за... олон жил эвдэрсэнгүй. Ганц хонь нядлаад тэгээд юу

яачихна, төлбөрийг нь төлөөд шинээр тавьчихна.” гээд л. Өөрөөр хэлбэл уг нь тэр карбюратор чинь 20, 30 жил эвдрэхээргүй зохион бүтээгдсэн байгаа юм шүү дээ. Тэгээд энэ нь юунаас шалтгаалж байна вэ гэх дээр хуурамч шатахуунаас болж л эвдэрч байгаа.

Тэгээд энэ эвдрэлийг даруухнаар тавьсан.

Хоёрдугаарт нь, би сая өнгөрсөн онд гэхэд Эрдэнэтийн “Эрдмин” үйлдвэр 76 тонн керосин оруулж ирсэн байна. Өөр бусад нь бол зөвхөн хоёрхон компани буюу одоо тэр хольц хийдэг компани оруулж ирсэн гэсэн үг.

Тэгэхээр энэ хэлэлцүүлгийн явцад нэг зүйлийг хийж болно. Өөрөөр хэлбэл яг дотоодын боловсруулах үйлдвэрт хэрэгтэй тэр нэмэлт бүтээгдэхүүнийг тодорхой квот олгох замаар шийдэж болно.

Хоёрдугаарт нь, Алтанширээгийн үйлдвэр ашиглалтад орлоо гэхэд тодорхой хольцууд хэрэгтэй болох байх. Энэ дээр тусгайлан Засгийн газар бас өөрөө шийдвэр гаргаад энэ дээр шатахууны асуудлыг, онцгой татварын асуудлыг шийдэх эрхтэй байдаг.

Тийм учраас энэ хүрээндээ л шийдэх боломжтой гэж хэлье. Баярлалаа.

Х.Ганхуяг: Ж.Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Хуурамч шатахуун үйлдвэрлэгч нартай тэмцэх гэж байгаа Б.Пүрэвдорж гишүүн тэргүүтэй гишүүдийн саналыг дэмжиж байгаа. Гэхдээ хоёр асуулт байна.

Дайвар бүтээгдэхүүн дотор чинь энэ керосин, нафта энэ тэр гээд нөхдүүд ордог юм байна шүү дээ. Бүтээгдэхүүнд ордог юм байна. Энэ ер нь ямар ямар юманд хэрэглэгддэг юм бэ? Керосин чинь онгоцны түлш биш билүү?

Хэрвээ энэ нэмэгдэх юм бол нөгөө орон нутгийн онгоцуудын маань тасалбар нэмэгдээд орон нутгийн иргэдэд маань хүндрэл учрах уу? Энэ керосин, нафта зэрэг хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүнээр юу юунд хэрэглэдэг юм бэ гэсэн. Нэг дэх асуулт ийм байгаа.

Хоёрдугаарт, Үндсэн хуулийнхаа цэцийг яаж тойрч гаргах вэ? Та хэд сая Х.Ганхуяг гишүүн аягүй чухал юм ярьчихлаа шүү дээ. Яг энэ чигээрээ бол дахиад хэрэг үүсээд, дахиад нөгөө хүмүүстээ очоод ялагдаад, дахиад энэ хууль чинь явахгүй нь. Тэгээд энэ хуулиа амьдруулахын тулд Та бүгд маань ажиллаж жаахан өөрчилбөл яасан юм. Яг энэ чигээр батлагдах юм бол хэрэг үүсээд тэр чинь Үндсэн хуулийн цэц дээр нөгөөдүүл чинь хүлээж байгаа. Тэгээд эргээд баталчихна.

Тэгэхээр нэг тийм цаг үрсэн ажил болох юм биш биз дээ. Их Хурал энд нэг хэлэлцээд батлаад явдаг. Тэнд очоод унадаг. Тоглоом шиг юм болох вий дээ.

Тийм учраас Та бүгд маань тэр Б.Пүрэвдорж гишүүний хажууд сууж байгаа Р.Даваадорж гуай Монголбанканд байгаа хүн. Та хэд судалгаа энэ тэр хийгээд өшөө заалт энэ тэр дэлгэрүүлээд үзвэл яасан юм гэсэн ийм хоёр асуулт байна.

Х.Ганхуяг: Хэн тайлбар өгөх вэ? 6 номер. Ажлын хэсгийн 6 номер. Тэгээд Тамгын газрын Ч.Дондогмаа дарга ер нь бас энэ дээр нэг тайлбар өгчихмөөр байна. Яг цэцтэй холбоотой асуудал дээр дүгнэлт гаргуулах шаардлагатай эсэх гээд. 6 номер.

Р.Даваадорж: Керосиныг юунд ашигладаг вэ гэсэн асуулт байна. Их Хурлын гишүүн Баяржавхлан гишүүний асуултад хариулъя.

Керосиныг гэрэлтүүлэгт ашигладаг, дэнлүү, чийдэн гээд орон нутагт ашигладаг байгаа. Мөн халаалт. Керосиныг тодорхой хэмжээгээр халаалт, байшин халаахад ийм зориулалтаар оруулж ирдэг. Мөн гал тогоо. Керосины зуухыг хоол хүнс бэлтгэхэд ашигладаг гэсэн ийм хэд хэдэн төрлийн зүйлд керосиныг ашигладаг.

Гэхдээ бид нарын яриад байгаа энэ зүйл бол судалгааг нь хийгээд ирэхээр яг тэр хууль батлагдсанахаа дараа энэ асуудал, керосины орж ирж байгаа статистик үзүүлэлт огцом буурсан. Яагаад гэвэл нөгөө хуурамч шатахуунд хэрэглэхээ больчихож байна гэсэн үг.

Эргээд хууль сэргээд ирсний дараа ахиад өсөөд ирж байгаа. Тухайн үед эхний хууль өргөн барихад 100 гаруй тэрбум төгрөгийн асуудал гарч ирж байсан. 100 гаруй тэрбум төгрөгийг онцгой татвараас зугтааж байна гэж бид тооцоо, судалгаа гаргаж байсан юм.

Тэгэхдээ энэ бол одоо их багадаа биш. Хамгийн гол нь нэгдүгээрт шударга бус үйл явдал. Үүнийг чинь дагаад түрүүн миний ярьдаг машины ченжүүд та нар тэгвэл бензин үйлдвэрлэдэг юмнуудыг нь ингээд зөвшөөрчихдөг юм байна. Тэгвэл бид яагаад болдоггүй юм? Бид жижиглээд оруулаад ирэхэд юу нь болохгүй. Яг л ижилхэн асуудал. Ижилхэн кэйс байна шүү дээ гэдэг ийм асуудал үүсэх учраас энэ дээр бид болгоомжлоод байгаа юм.

Тэгэхээр хууль мөрдөгдөх ёстой. Дээр нь төсвийн энэ мөнгө төгрөгийн асуудал байна.

Гуравт нь, түрүүн манай гишүүн ярилаа. Бусад цэврээр бизнес хийж байгаа хүмүүстээ энэ чинь ингээд гай болоод байдаг юм гэсэн ийм гурав, дөрвөн гол зүйлийг хэлэхийг хүсэж байна.

Х.Ганхуяг: Одоо ажлын хэсгийн 5 номер.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь сүүлийн 4 жилийн судалгаагаар лит болон зэс боловсруулах зориулалтаар “Эрдмин” компани л ерөөсөө жилд 70 гаруй тонн керосин оруулж ирдэг. Бусдыг нь ерөөсөө л тэр хольц хийдэг компаниуд л оруулж ирдэг. Тэгэхдээ энэ дээр бол өөр ямарваа нэгэн энд тэнд бусад салбарт хэрэглээд байгаа юм бараг байхгүй байгаа.

Х.Ганхуяг: Ч.Дондогмаа дарга нэг тайлбар өгчих үү. Цэцийн юутай холбоотой асуудлаар. 9 номерын микрофон өгье.

Ч.Дондогмаа: Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан тайлбар хэлье.

Онцгой албан татварын тухай хуульд Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтээр яг энэ газрын тосны үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүн керосин гээд энэ бүтээгдэхүүнд тавигдсан албан татварын хэмжээг цэц түдгэлзүүлсэн.

Үүнийг Их Хурал 2023 оны 52 дугаар тогтоолоороо хүлээн зөвшөөрсөн байгаа. Тэгээд үүнтэй холбогдуулаад яг хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн төсөл бол энэ зохицуулалтыг агуулгаар нь сэргээж байгаа.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл цэцийн аль нэг гишүүний санаачилгаар цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно гэсэн ийм зохицуулалттай.

Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ гэдэг нь их суудлын хуралдаанаар хэлэлцээд шууд тогтоол гаргах ийм зохицуулалттай байгаа.

Улсын Их Хурлын тухай хуульд заасан Байнгын хорооны бүрэн эрх дээр Байнгын хороо хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулах бүрэн эрхтэй гэж заасан байгаа.

Тэгэхээр энэ яг цэцийн шийдвэртэй холбоотой асуудлаар хууль зүйн зөвлөмж гаргуулах ийм эрхийг Байнгын хороо хэрэгжүүлэх боломжтой.

Х.Ганхуяг: Зөвлөмж гаргуулъя гэвэл хэд хоногт багтаж гарах вэ? Ер нь.

Ч.Дондогмаа: Байнгын хорооны хүсэлтээр Тамгын газар 14 хоногийн дотор зөвлөмж гаргах. 14 хүртэл хоногийн хугацаанд зөвлөмж гаргах тийм зохицуулалттай.

Х.Ганхуяг: Ойлголоо. Б.Заяабал гишүүн асуултаа асууя. Байж байгаарай. Ж.Алдаржавхлан гишүүн тодруулах юм байна.

Ж.Алдаржавхлан: Р.Даваадорж гуай. Хоёулаа эхлээд танилчихъя. Би Ж.Алдаржавхлан гэдэг хүн байгаа шүү. Тийм.

Хоёрдугаарт, та бас муу зөвлөж байна. Ний нуугүй хэлэхэд. Их Хурлын гишүүнд. Саяын ярьж байгаа зүйлийг Та нар аль хэдийн олж харах ёстой байсан. Энэ асуудлыг Их Хурлын гишүүддээ тавих ёстой байсан. Хэрвээ одоо ингээд явчих юм бол энэ чинь зүгээр тоглоом болоод л, очоод үнс болоод ахиад унана. Нэг хууль санаачилсан нэг тийм л зүйл болох гээд байгаа юм.

Тэгэхээр одоо бид юу гэж зөвлөх гээд байна гэхэд үүнийгээ бас ярилцаад дараагийн шатын чуулганд орохоос өмнө үүнийгээ нэг янзлаач. Тэгэхгүй бол хэдүүлээ Үндсэн хуулийн цэцтэй нэг тоглодог тоглоом шиг болох гээд байна.

Та зөвлөх юм бол үүнийгээ сайн хиймээр байна. Бүх талаас нь хармаар байна. Хуульчдыг оруулмаар байна гэж одоо танд зөвлөх хүнд зөвлөчихье.

Х.Ганхуяг: Ер нь Ж.Алдаржавхлан гишүүн ч гэсэн зөв. Б.Пүрэвдорж гишүүн маань гүйгээд л байдаг. Нүүрээ улалзуулаад л. Уг нь зөв сэдэв байхгүй юу.

Тэгээд хүмүүст бэлэн хоолыг нь бэлдэж өгөөд байна шүү дээ. Б.Пүрэвдорж гишүүний микрофон өгье.

Б.Пүрэвдорж: 15 дугаар зүйлийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны хүрээ гэж.

Энэ 15.3 дээр хэрвээ эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа гэдэг нь. Одоо жишээ нь Их Хурал шийдвэр гаргахдаа цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл цэцийн аль нэг гишүүний санаачилгаар цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно гэж байгаа юм.

Тэгэхээр энэ бол дахиад миний хууль өргөн барих эрхийг хязгаарлаагүй гэсэн үг байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл би энэ цэцийн гаргасан шийдвэрийн дагуу дахиад хууль өргөн барьж болно. Одоо жишээ нь цэц үүнийг хууль бус гэж үзэх юм дахиж маргаан үүсэх боломжтой. Тэгэхдээ өнөөдрийн цэц үүнийг гаргахгүй. Үүнийг шийдсэн 5 шүүгч байгаа. 5 цэцийн гишүүн байгаа. Тэрний 4-өөр нь энэ асуудал шийдвэрлэгдсэн.

Х.Ганхуяг: Б.Заяабал гишүүн асуултаа асууя.

Б.Заяабал: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр өнөөдрийн яригдаад байгаа сэдэв бол бас зөв сэдэв гэдэг дээр би санал нэг байна. Сая бас хэд хэдэн гишүүд ярилаа. Манай Ж.Баясгалан гишүүн, Ж.Алдаржавхлан гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүн, Р.Батболд гишүүн, Байнгын хорооны дарга ч гэсэн энэ дээр яриад байна.

Ер нь үүнийг бид бас нэг мөр зөв хийж авч явах нь зөв байх. Тооцоо судалгаагаа бас эргэж яриад нэлээн нягтлаад үүнийг дахиж дараагийн шатны маргаан үүсгэхгүйгээр асуудлаа шийдээд явъя гэдэг дээр Байнгын хорооны гишүүд санал нэгтэй байна гэдэг нь эндээс бол харагдаж байна. Энэ дээр бас хууль санаачлагч маань анхаарахыг хүсэж байна.

Ер нь энэ хуурамч шатахуун үйлдвэрлээд байгаа энэ зүйл бол ямар нэгэн төрөөс хяналтгүй явдаг юм байна. Мэдээж энэ нь иргэдийн эдийн засгийн болон эрүүл мэндэд хортой үйл ажиллагаа явуулж байгаа. Зах зээлд тэгш бус өрсөлдөөнийг бий болгож байгаа гээд. Энэ болгон дээр маргаан байхгүй. Энэ асуудлуудаар дэмжиж байгаа гэдгийг илэрхийлье.

Ингээд таны оруулж ирсэн материалуудыг аваад үзэхэд ер нь нэг нефть импортолдог, шатахуун импорт алдаг компаниудын 51 хувь нь импортынхоо худалдан авалтдаа зарцуулдаг. 34 хувь нь татвар, 16 хувь нь үйл ажиллагааны зардалд зарцуулдаг. Ингээд ашиггүй учраас ашиг хийхийн тулд бараг л ийм хуулийн цоорхойг ашиглаж ийм юм хийж байна. Бараг энэ нефть импортолж оруулж ирдэг бүх газрууд бараг хийж байгаа юм шиг иймэрхүү ойлголт өгөхөөр иймэрхүү юм танилцуулга дээр бичигдсэн байна. Энэ дээрээ та хариулт өгөөч ээ гэж нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, энэ хуурамч үйлдвэрлэсэн шатахуунууд мэдээж шатахуун зардаг аж ахуйн нэгжүүдээр дамжиж зарж байж тэр хэрэглэгчдийн портер машин гэх мэтчилэн тоног төхөөрөмжүүд эвдрэх асуудал үүсэж байгаа.

Тэгэхээр колонкийн шахаж байгаа тэр бензинүүд дээр, шахаж байгаа тэр нефть дээр, түлш дээр ямар нэгэн төрийн хяналт байдаггүй юм байна даа гэдэг нь эндээс таны танилцуулгаас харагдаад байна л даа. Үүнийг бид яах юм бэ гэдэг ийм асуудал эндээс ургаж гарч ирж байна. Энэ дээр та хариулт өгөөч ээ. Салбарын яаманд нь эсвэл үүрэг даалгавар өгсөн Их Хурлын тогтоол давхар гарах ёстой юм уу гэсэн ийм байр байдалтай би бодоод сууж байна.

Мөн энэ одоо газрын тосны дайвар бүтээгдэхүүн гээд энэ дотроо керосин, хийн конденсацын нэрмэл дестилет, хөнгөн фракцын бензин, нафта гэх мэтчилэн гээд оруулаад өгчихсөн байна л даа.

Эдгээрийг ашиглаж үйл ажиллагаа явуулдаг, магадгүй цэвэрлэгээ үйлчилгээ хийдэг гэж зарим газрууд нь эдгээр бүтээгдэхүүнийг ашиглаж цэвэрлэгээ үйлчилгээ хийдэг гэж сонсож байсан.

Тэдгээр аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулж байгаа нөхдүүд дээр энэ татвар нэмэгдсэнтэй холбоотой тэд нарын үйл ажиллагаанд ямар хэмжээний зардал бий болох юм бэ? Өртөг бий болох юм бэ? Эргээд иргэдэд ямар хэмжээний эдийн засгийн хувьд нь дахиад эргэж нөлөө үзүүлэх юм болов уу? Энэ тал дээр танай судалсан судалгаа байгаа болов уу гэж.

Эцэст нь дөрөвдүгээрт нь газрын тосны үйлдвэрийг бид өндөр өртөгтэй барьж байгаа. Энэ шинээр барьж байгаа газрын тосыг үйлдвэрлэхэд энэ газрын тосны дайвар бүтээгдэхүүнээс орцод нь ордог бүтээгдэхүүнүүд байдаг юм болов уу? Хэрвээ орцод нь ордог бүтээгдэхүүн дээр одоо бид ингээд татвар тавьчихаар нөгөө зээл авч байсан газрын тосны үйлдвэрлэлийн өөрийнх нь ТЭЗҮ-д нь өөрчлөлт гарч таарна. Ашгаа нөхөх, зээлээ төлөх энэ тэр гээд асуудлууд үүсэж таарна. Энэ дээр нь ямар ч тооцоо судалгаа байдаг юм бол гэсэн ийм дөрвөн асуултыг асууя. Баярлалаа.

Х.Ганхуяг: Б.Пүрэвдорж гишүүн хариулах уу? 5 номер.

Б.Пүрэвдорж: Сүүлээс нь эхлээд хариулъя.

Тэгэхээр ер нь газрын тосны үйлдвэр тодорхой хэмжээгээр яг энэ шатахуун үйлдвэрлэхэд тодорхой хольцууд манай улсад байхгүй.

Тийм учраас тодорхой хольцууд орж ирнэ. Энэ тохиолдолд тусгайлан арга хэмжээ авах ийм боломжтой.

Хоёрдугаарт, нь яг энэ хууль дээр бид одоо хэлэлцүүлгийн явцад тодорхой хэмжээгээр одоо жишээ нь юу гэдэг юм гаалийн мэдээгээр бол сүүлийн 4, 5 жилийн гаалийн мэдээгээр бол ганцхан “Эрдмин” гэж компани л оруулж ирсэн байгаад байна л даа. Тэр нь болохоор нөгөө зэс боловсруулах тэр үйлдвэртээ хэрэгтэй тэр зүйлийг л оруулсан байна. Бусад ямарваа нэгэн компаниуд оруулж ирээгүй байгаад байна шүү дээ. Зөвхөн тэр нөгөө хольц хийдэг компаниуд л оруулж ирж байна.

Тийм учраас яг энэ дотоодын, ялангуяа үйлдвэрлэлд, өөрөөр хэлбэл бусад үйлдвэрлэлд, шатахуунаас бусад үйлдвэрлэлд хэрэгтэй байгаа тэр бүтээгдэхүүнүүдийг яг энэ хууль дотроо бас квот олгох замаар ч юм уу татвараас нь чөлөөлөх ийм боломж хэлэлцүүлгийн явцад байж болно. Тэр нь тэгэхдээ нөгөө компани нь ороод замбараагүй оруулж ирэхээргүй зохицуулалтыг хийж болно гэж хэлмээр байна.

Тооцоолол дээр жоохон алдаа гарсан байна. Миний өөрт байгаа юугаар бол 45 хувийг нь импортын худал худалдан авалт, 31 хувийг нь. Одоо бол 28 болчихсон юм байна. Яагаад гэвэл онцгой татвар шатахуун дээр ер нь бол чөлөөлөгдчихсөн байж байгаа. Засгийн газрын шийдвэрээр. Тэгээд 28 хувь болсон байгаа.

Тэгэхээр ер нь бол энэ үүнийг та бүхэн бас танилцуулгыг бас засаж өгье.

Гурав дахь асуулт нь юу билээ. Тэрийг нь би сая хэлчихлээ.

Х.Ганхуяг: Шахаж байгаа бензин дээр хяналт алга байна. Шатахуун түгээх станцуудаар гэж. Байхгүй байгаа юм уу? Стандарт байхгүй байгаа юм уу? Б.Пүрэвдорж гишүүний микрофон өгье.

Б.Пүрэвдорж: Ялангуяа хувийн компаниуд, томоохон уул уурхайн компаниуд маш чанартай шатахууныг авч шат техникүүдээ хамгаалах ийм зорилготой учраас энэ компанийн шатахуунуудыг ерөөсөө авдаггүй. Ихэнх төрийн өмчийн компаниуд авч байна.

Төрийн өмчийн их олон байгууллагууд дарга нар нь тэр хямдхан шатахуун аваад тэрнийхээ зөрүү гаргах замаар энэ хувийн эрх ашгаас хандаж компанийн хуурамч шатахууныг худалдаж авах, өөгшүүлэх ийм зүйлүүдийг бас маш их хийж байгаа.

Дээрээс нь хөдөө орон нутагт хянан шалгах боломжгүй тэр газруудад энэ хуурамч шатахуун маш их түгээгдэж ард иргэд машин тэргээ эвдүүлж байгаа гэдгийг хэлье.

Тийм учраас. Би түрүүн хэлсэн шүү дээ. Өөрөөр хэлбэл энэ хяналт шалгалтын бүх шатад, хууль хяналтын бүх шат.../минут дуусав/

Х.Ганхуяг: Д.Батбаяр гишүүний микрофон өгье. Байж байгаарай. Б.Заяабал гишүүн тодруулах байсан уу? Д.Батбаяр гишүүний микрофон өгье. Д.Батбаяр гишүүнийг нэмээрэй.

Д.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Нөгөө хуурамч шатахуун үйлдвэрлэж байгаа гээд хуурамч шатахууны чанар, орж ирж байгаа шатахуун хоёрын ялгаа эрс өөр байгаа юу? Тэгээд үүнийг худалдаж аваад, үүнийг хэрэглэснээс болоод энэ машин, энэ техник гэмтжээ гэсэн дүгнэлтүүд гарсан уу гэсэн нэг ийм асуулт байгаад байгаа юм. Тэгээд тодруулчихъя.

Х.Ганхуяг: 5 номер.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Ж.Баясгалан гишүүн яг өөрийнхөө амьдрал дээр тохиолдсон зүйлээ сая ярилаа. Өөрөөр хэлбэл. Тийм.

Тэгэхээр ер нь яг ингээд дилер компани дээр нь очоод машинаа засуулах дээр зөвхөн тэр карбюраторыг нь жоохон янзлаад тэгээд болдог. Тэгээд буцаад танайхаас болсон уу, шатахууны компаниас болсон уу гэхээр айгаад бас юм хумаа хийж өгдөггүй ийм л байна л даа.

Тэгэхээр ер нь мэдээж та нарт нэг зүйлийг хэлэхэд яг тэр бензин шатахуунд орж байгаа тэр хольцууд л орж байгаа. Жишээ нь, керосин орох ёстой юу, орох ёстой. Нафта орох ёстой юу, орох ёстой. Түүний яг тэр хольцууд нь байна уу гэдэг бол тэрийгээ үзэхэд байгаа. Хамгийн гол нь тэр хольдог технологи нь ерөөсөө энэ чинь Европын наад талын улсуудаар хэрэгжээд, посткоммунист орнуудаар явж байгаад тэгээд дараа нь станы орнуудаар явж байгаа сүүлдээ Монголд орж ирээд л дуусаж байгаа юм. Энэ бизнес ерөөсөө хаагдаж байгаа байхгүй юу даа. Дэлхийн бусад орнууд бүгдээрээ үүнийг хэрэглэхээ больсон.

Тэгээд Монголд л одоо энэ хууль хяналт, дээрээс нь бүх зүйл нь задгай байгааг ашиглаж өнөөдрийг хүртэл энэ компаниуд энэ ажлаа хийж байгаа л гэж ойлгож болно.

Ер нь бол хэлэлцүүлгийн явцад 4 жилийн өмнө Багануурын уурхайн 40 машин хуурамч түлш шатахуун хэрэглэсний улмаас эвдэрчээ. Тус уурхайн том экскаваторын форсунк нь эвдэрлээ гэхэд 15 мянган доллароор 1-ийг нь засдаг л гэсэн ийм л жишээ.

Х.Ганхуяг: Д.Батбаяр гишүүн тодруулъя.

Д.Батбаяр: Мэргэжлийн хүн биш учраас сая хуулийн төсөл санаачилж байгаа гишүүний үгэн дээр л үндэслэж ярьж байна л даа.

Ер нь адилхан хэмжээний найрлага ордог. Хилийн наана юм уу, цаана байдаг л гэсэн асуудал юм байна шүү дээ. Технологи нь жоохон хуучирчихсан байгаа байна гэж ойлголоо.

Тэгээд би үүнийг юу гэж хараад байна гэхээр одоо энэ Беларуст ч байдаг юм уу, Чечень ч байдаг юм уу баахан шүү дээ нефть боловсруулах үйлдвэрүүд гудамжаараа шахуу байж байдаг. Холбоо байгуулчихсан. Тэгээд дундаасаа илүү их хэмжээгээр нь оруулж ирдэг байхгүй юу. Нэг ёсондоо бас ахиад үйлдвэр гэсэн үг.

Тэгэхээр зүгээр миний бодол шүү. Үнэхээр хямдхан тийм том түүхий эд орох боломжтой байгаа юм болбол тэгвэл яг энэ боловсруулах технологи дээр нь илүү хяналт шалгалтыг нь тавиад тэгвэл өөрсдөө үйлдвэрлэг л дээ. Үнэхээр тийм чанартай бүтээгдэхүүн гаргах тал дээр нь л анхааръя л даа.

Ажлын байр бий болоод, үйлдвэр бий болоод, энд нь үйлдвэрлэж байх юм бол сайн шүү дээ. Яагаад хорино гэж?

Х.Ганхуяг: Гишүүд хуулийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Сая асуулт байсан юм. Д.Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа.

Д.Жаргалсайхан гишүүний микрофоныг өгье. Ирцээр юм уу? Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Үүрийнтуяа: Их л сонин дүр зураг харагдаад байгаа юм. Яг энэ ярьж байгаа асуудал, хөндөж байгаа сэдвийг бүрэн дэмжиж байгаа.

Хуурамч шатахууныг хязгаарлах, хуурамч шатахууны хэрэглээг зах зээлээс гаргах, үйлдвэрлэлд хяналт тавих, хариуцлага тооцох механизм зайлшгүй хэрэгтэй.

Гэхдээ энэ нь өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гараад Улсын Их Хурал түүнийг хүлээгээд аваад хүчингүй болгосон хуулийг дахиж оруулж ирж байгаагаар шийдэгдэх үү, үгүй юу гэдэг л асуудал байна. Эрх зүйн хувьд, зохицуулалтын хувьд энд бид бас зөрүүтэй буруу зөрүү зүйл гаргах вий гэдэг болгоомжлол миний хувьд байна.

Тэгэхээр Байнгын хорооны даргад нэг хүсэлт байна. Их Хурлын тухай хуулийн 22.3.9-ийн дагуу Байнгын хороо хууль зүйн дүгнэлт гаргуулах эрхтэй.

Тэгэхээр яг энэ асуудал дээр эрх зүйн талаасаа хүчингүй болгосон Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргаад, түүнийг Улсын Их Хурлын тогтоолоор хүлээж аваад Улсын Их Хурал шийдвэрийг гаргаад хүчингүй болгосон яг тэр агуулгаар нь орж ирж байгаа энэ баримт бичгийг бид хэлэлцэх боломж байна уу, үгүй юу. Хууль зүйн гаргалгааныхаа хувьд. Манай Байнгын хороо хэлэлцэх эрхтэй юу, үгүй юу гэдэг дээрээ.

Энэ нь өөрөө ямар нэгэн хууль зөрчиж байна уу, үгүй юу гэдэг дээрээ эхний ээлжид дүгнэлт гаргуулах ёстой гэж үзэж байна. Энэ хэрвээ хуулийн зөрчил байхгүй, боломжтой гэж үзвэл харин бид үүнийг цааш нь үргэлжлүүлээд явах нь зөв гэж миний хувьд харж байна.

Тийм учраас энэ зарчмын байр суурь дээр Байнгын хорооны гишүүд дээр санал хураалгаж өгөөч ээ гэсэн хүсэлтэй байна.

Х.Ганхуяг: Д.Үүрийнтуяа гишүүн санал хэллээ гэж би ойлголоо. Зөвлөмж гаргуулъя гэдэг дээр. Тийм үү? Тийм горимын саналаар санал хураалт явуулж болно.

Яах вэ, ер нь таны хажууд сууж байгаа хүн сая Ж.Алдаржавхлан гишүүний хэлдгээр жоохон ажилсаг л байх ёстой л байсан байна л даа. Энэ чинь яг буцаагаад л зөрүүлээд л нөгөө юмаа 100 хувь агуулгаар нь оруулаад ирчхэж байгаа байхгүй юу.

Горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

Хуулийн зөвлөмж, дүгнэлт гаргуулъя гэдэг дээр. Ер нь гишүүн горимын санал гаргаж болно.

Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3.9-д зааснаар хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн болон бусад төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулах эрхтэй байгаа юм.

Тэгэхээр бид хуулиа дагахаас өөр аргагүй шүү дээ. Б.Пүрэвдорж гишүүн ээ.

Тэгэхээр бид нэгдүгээрт хуулийн зөвлөмжийг нь гаргуулъя. Зөвлөмжөө гаргуулчхаад тэрнийх нь дагуу хэлэлцээд явах нь зөв байх. Энэ чинь цэц дээр унаад, Их Хурал хүлээгээд авчихсан. Тэгээд орж ирэхдээ буцаагаад л яг 100 хувь тэр агуулгаар ороод ирчхэж байгаа байхгүй юу. Үүнийг л гишүүд яриад байна шүү дээ. Нээлттэй хэвээрээ. Тэгэхдээ энэ чинь асуудал нь гишүүн энд санал гаргах эрхтэй хэвээрээ л байгаа. Хуулиараа. Процессын хуулиараа.

Хуулийн зөвлөмж гаргуулъя гэдэг санал гаргасан байна. Д.Үүрийнтуяа гишүүн. Н.Алтанхуяг гишүүн горимын санал гаргах юм байна.

Н.Алтанхуяг: Энэ одоо Их Хурлын гишүүн ингээд хууль санаачлахаар Тамгын газар ямар юм хийнэ гэнэ вэ, нэг юм хийгээд.

Би тэр Эрдэнэтийн нөгөө овоолгын асуудлаар нэг ийм юм яасан чинь. Т.Аубакир даргалж байсан шүү дээ. Тэгсэн чинь энэ хардаа, Их Хурлын гишүүд бид нарын эрхэнд ингээд Тамгын газар халдаж болохгүй байхгүй юу.

Тамгын газраар дүгнэлт гаргуулаад. Миний тогтоолыг юу гэсэн гээч. Энэ Н.Алтанхуяг хувийн өмчид халдаж, Үндсэн хууль зөрчиж байна гэж солиорсон. Энэ ингэж болохгүй шүү дээ. Энэ хүний саналыг хуулийнх нь төслийг дэмжих үү, үгүй юу гэдгээ санал хураагаад л шийдчихье. Тэгээд л болоо шүү дээ. Юу яасан Тамгын даргын, Тамгын түшмэлүүд яахаараа бид нарын эрхэнд халдаж байдаг юм.

Х.Ганхуяг: Энэ бол яах вэ, дүгнэлт биш ээ. Энэ чинь зөвлөмж гэж байгаа юм. Д.Үүрийнтуяа гишүүн саналаа тайлбарлачих.

Д.Үүрийнтуяа: 22.3.9 дээр зөвлөмж гаргахаар заасан байгаа юм.

Тэгээд яах вэ өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа Улсын Их Хурлын тухай хуулийн заалтын дагуу л Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд санал гаргаж байгаа юм. Горимын санал гаргаж байгаа юм.

Тэгэхээр мэдээж миний горимын саналыг дэмжиж болно, дэмжихгүй байж болно. Саналаа хураагаад үүнийхээ хүрээнд цааш нь үргэлжлүүлэх эсэхээ шийдээд өгөөч ээ л гэдэг хүсэлт.

Х.Ганхуяг: Энэ чинь зөвлөмж байхгүй юу даа. Н.Алтанхуяг дарга аа. Тийм.

Тэгэхээр зөвлөмжийг нь гаргуулъя гэдэг саналыг Д.Үүрийнтуяа гишүүн гаргаж байна. Гишүүд дэмжихгүй бол хэлэлцүүлгээ үргэлжлүүлээд тэгээд саналаа хураагаад л шийдчихье л гэдэг л асуудал байхгүй юу. Д.Үүрийнтуяа гишүүн санал гаргах эрхтэй.

Ц.Даваасүрэн даргын микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, гишүүд ээ, энэ чинь ийм шүү дээ. Энэ чинь зөвлөмж гэж байгаа юм. Тийм үү. Гэтэл хууль өргөн барихад хүлээж авах уу, үгүй юу гэдгээр чинь угаасаа Тамгын газар дээр юм явчхаж байгаа шүү дээ. Тэр үед л үзэх ёстой байхгүй юу.

Түүнээс биш нэгэнт ингээд Их Хурал хүлээн авчхаад, өргөн барьчхаад хэлэлцэж байгаа үед зөвлөмж гаргана гэдэг ялангуяа тэр дүгнэлт бол бүр байж болохгүй. Хууль дээр тайлбар өгч ерөөсөө болохгүй. Тамгын газар шүү дээ.

Энэ чинь бид зүгээр туслах аппарат, зөвлөх аппарат л байхгүй юу. Түүнээс болно, болохгүй гэж бол ерөөсөө болохгүй. Зүгээр яах вэ ийм хууль зүйн алдаа байна гээд зөвлөмж гэдэг талаасаа ярих юм бол уг нь байна шүү дээ энэ буруу л гэж үзсэн юм бол тэр хууль өргөн барьж байх үед нь хэлэлцэх үү, үгүй юу, Байнгын хороо руу шилжих үү, үгүй юу гээд л ингээд л шийдээд явах байдаг шүү дээ.

Х.Ганхуяг: Ц.Даваасүрэн дарга аа, юу шүү. Тамгын газар бол бүрдүүлбэр хангасан байна уу, үгүй юу гэдгийг л харж байгаа. Одоо хууль өргөн барьж байхад.

Яах вэ, одоо би Д.Үүрийнтуяа гишүүнийг энэ санал гаргачихаар чинь би санал гаргах эрхгүй ээ гэж би бол хэлэх эрх байхгүй шүү дээ. Тэгээд тэр саналаар нь цөмөөрөө саналаа хураагаад л дэмжигдвэл тэгээд л дэмжигдээд, дэмжигдэхгүй бол хэлэлцүүлгээ үргэлжлүүлээд л явна шүү дээ. Тийм.

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалт. Д.Үүрийнтуяа гишүүний гаргасан горимын саналаар Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3.9-өөр хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулах дээр Д.Үүрийнтуяа гишүүний гаргасан санал дээр санал хураалт явуулъя. Гаргуулах нь зүйтэй гэснээр санал хураалт явуулна.

Д.Үүрийнтуяа гишүүний горимын санал дэмжигдсэнгүй.

Хэлэлцүүлгийг цааш үргэлжлүүлээд явъя. Дараагийн гишүүн хэн байлаа?
П.Ганзориг гишүүний микрофоныг өгье.

П.Ганзориг: Хуулийн төслийг агуулгын хувьд дэмжиж байгаа. Олон жил олон нийтийн эрх ашгийг зөрчиж ирсэн асуудлыг хамгаалах зорилгоор гаргаж байгаа.

Тэгэхдээ хэд хэдэн анхаарах зүйлүүд байна. Хэлэлцүүлгийн явцад анхаарахгүй бол. Тухайлбал, түрүүн гишүүд нэлээн дурдаж байна. Засгийн газар энэ хуулийн төсөл дээр татгалзсан санал өгсөн байна лээ. Тэгээд энэ дээрээ гол агуулга тэр газрын тосны үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүнийг онцгой татвар ногдуулахаар дотоодын бүтээгдэхүүний чинь өртөг өсөх гээд байна гээд.

Тэгэхээр үүний тэр гарц, гаргалгаа, шийдлийг тодорхой давхар ярьж танилцуулж явахгүй бол, танилцуулга дээрээ мэдээллээ өгч явахгүй бол энэ маань их буруу ойлголт төрүүлэхээр ийм асуудал явж байна.

Хоёрт, ер нь одоо хэрэглэж байгаа энэ керосиныг тэр бусад салбаруудад ямар сөрөг нөлөө үзүүлж байгаа. Ирээдүйд ямар нөлөө үзүүлэх вэ? Ойрын ядаж 5, 10 жил. Өөр шинэ салбарт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнд хэрэглэгдэх ийм нөхцөл бүрддэг. Гэтэл одоо бид энэ дээр нь онцгой албан татвар тавиад хаядаг.

Тэгэхээр үүний судалгааг тодорхой тайлбарлах хэрэгтэй байна.

Гуравт, ер нь энэ онцгой албан татвар тавьснаар хуурамч шатахууны асуудлыг бүрэн шийдэгдэх үү гэдэг бас эргэлзээтэй. Өөрөөр хэлбэл энэ бүтээгдэхүүний чинь нэр төрөл байдаг юм уу даа, орц найрлага ч байдаг юм уу өөрчлөгдөөд ингээд дахиад өөр төрлийн орц найрлагатайгаар хуурамч шатахуунууд энэ бензин түгээх газруудаар гараад явахыг үгүйсгэхгүй.

Тэгэхээр энэ дээр яаж хяналт тавих юм бэ? Ер нь гол үндсэн энэ хуурамч шатахуун, чанаргүй шатахуун гаргаж байгаа, түгээж байгаа байгууллагууд дээрээ хариуцлагын асуудлаа, хяналтын асуудлаа шийдэхгүйгээр зөвхөн нэг төрлийн бүтээгдэхүүн дээр ингэж тавиад бүрэн шийдэгдэхгүй байх гэсэн ийм зүйл харагдаж байна.

Тэгэхээр үүнийг бас давхар хяналт хариуцлагын асуудлыг нь шийдэж явахгүй бол дахиад л өөр төрлийн бүтээгдэхүүнээр орлуулаад хуурамч шатахуун, хямд шатахуун, чанаргүй шатахуун гаргаад байх ийм эрсдэлүүд байна. Тэгээд энэ хэдийг бас анхаарч ажиллаарай гэж хүсье. Баярлалаа.

Х.Ганхуяг: Д.Жаргалсайхан гишүүн үг хэлье.

Д.Жаргалсайхан. Ядарсан иргэд бензин, түлш аж ахуйн нэгжүүд бүхий л юун дээр татвар төлөөд хэрэглээгээ авч байна шүү дээ. Гэтэл хажуугаар нь одоо ингээд ийм татваргүй дайвар бүтээгдэхүүн оруулж ирээд холиод тэгээд ард иргэдийн ядарсан дээр нь бас нэг нэрмээс болж байгаа учраас энэ хуулийг хэлэлцэх нь зөв өө. Дэмжиж байна. Тийм.

Тэгэхдээ энэ бас агуулга дээр холих гэдэг чинь ашгийн нэг асуудал байна. Цаана нь энэ чинь хүний эд хөрөнгө, асар их зүйл бол хохироод байна шүү дээ. Энэ дээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт оруулж болдоггүй юм уу. Энэ саналыг манай ажлын хэсэг аваач ээ. Энэ чинь цаанаа хүний л өмч хөрөнгөд халдаад байна шүү дээ, эвдээд сүйтгээд байна шүү дээ, хохирол учруулаад байна шүү дээ. Тийм. Үүнийг яаж хязгаарлах юм. Энэ тал дээрээ санал оруулж байна. Тийм. Баярлалаа.

Х.Ганхуяг: Санал хэллээ. Ж.Батсуурь гишүүн үг хэлье гэсэн үү? Ж.Батсуурь гишүүн үг хэлье.

Ж.Батсуурь: Энэ хуулийг дэмжээд явах нь зөв өө. Яагаад вэ гэхээр үүний хор хохирлыг монголчууд, ялангуяа хөдөөд асар их үүрч байгаа юм.

Тэгээд үүнийг олон жил хэлж яриад дийлэхгүй байгаа. Б.Пүрэвдорж гишүүн бид хоёр энэ талаар жагсаал хийсний төлөө Үндсэн хуулийн цэц бид хоёрын эрхийг түдгэлзүүлнэ гэж Их Хуралд санал тавьж байсан шүү дээ.

Тэгэхээр энэ хэмжээний мафи Монголын төр бүх шатад байгаа. Дуугарсан хүнийг нь намнадаг, дуугарсан Их Хурлын гишүүнийг эрхийг нь түдгэлзүүлнэ гэж бид хоёр дээр хэрэг үүсгэнэ гэж Үндсэн хуулийн цэцээс бүр бичиг ирсэн. Одоо ч бид нарт хадгалаатай байж байгаа.

Тэгээд улс төрийн нөхцөл байдлаас болж өөрчлөгдсөн. Одоо харин Б.Пүрэвдорж гишүүний хэлж байгаагаар энэ асуудал илаарьшиж, одоо энэ хууль цаашаа явах боломжтой болж байгаа гэж харж байгаа. Нийгэм мэдэж байгаа шүү дээ. Хэн хэн ард нь байсан, хэн хэн Үндсэн хуулийн цэц дээр тэрийг таглаж байсан. Дуугарсан хүн байтугай дуугарсан Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх хэмжээнд Монголын төрийг базаж байсан ийм нөхцөлүүд үүсэж байсан.

Тийм учраас би энэ хуулийг хойш тавихгүйгээр Их Хурал руу оруулж, ядаж олон нийттэйгээ хамтарч Байнгын хороогоор хэлэлцээд явах нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Ямар ч болтугай зөвлөмж энэ тэр гаргаж болохгүй. Ер нь горимын санал чинь бас утгатай байх ёстой шүү дээ. 126 гишүүний хоорондоо ярилцаад зөвшилцөөд гарах шийдвэрийг горимын саналаар дүгнэлт гаргуулна гэх юм бол байнгын ажиллагаатай парламент байх хэрэг юу байгаа юм. Хууль ер нь батлах

хэрэг юу байгаа юм. Шууд горимын санал гаргаж ирээд Тамгын газраар дүгнэлт гаргуулаад, гаргуулаад л явчихна байна шүү дээ энэ чинь.

Тийм учраас энэ хуулийг хойш нь тавилгүйгээр. Олон ч удаа маш их хэцүү даваа давж орж ирсэн. Тэгээд үүнийг нь манай Байнгын хороо бас тэр хүмүүсийн гар хөл болж байгаа юм шиг харагдаж хойш тавина гэдэг үнэхээр увайгүй зүйл болно.

Үгүй ээ, энэ “хүрээний бузрыг ухвал далай, далай” гэдэг шиг үүний хохирлыг ард түмэн зүгээр хэдэн зуун тэрбум, их наядаар нь амсаж байгаа шүү дээ.

Өнөөдөр хөдөөгийн сумдын колонк дээр очоод тэр халууны шил шиг юмаар бензиний октаныг үз дээ. 92-тоо хүрч байгаа, бензин авч байгаа хүн нэг ширхэг ч байхгүй. 95-даа хүрч байгаа, бензин авч байгаа хүн нэг ширхэг ч байхгүй.

Энэ нь хаана вэ гэхээр хилийн боомтууд, холын сумд, төвийн аймгууд. Одоо колонк чинь одоо нөгөө борооны дараагаас мөөг гэдэг шиг хуучин шиг нэг систем биш болчихсон. Нэг уулзвар дээрх гэрээ 5 колонк, 10 колонк байгаа. Тавууланг нь үзсэн ч, арвууланг нь үзсэн ч 92-тоо хүрч байгаа, бензин хэрэглэж байгаа хүн үндсэндээ байхгүй. Хөдөөд бол. 95-даа хүрч байгаа, бензин хэрэглэж байгаа хүн үндсэндээ байхгүй.

Тэгээд үүнийг нэгдүгээрт шатахууны үнийг нь нэмэгдүүлж нэг хохирно, хуурамч авч нэг хохирно, эд хөрөнгөөр нь хохирно. Тэгээд энэ бол маш олон жил олон удаа давтагдсан учраас үүнийг хойшлуулах боломжгүй.

Тийм учраас манай Байнгын хороо дэмжээд тэгээд ярилцаад эцсийн шийдвэр яаж гарах нь бол асуудал. Үндсэн хуулийг ер нь өөрчлөгдөж үү, үгүй юу бас нэг сорил тавиад үзчихье л дээ.

Х.Ганхуяг: Ж.Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Энэ хуулийг Улсын Их Хурлаар батлахад дэмжсэн юм. Тухайн үед дэмжиж байсан. Тэгээд цэц дээр асуудал үүсээд, цэцийн дүгнэлтээ Их Хурал хүлээгээд авчихсан юм.

Тэгэхээр эрх зүйн хувьдаа бодох ёстой юм байгаад байгаа юм. Ний нуугүй үнэнийг хэлэхэд. Энд хууль үйлчилдэг биш гэдэг зарчим барьж болохгүй л дээ. Бид. Яах аргагүй Үндсэн хуультай эрх зүйт төрийг төлөвшүүлж явж байгаа бол хууль дээдэлдэг зарчмаа барих ёстой. Цэц тухайлсан асуудлаар тодорхой шийдвэр гаргасан бол дахиад яг тэр агуулга өнгөөр нь бид асуудлыг шийдэх боломжгүй байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр нь эрх зүйн зөвлөмж авъя л гэдэг асуудал сая яригдлаа шүү дээ. Энд буруу юм байхгүй. Үүнийг хэлэлцүүлгийн явцад авах ёстой. Ер нь. Авах ёстой. Үүн дээр тодорхой шийдлээ гаргуулж авах ёстой гэж.

Хоёр дахь зүйл. Хэлэлцүүлгийн түвшинд анхаарах ёстой. Энэ ер нь улс ардын аж ахуйн бусад салбаруудад юу юунд энэ бүтээгдэхүүнүүд дангаараа ашиглагддаг юм гэдэг юмыг тооцож, түүний хэрэглээ юмнуудыг нэг гаргаж ирэх ёстой.

Тэр 1.7 тэрбум доллароор баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн жилийн хүчин чадлыг нь бүтэн ашиглахад энэ дайвар бүтээгдэхүүнүүд хэдий хэмжээгээр орж ирж байж сая тодорхой бүтээгдэхүүн болох юм бэ гэдэг судалгаа юмаа нарийсгаж үзэх ёстой. Энэ бүх юмнууд дээрээ дүгнэлтээ хийж хэлэлцүүлгийнхээ түвшинд илүү боловсронгуй болгож шийдлээ гаргах нь зөв байх. Ямар ч байсан эхний ээлжид үүнийг хэлэлцэх эсэхийг нь бол дэмжье. Тэгээд хэлэлцүүлгийн түвшинд нь энэ дутуу дулимаг зүйлүүдээ нарийсгаж гаргаж ирэх ёстой.

Чуулганы хуралдаан дээр зүгээр тэрэг эвдээд байгаа гээд яриад сууж болохгүй л дээ. Үүнийг эрх зүйн талаас нь ч тэр, цаад нөлөөллийн үнэлгээ талаасаа ч тэр, бүх юмнуудаа Б.Пүрэвдорж төсөл өргөн баригч тодорхой болгож хэдүүлээ ярихгүй бол бас арай боломгүй.

Тийм учраас Та тийм ажил руугаа наад баг бүрэлдэхүүнээ ажилд нь оруулсан нь дээр байх. Би энэ талаас нь дуугармаар байна.

Х.Ганхуяг: Одоо саналаа хураая. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтдаа бэлдье. Гишүүд ээ. Ж.Батсуурь гишүүн ороогүй байна шүү. Ж.Батсуурь гишүүн ороогүй байна. Да.Цогтбаатар байсан уу? Байхгүй байна. Х.Болормаа байхгүй байна. Ж.Батсуурь орсон уу? Одоо бол харагдахгүй байна шүү. Орчихлоо.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

87.0 хувиар дэмжсэн тул Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар танилцуулна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

**Гурав. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай
холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын
хэрэгжилтийн талаарх
Сангийн сайдын мэдээллийг сонсох**

Гурав. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсоно.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Сангийн яам Ж.Ганбат Төрийн нарийн бичгийн дарга, С.Батболд Зам, тээврийн яам Төрийн нарийн бичгийн дарга. Р.Батболд ирсэн юм уу? Ирээгүй юм байна. Тийм ээ. Ш.Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Б.Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, М.Санжаадорж, Сангийн яам Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ж.Энхтөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга. Ж.Энхтөр дарга байна уу? Г.Батбаяр Зам, тээврийн яам Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Л.Мөнхцэцэг Эрүүл мэндийн яам Санхүү, даатгалын хэлтсийн дарга, Н.Хүрэлбаатар Эрүүл мэндийн яам Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Б.Отгонбаатар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар Бодлого, зохицуулалтын газрын дарга, Ц.Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, В.Дарханбаатар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Удирдлага, төлөөллийн албаны дарга, Х.Өлзий-Орших Эрүүл мэндийн яам Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч, С.Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК захирал.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Төсвийн байнгын хороон дарга, эрхэм гишүүдийн өдрийн мэндийг хүргэе.

Мөн энд хүрэлцэн ирсэн Засгийн газрын гишүүд, төрийн албан хаагч нартаа мөн өдрийн мэндийг хүргэе.

2024 онд 2025 оны төсөв хэлэлцэж байгаатай зэрэгцээд өнөөдрийн бид нарын Та бүхэнд танилцуулах гэж байгаа асуудлууд хөндөгдсөн байдаг.

Ингээд төсөв батлагдаад дагасан хоёр ч тогтоол гарсан. 52, 54 гээд. Эдгээр тогтоолоор өгсөн үүргийн дагуу хавар тайлангаа Улсын Их Хурал, холбогдох Байнгын хороодод хүргэсэн байгаа.

Ингээд өнөөдөр тайланг хэлэлцэх боломж олгож байгаад баярлалаа.

Ингээд танилцуулгыг Та бүхэнд хүргэе.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас 2024 оны 54 дүгээр тогтоолоор Засгийн газарт 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулаад зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасан.

Тус тогтоолд тусгагдсан Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг танилцуулж байна.

▷ **Нэгдүгээрт,** төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 2025 оны төсвийн тодотголоор Монгол Улсын хөгжлийн 2026 оны төсвийн төлөвлөгөөнд заасны дагуу багш, эмчээс бусад төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд орон тооны хязгаарыг 2025 оны түвшинд хадгалах бодлогыг баримталж байна.

Миний танилцуулгатай зэрэгцээд энэ дэлгэцүүд дээр танилцуулга явж байгаа шүү. Та бүхэн бас тийшээ анхаараарай.

Мөн 2025 оны төсвийн тодотголоор яам, агентлагийн 135 удирдах албан тушаалтны орон тоог бууруулсан ба 2026 оны төсвийн төсөлд эдгээр орон тоотой холбоотой зардлыг хэмнэхээр тооцсон.

Энэхүү бодлогын арга хэмжээ нь төсвийн зардлыг хэмнэх, чиг үүргийн давхардлыг арилгах, байгууллагуудын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

▷ **Хоёрдугаарт**, Засгийн газрын тусгай сангуудын үр нөлөө, зориулалт, зохицуулалттай холбоотой арга хэмжээний хүрээнд Засгийн газрын нийт 27 тусгай сангийн одоогийн нөхцөл байдалд судалгаа хийж, улсын төсвөөс бүрэн санхүүждэг эргэлтийн бус шинж чанартай 6 тусгай санд 2026 онд төсөвт тусгалгүй төсвийн төслийг өргөн мэдүүлээд байна.

▷ **Гуравдугаарт**, гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбэ, зохицуулалтын хүрээнд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийг Улсын Их Хурлаас баталсан 2025 оны гадаад зээлийн ашиглалт болох 1.5 их наяд төгрөгт багтаан санхүүжүүлэх зорилгоор 29 төслийн 97 ажлыг хэсэгчлэн болон бүрэн хойшлуулах арга хэмжээг авч Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан мега төслүүд гэр хорооллын дэд бүтэц, авто зам барих бүтээн байгуулалтын төслүүдийн ашиглалтыг 173.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх зохицуулалтыг хийсэн.

Төрийн хэмнэлт, бүтээмжийг сайжруулах, гадаад зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд Засгийн газар 2025 оны 24 дүгээр тогтоолоор төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийг нэгтгэх шийдвэр гарсан.

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалтад шилжсэнээр удирдлагын болон урсгал зардал 40 гаруй хувиар буурахаар байна.

Гадаад зээл, тусламжийн төслүүдийн хяналт шинжилгээ, үнэлгээг сайжруулах зорилгоор төсөл, арга хэмжээний явцыг үнэлэх, эрэмбэлэх аргачлалыг боловсруулсан бөгөөд уг шалгуур үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах зохицуулалтыг холбогдох журамд тусгахаар ажиллаж байна.

Түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд гадаад зээл, тусламжийн болон бусад эх үүсвэрийг нэгтгэх, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх дэд системийг бүх салбарт үе шаттайгаар нэвтрүүлэх хөрөнгө оруулалтын их өгөгдөлд суурилсан мэдээллийн сан үүсгэж, уялдаа холбоотой, үр ашигтай хөрөнгө оруулалтын нэгдсэн платформ хөгжүүлэх ажлууд хийгдэж байна.

▷ **Дөрөвдүгээрт**, шинээр авах гадаад зээлийн чиглэл, гадаад зээлийн эдийн засгийн өсөлт түлхүү чиглүүлэх бодлогын хүрээнд Улсын Их Хурлын тогтоол батлагдсанаас хойш газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нэмэлт санхүүжилт болон “Эрчим хүч-3” төслүүдийн зээлийн хэлэлцээрүүдийг байгуулаад байна.

Энэтхэгийн ЭКЗИМ банкны санхүүжилтээр хэрэгжиж буй газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл нь импортын зардлыг 1 тэрбум ам.доллар хүртэл бууруулах, шинээр 1500 ажлын байр бий болгох бөгөөд говийн бүсэд аж

үйлдвэр, техник, технологийн шинэ төв бий болгох ач холбогдолтой бол Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих “Эрчим хүч-3” буюу Багануур, Чойр чиглэлийн дамжуулах шугам барих төсөл нь Дундговь, Дорноговь, Хэнтий, Өмнөговь, Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудын нийт 355 мянган хэрэглэгчдийг тогтвортой, чанартай, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах ач холбогдолтой төсөл юм.

Цаашид Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт багтсан боловсрол, эрүүл мэнд, онцгой байдлын салбарын төслүүд болон “Эрчим хүч-4” буюу Мандалговь, Арвайхээр чиглэлийн цахилгаан дамжуулах шугам барих төсөл зэрэг эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдсан томоохон дэд бүтцийн төслүүдийн зээлийн хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна.

Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийг бид дээрх чиглэлүүдээр ханган ажиллаж байна.

Төсөв, санхүүгийн сахилга хариуцлага, хөрөнгө оруулалтын уялдаа холбоо, гадаад зээлийн үр ашиг, бүтээмжийг ахиулах чиглэлээр бид цаашид тууштай ажиллах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Ганхуяг: Сангийн сайдад баярлалаа.

2025 оны 09 сарын 11-ний өдөр Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт Байнгын хорооны гишүүдэд энэ материалыг хүргүүлсэн байгаа шүү. Одоо энэ дэлгэрэнгүй байдлаар.

Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Б.Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Д.Үүрийнтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Үүрийнтуяа: Хэрэгжилт. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн тайлан сонсож байна гэж ойлгоод байгаа шүү дээ.

Тэгээд ирүүлсэн материал дээр ч тэр, танилцуулга дээр ч тэр хэрэгжилт гэвэл гүйцэтгэл, хуваарь гарах ёстой байх. Тийм ээ. Тэгээд энэ тайлагнаж байгаа хэлбэрүүд дээр ерөөсөө ямар ч хувь байхгүй.

Ер нь хэдэн хувийн биелэлттэй гэж ойлгох вэ?

Хэчнээн ажлуудыг даалгаад, хэдийг нь хэрэгжүүлээд, хэдэн хувийн биелэлттэй явж байгаа юм?

Хэрэгжихгүй байгаа ямар асуудлууд байгаа юм? Хэрэгжих боломжтой даалгавар өгсөн юм уу, боломжгүй даалгавар өгчихсөн юм уу? Хэрэгжих боломжгүй бол яагаад хэрэгжихгүй байгаа юм? Хувь хүнээс хамаараад байгаа юм уу? Тогтолцооноос хамаараад байгаа юм уу? Ийм л зүйлийг сонсмоор байх юм. Уг нь.

Тэгээд яг тийм тодорхой мэдээллийг өгөөч гэж хүсэх байна.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайдын микрофоныг өгье. 8 номерын микрофон өгье.

Ж.Ганбат: Бид Улсын Их Хурлаас өгсөн энэ 52, 54 дүгээр тогтоолын биелэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр нэгтгэгдээд албан ёсоор хүргүүлсэн байгаа.

Бид Улсын Их Хурлаас өгсөн 52, 54 дүгээр тогтоолыг батлагдсаных нь дараа Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бүх шатын төсвийн захирагч нарт холбогдох чиглэл чиглэлүүдээр арга хэмжээ авахаар хүргүүлсэн байгаа.

Биелэлт бол яг Сангийн яамтай хамаарах 4 заалт байгаа. Үүний хэрэгжилт 100 хувийн биелэлттэй хэрэгжсэн байгаа. Бусад яамд өөр өөрсдийнхөө хамаарах заалтууд дээр тайлбаруудаа өгөөд явах нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

Х.Ганхуяг: Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Үүрийнтуяа: Сангийн яамнаас гэхээр зөвхөн Б.Жавхлан сайдаас гэнгүүт Сангийн яамны мэдээлэл ороод ирэх шиг боллоо.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын ирүүлсэн албан бичгээр ирсэн энэ хэрэгжилтийн тайланг би Б.Жавхлан сайдыг танилцууллаа гэж ойлгосон.

Тэгэхээр яам болгоноос юм аваад нэгтгээд сонссон ч гэж байхгүй байх л даа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хэрвээ үүнийг албан ёсоор төлөөлж танилцуулж байгаа бол нэгтгэл дүнгээ танилцуулаач. Гүйцэтгэлийн дүнгээ.

Х.Ганхуяг: Асуулт асуусан уу? Хэн хариулах юм? 8 номер хариулах уу? Ж.Ганбат даргын микрофоныг өгье.

1 номер дээр хариулах юм уу? Хариулт өгч байгаа албан тушаалтан нэр, албан тушаалаа хэлж байж хариулт өгнө шүү.

Ш.Мөнхцэрэн: Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилт өмнөх бүтцээрээ Эдийн засаг, хөгжлийн яаманд харьяалагддаг. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар дээр нэгтгэгддэг байсан.

Одоо Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан хууль тогтоомжийн хэрэгжилт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр ирсэн.

Тэгэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнд хийсэн үнэлгээ нь эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас нэгтгэснээр явсан байгаа.

Одоо сүүлийн хагас жил 2025 оны хувьд сүүлийн хагас жилийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нэгтгэж Улсын Их Хуралд танилцуулахаар байгаа юм.

Улсын Их Хурлын 52, 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийг... /минут дуусав/

Х.Ганхуяг: Нэмээд 1 номерын микрофон.

Ш.Мөнхцэрэн: Энэ тогтоолын хэрэгжилтийг тусгайлан Их Хурал дээр сонсож байгаа учраас Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Засгийн газрын unelgee.gov.mn гэсэн системээс татаж Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байгаа.

Энэ дээр тусгайлан үнэлгээ хийгдээгүй. Хэрэгжилтийн явцыг unelgee.gov.mn гэсэн системээсээ татаж хүргүүлсэн байгаа.

Х.Ганхуяг: Нэмж тодруулах юм уу? Тийм. Асуулт, үг хоёр цуг юм байна шүү.

Д.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Үгүй ээ, одоо энэ чинь 09 сарын 11-ний өдөр ирсэн албан бичгийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын гарын үсэгтэй албан бичгийн дагуу өнөөдөр энэ мэдээллийг сонсож байгаа гэж ойлгоод байгаа юм.

Тэгээд хэрэгжилтийн тайланг хүргүүллээ гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр хэрэгжилт гаргаж л байгаа бол бид чинь хяналт-шинжилгээ, үнэлгээ, мониторинг хийх дүрэм, журам гээд бидэнд бий шүү дээ. Тэгээд хэрэгжилт л гаргаж байгаа бол хэдэн хувийн хэрэгжилттэй юм бэ гэдэг зүйлийг ярих ёстой биз дээ.

Тэгээд өнөөдөр хэдүүлээ зүгээр ийм тайлан сонсоод ямар үр дүн байгаа юм? Хэрэгжилт нь хэдэн хувьтай байгаа юм? Хэрэгжилт нь нөлөөлж байгаа хүчин зүйл нь юу байгаад байгаа юм? Он дуустал энэ хэрэгжих юм уу, хэрэгжихгүй юм уу? 2026 оны төсөв дээр үүнтэй холбоотой анхаарах юм байгаа юм уу, байхгүй юм уу? Ийм л зүйлийг ярих гэж би төсвийн өмнө энэ хэрэгжилтийн тайланг өнөөдөр Байнгын хороогоор сонсож байгаа байх гэж бодож байна.

Тэгээд энэ өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт аль нь биелээд, аль нь биелэхгүй байгаагаа ч бараг мэдэхгүй шахуу ийм... /минут дуусав/

Х.Ганхуяг: Болсон уу? Ж.Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгээд түрүүн асууж байсан асуултаа дахиад асууна.

Энэ гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслүүдийн талаар асуух гээд байна. Энд тогтоолын хэрэгжилт. Сая Д.Үүрийнтуяа гишүүний хэлсэнтэй санал нэг байна. Дүгнэлт нь байхгүй. Хэдэн хувьтай хэрэгжсэн нь байхгүй. Тэгээд тэрийг тогтоох аргагүй. Тэрийг тогтоогоогүй гэж байна.

Тэгэхээр гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа мега төслүүд. Түрүүн би Б.Жавхлан сайдаас бас асууж байсан. Одоо ч дахиад асууя.

Энэ дунд судалгаа хийсэн үү? Энэ төслүүдээс хамгийн амжилттай яваа нь юу юм бэ? Бас амжилтгүй яваа нь юу юм? Хамгийн хойш нь татаж байгаа нь юу юм? Өдөр болгон иргэдийн татварын мөнгөнөөс зээлийн хүү төлж байгаа энэ гадаадын үзэл, тусламжийн төслүүдээс хамгийн амжилтгүй яваа. Ер нь бид зогсоож болох тийм мега төсөл байгаа юу? Эсвэл хамгийн их амжилттай яваагаа бид дурдахгүй бол ингээд бөөрөнхийлөөд, аль нь ч үгүй хоцроод байна.

Тэгэхээр сайн явж байгаагаа сайнаар нь хэлье. Ор тас болохгүй байгаагаа хэлье.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн бүгдээрээ нэг хэлээдхээч. Түрүүн Сангийн сайдаас бас асуусан. Энэ дээр салбар болгон бас хэлээдхээрэй. Хамгийн амжилттай яваа төсөл нь юу юм? Бас ор тас фэйлдээд байгаа хамгийн амжилтгүй нь юу байна.

Х.Ганхуяг: Сангийн сайд хариулах уу? Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Ж.Баясгалан гишүүний асуултад хариулъя.

Одоогоор 96 төсөл явж байгаа юм. 13.6 их наядын төсөвт өртөгтэй. Жил болгон ингээд 1.5 их наядаар яваад байх юм бол 10 жил явах ийм зээлийн ашиглалт байна. Тэгэхдээ одоо зарим төслүүд нь хугацаанууд нь наана нь

дуусах ёстой. Үүрэг хүлээсэн. Олон улсын гэрээгээр үүрэг хүлээсэн ийм зүйлүүд олон байгаа.

Хамгийн амжилттай явж байгаа төсөл нь ерөөсөө яах аргагүй Мянганы сорилын корпорацтай хамтарч хэрэгжүүлж байгаа нийслэлийн цэвэр усны хангамжийг сайжруулах энэ төсөл байгаа юм. Маш амжилттай хэрэгжиж байгаа. Хойтон хугацаандаа ашиглалтад орно.

Хамгийн амжилтгүй явж байгаа нь. Юуны мөнгөн дүнг хэлээдэх дээ. Нийтдээ 460 сая долларын өртөгтэй 350 нь тусламж, 110 нь Монголын талын гаргах ийм хөрөнгийн санхүүжилттэй. Ер нь бас л мега төсөл юм байгаа юм шүү. 460 сая доллар гэдэг бол.

Нөгөө хамгийн муу явж байгаа нь одоо яах аргагүй энэ 10 аймгийн дулааны станц. Энэ Солонгосын ЭКСИМ банкаар явж байгаа. Захиалагчийн яам нь Эрчим хүчний яам байгаа.

Мянганы сорилын сан дээр энэ захиалагчийн яам нь Сангийн яам байгаа шүү. Би өөрийнхөө яамны төслийг бас ингээд байгаа зүйл биш шүү. Манайх шилж нэг жоохон гацаа үүссэн юм. Энэ төсөл дээр. Тэгээд юуны үеэр, ковидын үеэр манайх Гадаад яамнаас шилжүүлж авсан юм. Ингээд түүнээс хойш одоо ямар ч саадгүй яг хугацаандаа төсөл санхүүжилтүүдээ аваад маш сайн явж байгаа. Энэ жил Ерөнхийлөгч ч очсон Ерөнхий сайд ч очсон, Ерөнхий сайд ч очсон. Ер нь төслийн гүйцэтгэлд бол ер нь онц дунд тавьсан. Цаад талаас ч гэсэн маш сэтгэл хангалуун байгаа.

Сая Америкийн Нэгдсэн Улсын шинэ Ерөнхийлөгч томилогдсонтой холбогдуулаад Мянганы соёлын корпорацаас хэрэгжүүлж байгаа ялангуяа хөгжиж буй орнуудад хэрэгжүүлж байгаа бүх төслүүдээ зогсоосон.

Эндээс ерөөсөө хэдхэн төсөл авч үлдсэн. Тэрний нэг нь манай энэ төсөл байгаа.

Солонгосын ЭКСИМ банкны энэ 10 аймгийн цэвэрлэх байгууламж хамгийн амжилтгүй фэйлдчихээд байгаа төсөл. Нөгөө гүйцэтгэж байгаа 148 сая ам.долларын өртөгтэй. Захиалагчийн яам нь Эрчим хүчний яам. Гүйцэтгэгч компани нь Солонгосын талаас өөрсдөө тендер зарлаад сонгон шалгаруулалтаа хийгээд нэг Солонгосын компани шалгарсан боловч тэр компани нь дампуураад алга болсон. Дампуураад алга болсон. Бүр 25 сая долларын гүйцэтгэлээ ч гаргаж өгч чадахгүй алга болсон. Баталгаагаа Солонгосын нэг даатгалын компаниар гаргуулсан боловч нөгөө даатгалын компани нь даатгалын тохиолдол үүслээ... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд гүйцээгээд хариулъя.

Б.Жавхлан: Нөгөө баталгаа гаргасан Солонгосын даатгалын компани нь бүр үүнээсээ татгалзчихсан. Хохирлыг нь төлөхгүй гээд ингээд бүр шүүхдээд явж байгаа.

Одоо бид Солонгосын ЭКСИМ банктai харин хэлэлцээрт орж байгаа. Солонгосын талаас бол юу гэж байгаа вэ гэхээр танайх нэмээд зээл авчих. Ингээд гүйцээчихье гээд. Тэгээд бид бол үгүй ээ. Эхлээд манай Монгол Улсын төлсөн мөнгө, гаргасан мөнгө, ирээдүйд Монголын ард түмэн татвараараа төлөх энэ хохирлыг эхлээд барагдуулаадах. Тэрний дараа хэлэлцээрээ үргэлжлүүлнэ ээ гээд. Ингээд ийм байдалтай одоо үндсэндээ бараг гацчихсан байгаа.

Х.Ганхуяг: Р.Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Сангийн сайдын танилцуулгатай холбоотой нэг зүйл л асуух гэсэн юм. Бид мэдээж өөрсдийнхөө орлогоор бүх зүйлээ санхүүжүүлж чадахгүй байгаа учраас гаднын зээл, тусламжийг аваад төсөл, хөтөлбөрүүдүүдээ хэрэгжүүлээд явж байгаа.

Тэгэхээр энд хоёр асуудал хөндмөөр байгаа юм. Нэгдүгээрт, энэ зээлийн ашиглалт нь өөрөө зээлийн тэр хөрөнгөөр, санхүүжилтээр хийгдэж байгаа тэр төсөл хөтөлбөрүүдийн чинь өөрийнх нь өртөг нь дотоодын төсөвт өртгөөс өндөр байгаад байгаа юм биш үү. Энэ дээр ер нь та хэд ямархуу байдалтай ханддаг юм бэ? Одоо барилгын салбар дээр гэхэд л тийм зүйл ажиглагдаад байх юм. Одоо энэ Солонго 1, 2-оос эхлүүлээд л өртөг нь маш өндөр байгаад байдаг. Үүнийг ер нь Сангийн яам юу гэж харж байдаг юм бэ гэдэг нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. Одоо зээл олгож байгаа газрын саналаар гэдэг юм уу, хүсэлтээр ч гэдэг юм уу ерөнхий гүйцэтгэгчийг нь цаад талаасаа сонгохоос өөр аргагүй болдог гэдэг. Яах вэ тэрийг нь зөвшөөрч болж байна. Гэтэл эд нар чинь орж ирээд туслан гүйцэтгэгч аваад хэдэн Монгол компаниудыг чинь дарамталдгийг нь дарамтлаад ингээд овоо гайгүй ажилтайг нь унагаахыг нь унагаагаад мөнгө төгрөгөө төлдөггүй ийм асуудлууд гараад байдаг. Энэ шүүхээр явж байгаа асуудал ч байгаа. Энэ тал дээр Сангийн яаман дээр мэдээлэл байдаг юм уу? Та нар энэ дээрээ эргээд тэр Ерөнхий гүйцэтгэгчдээ ямар хариуцлага тооцох юм? Яаж явдаг юм гэдэг ийм хоёр асуудал л асууя.

Х.Ганхуяг: Сайд хариулах уу? Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Гадаад зээлээр санхүүжиж байгаа төслийг төсвийн биш төсвийн гадуур гэж хэлэх нь зохисгүй. Гадаад зээлийн ашиглалт. Энэ бол төсвийн нэг хэсэг нь. Ирээдүйд төсвөөс л төлнө. Татвар төлөгчдийн мөнгөөр л төлнө.

Харин ч гадаад зээлээр санхүүжиж байгаа төслүүд маань нэг, хоёр жил богино хугацаанд төсөв дээр ирэх дарамтаа 20-оос 25, 25-аас дээш жилүүдэд ачааллыг нь багасгаад хойш нь шидэж байгаа энэ бас зөв зохицуулалт. Ийм эх үүсвэрүүд олдохын хэрээр зөв төсөлдөө зарцуулаад байх юм бол эдийн засгийн хувьд өгөөж өндөр байх учиртай юм.

Тийм учраас гадаад зээлийн ашиглалт гэж бид өнөөдөр чухалчилж авч үзэж байгаа нь энэ. төсөвт өртгийн хувьд энэ төсөвт өртгийг хийдэг ерөөсөө дөрөвхөн институц байгаа. Монголд. Төсвийн байгууллага биш. Энэ гэрээт ийм аж ахуйн нэгжүүд байдаг. Аж ахуйн нэгж аж ахуйн тооцоон дээр ажилладаг ийм компаниуд байгаа. Институцүүд байгаа.

Зам тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв, Уул уурхайн яамны хажууд Эрдэмтдийн зөвлөл байдаг.

Төсөвт өртөгтэй холбоотой асуудал бол эд нарыг дуудаж асуусан нь зөв байх. Бид нарын хувьд үүнийг яаж ч чаддаггүй. Одоо бүр сүүлдээ бид аргаа бараад Үндэсний аудитын газар луу явуулдаг. Заримыг нь бүр хуулийн байгууллага руу шилжүүлбэ ч гэж бодож байгаа зүйлүүд байгаа.

Тэгэхээр энэ төсөвт өртөгтэй асуудлуудыг чиглэл чиглэлийн яамдуудаас нь байлгаж байгаад чиглэл чиглэлийн тэр үндэсний төвүүдийг тэр одоо яг эцсийн магадлал хийдэг экспертүүдийг нь суулгаж байгаад асуувал зүгээр байгаа юм.

Х.Ганхуяг дарга аа, Ер нь энэ төсөвт өртөгтэй холбоотой асуудлыг Төсвийн байнгын хороон дээр нэг ярилцаад, ялангуяа яг энэ 4 институцээс нь тэр төсөвт өртгийн нөгөө тусгай лицензтэй тэр экспертүүдийг авчирч байгаад, дарга нарыг нь авчирч байгаад яг сайд нартай нь цуг суулгаж байгаад үүнийг асуумаар байгаа юм шүү.

Энэ чинь ганцхан Сангийн яамны ажил биш байхгүй юу. Сангийн яамныхны ганц хүрч чаддаггүй, бид хянаж чаддаггүй ганц ажил бол ерөөсөө л энэ байдаг. Тийм. Ийм юм байгаа юм.

Тэгэхээр тэрийг одоо бага байна, их байна гэж бид хэлж чадахгүй. Бид ямар үүрэг хүлээдэг вэ гэхээр тэрийг төсөвт суулгах л үүрэг хүлээдэг. Бүр харанхуйгаар.

Тэгэхээр энэ нэг ийм учир дутагдалтай ийм юм байгаа юм шүү. Тэр туслан компаниуд авч ажиллаж байгаа ажлууд ч гэсэн энэ захиалагч яамны хяналт, стандартыг бариулах л ийм л ажил байгаа. Одоо жишээ нь Мянганы сорилын сангийн цэвэрлэх байгууламжийн асуудал байна. Үүнийг одоо жишээ нь захиалагчийн яам нь Сангийн яам учраас бид бүх асуудлыг нь хариуцна. Туслан компаниуд нь юу байна. Тийшээ хэдэн төгрөг яаж очих ёстой вэ? Тэд

нар нь үүргээ биелүүлж байна уу, үгүй юу. 100 хувь бид хариуцна. Сангийн яам хариуцна.

Тэр Улаанбаатар хотын тэр нэг бохир усны цэвэрлэх... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд гүйцээж хариулья.

Б.Жавхлан: Тэр бол одоо жишээ нь Хот байгуулалт, барилгын яамны төсөл байхгүй юу. Яам нь захиалагч нь. Цаашаагаа хяналт стандартаа тавих нь тус яам. Тэгээд бүх хариуцлагаа тэнд хүлээх ёстой.

Одоо энэ 10 аймгийн тэр дулааны төсөл байна. Эрчим хүчний яам 100 хувь хариуцлагаа хүлээх ёстой. Тэр ямар төслийн компаниуд ажиллаж байгааг бас давхар хяналтаа тавьж байх ёстой. Дотоодын компани бол эдний бас эрх ашгийг нь хамгаалж байх ёстой. Тийм.

Тэгэхээр яг захиалагчийн яамдууд дээр бүх мэдээллүүд нь байж байх ёстой.

Х.Ганхуяг: Тэр экспертүүдтэй холбоотой асуудал бол ер нь цөмөөрөө нэг Байнгын хороон дээр нэг ярилцахгүй бол бүр хэнд ч захирагдахгүй хэдэн улсууд байдаг юм билээ дээ.

Р.Батболд гишүүн тодруулья.

Р.Батболд: Манай Сангийн сайд маань ёстой яалт ч үгүй л зовлонгоо хэлэх шиг боллоо. Энэ ороод ирсэн төсвийг бид мөнгийг нь л хуваарилаад явахаас өөр арга байхгүй.

Тэгэхээр сайдын хэлж байгаагаар бид тэр одоо ёстой хариуцсан газруудыг нь, тэр хэдэн агентлагуудыг бүгдийг нь дуудаад энэ төсөвт өртгийг яаж тооцоод байгаа юм, яаж магадлан хийгээд байгаа юм. Энэ асуудлуудыг Төсвийн байнгын хороон дээр авч үзэж ярилцахгүй бол арай дэндүү замбараагүй юм яваад байна л гэж харагдаад байгаа юм.

Өөр асуулт алга даа.

Х.Ганхуяг: Б.Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Өдрийн амрыг айлтгая.

Тэгээд энэ маш чухал тогтоол. Тэгээд энэ тогтоолын хэрэгжилтийн талаар хэр хийж байгаа энэ хурал нь өөрөө бас маш өндөр ач холбогдолтой байх ёстой гэж бодож байна. Маш олон асуудал хөндсөн.

Тэгээд нэгдүгээрхтэй холбоотой ганцхан тодорхой асуудлыг хөндчихье гэж бодож байна. Нэгдүгээрт. Одоо төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай гээд. Энэ дотор АМНАТ, энэ тэрээ зөндөө юм байгаа. НӨАТ-тэй холбоотой.

Гуравдугаарх асуудал. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийх энэ тэр гээд. Энэ дээр тэгээд хэрэгжилт нь болохоор уг тогтоолын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчдаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 315 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэх саналыг ирүүлсэн.

Эдгээр төслүүдийн хувьд тарифт цалин, материалын үнийн өсөлт, анх төлөвлөсөн зураг, төсвийн алдаатай байдал, захиалагч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан төсөвт өртөг нэмэгдэж байна гэсэн ганц том шалтгаан байна.

Тэгээд одоо эргээд харъя. 2026 оны төсөв, төсвийн төсөл, Төсвийн тухай хуулийг хэлэлцэх гэж байна. Яг энэ тогтоолын хэрэгжилт бөгөөд үнэлгээ нь ирэх оны төсвийн тухай төслийн хэлэлцэх үед маш чухал ийм асуудлууд буюу хүчин зүйлс болох нь.

Тэгэхээр миний хэлэх гээд байгаа санаа нь одоо эхний 8 сарын байдлаар хөрөнгө оруулалтын төслүүд, арга хэмжээний гүйцэтгэл дөнгөж 31 хувьтай байгаа юм байна шүү дээ. Ялангуяа шинээр эхлүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, арга хэмжээ арван есхөн хувьтай байна.

Тэгэхээр нэг үндсэн шалтгаан чинь хугацаандаа тендер зарлахгүй, хугацаандаа хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэхгүй байгаатай холбоотой. Энэ эргээд ирэх оны Төсвийн тухай хуульд хэрхэн тусаж байгаа вэ? Дээгий хөрөнгө оруулалт маш сайн хариуцаж байгаа учраас энэ маш чухал шүү. Ганц Сангийн яамнаас хамаарахгүй. Бүх сайд нарын багцад хамаатай асуудал учраас тов тодорхой хариулаарай гэж хүсэж байна.

Дараагийн нэг хөндөх гээд байгаа асуудал нь бас нөгөө засаглал ил тод байдлын асуудал байна шүү дээ. Нөгөө төрийн өмчит үйлдвэрийн газруудын. Энэ дээр Францаас оруулж ирсэн яасан ийсэн арга зүй ашиглаад сайжруулах гэж байгаа, хэрэгжүүлэх гэж байгаа гэсэн байна. Яг бодит үр дүн бас ямар байна вэ? Төрийн өмчит үйлдвэрийн газруудыг хувьчилна. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр энэ төрийн өмчит үйлдвэрийн газруудын менежмент, засаглалыг сайжрах эсвэл хувьчлах замаар ашигт ажиллагааг нэмэх замаар орлого нэмэгдүүлэх энэ байдал хойшлоод байгаа. Энэ дээр бас шинэ төсөв

дээр Төсвийн тухай хууль дээр олигтой юм байхгүй байна лээ. Энэ дээр бас давхар хариулт авчихъя. Хоёр тодорхой асуулт.

Х.Ганхуяг: Ж.Дэлгэржаргал хариулъя. 5 номер.

Ж.Дэлгэржаргал: Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Ж.Дэлгэржаргал.

Тэгэхээр Их Хурлын тогтоолын дагуу өнгөрсөн оны 12 сараас эхлээд бид төсөвт өртгийн нэмэгдэлтэй. Анхны батлагдсан өртгөөрөө магадлалын ерөнхий дүгнэлтээр ямар нэгэн байдлаар өртөг нэмэгдсэн ажлуудыг Үндэсний аудитын газарт тухай бүр хүргүүлж ажилласан.

Ер нь Сангийн яаман дээр яг энэ тогтоолтой холбоотой төсвийн ерөнхийлөн захирагчдаас нийтдээ 1.7 их наядын санал ирсэн. Түүн дээр бид хэд хэдэн шалгуур тавиад яг аудит руу хүргүүлсэн нэмэгдлийн дүн 644.0 тэрбум байгаа.

Төсвийн төсөл өргөн барихаас өмнө Үндэсний аудитын газрын дүгнэлтээр 100 төслийн 194 тэрбумын нэмэлт хянагдаж ирсэн. Хянагдаж ирсэн дүнгээр тухайн төсөл төсөл дээр нь бид нэмэгдлийг нь ингээд тусгасан байгаа. Бусад нь аудитаас ирээгүй байгаа.

Дээрээс нь энэ дээр бас нэг асуудал бол барилгын ажилтны цалингийн тарифын өөрчлөлтийн өсөлтийн асуудал байгаа. Барилга, хот байгуулалтын яамнаас энэ дээр 35 тэрбумын цалингийн зөрүүг энэ төслүүд дээр тусгаж өгөх асуудал ирсэн. Аудитад хүргүүлээд Үндэсний аудитаас үүнийг хянах боломжгүй гэдэг санал албан бичгээр ирсэн учраас Сангийн яамнаас Барилга, хот байгуулалтын яаман дээр энэ дээр цалингийн тарифын асуудал ер нь хөрөнгө оруулалт дээр өмнө нь шийдэгдэж байгаагүй асуудал.

Тийм учраас төсвийн хувьд эрсдэлтэй байна гэж үзээд хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлтийг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Үүний хувьд төсвийн төслөөс өмнө ямар нэгэн шийдэл, санал, дүгнэлт бол ирээгүй учраас цалин тарифтай холбоотой өсөлт төсвийн төсөлд тусгагдаагүй байгаа.

Х.Ганхуяг: П.Ганзориг гишүүн. 3 номер гүйцээж хариулъя.

Б.Цэнгэл: Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя.

Их Хурлын 52 дугаар тогтоол дээр манайтай холбоотой 5 заалт байгаа. Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчийн этгээдийн хувьцааг олон нийтэд нь нээлттэй худалдах асуудлын талаар санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэдэг асуудлаас л би эхэлье.

Энэ асуудал Засгийн газар дээр боловсруулагдаж байгаа. Холбогдох яамдаас санал авсан. Тэгээд бид бас нэлээн хэрэгжих магадлалтай ийм зүйлийг Их Хуралд оруулаад үндсэн чиглэл болгож батлуулаад, тэгээд үүнийгээ Засгийн газрын жагсаалт болгоод хэрэгжүүлє гэж төлөвлөж байгаа.

Тухайлбал бид энэ удаа 9 компанийг үндсэн чиглэлд тусгахаар төлөвлөж байгаа. МИАТ компанийг энгийн хувьцааны 10 хүртэл хувийн эхний шатад стратегийн болон санхүүгийн хөрөнгө оруулагч нарт санал болгох... /минут дуусав/

Х.Ганхуяг: Болсон уу? Б.Мөнхсоёл гишүүн болсон уу? П.Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Энэ хоёр тогтоолын хэрэгжилттэй холбоотой бас олон асуудлууд байна.

Тэгээд би голчлоод хоёр зүйлийг тодруулмаар байна.

Нэгд, энэ 52 дугаар тогтоолын тэр 3 дугаар бүлгийн 16 дээр заасан байж байгаа. Төсвөөс олгож байгаа бүх төрлийн татаас урамшууллын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг судлаад, тэгээд эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллөөр нь нийгмийн хөгжлийг дэмжих эрэмбээр нь үүнийг зөв чиглүүлнэ, бодлогыг нь зөв болгоно гээд заасан. Гэтэл энэ нөгөө тайлбарласан, ард нь хэрэгжсэн байдал дээрээ тодорхой нарийвчилж заасан зүйл бараг огт байхгүй. Ийм байдалтай байж байна.

Тэгээд одоо манайх ер нь олон жил төсвөөс янз бүрийн татаас олон салбарт өгсөн. Өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн байгаа байдал, ялангуяа хувийн хэвшил гэдэг юм уу, ажлын байр гэдэг юм уу, цалин хөлсний дундаж хэмжээ гээд харах юм бол одоо өгсөн татаасаараа бол уг нь сайхан хөгжчихөөр болсон. Харамсалтай нь тийм биш байгаа.

Өөрөөр хэлбэл огт байгаа онодоггүй. Одоо тухайлбал, зүгээр нэг жишээ авахад “Шинэ хоршоо” зээлээр. Одоогийн байдлаар 840.0 тэрбум төгрөгийн зээл олгосон. Банкуудаас 2024, 2025 онд. Зөрүүг нь төсөв дээрээс хүүг нь татаасаар өгч байгаа. Өнгөрсөн жил ч би үүнийг хэлж байсан. 2026 онд дахиад 500 тэрбум төгрөгийн зээл олгоно. Хүүгийн татаас нь 109 тэрбум төгрөгийг төсвөөс өгнө. Тэгээд энэ өөрөө дандаа импортыг дэмждэг. Баахан урдаас Хятадын чанаргүй тоног төхөөрөмж, бараг, зарим нь үржлийн адуу мал болоод хувирдаг гэж байгаа. Тэгээд бүх мөнгө валют нь гадагшлаад явчихдаг. Валютын нөөцөд нөлөөлдөг. Инфляцыг импортолдог. Үнийн өсөлт иргэдийн халаас руу ордог. Ингээд үүний зовлонг чинь иргэд үүрч байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр тодорхой ямар бодлого барьж байгаа юм бэ? Энэ чинь бол маш чухал заалт шүү дээ. Маш олон төсөл, хөтөлбөр татаасууд явж байгаа. Хүүгийн татаасаар. Бусад төрлөөр.

Тэгэхээр иймэрхүү ийм чухал зүйлүүд дээрээ энэ тодорхой үр дүнтэй бодлого хэрэгжүүлсэн ийм бодитой тайлбар өгөөч ээ гэж хүсмээр байна.

Хоёрт, энэ 52 дугаар тогтоолын хамгийн эхний хэсэг дээр байж байгаа. Төсөв санхүү, татварын орчныг боловсронгуй болгох гээд. Энэ татварын орчны асуудал дээр дахиад л Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусчихсан байж байгаа татварын дарамт ачааллыг бууруулна гээд. Их Хурлаас ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Бас тодорхой хэмжээнд Засгийн газартай буюу Сангийн яамтай ойлголцоод саналуудаа тусгаад ингээд татварын хуулийн төсөл боловсруулаад тавьсан. Тэгээд энэ маань бас 2026 оны төсөвт байхгүй. Энэ тогтоолын үүрэгтэй бас хамаатай. Ганцхан НӨАТ-ын асуудал орж ирж байгаа. Бусад нь байхгүй.

Гэтэл бид халамжийн улс болчихоод хөдөлмөр лүү шилжих гээд байна гээд байдаг. Яг ажил хөдөлмөр эрхэлж байгаа, ажлын байр бий болгож байгаа, ажил хөдөлмөр эрхлээд цалин авч байгаа хүмүүсийнхээ татвар дээр хөнгөлөлт дэмжлэг огт байхгүй. Хүн амын орлогын албан татварын дэмжлэгүүд оруулсан. Байхгүй. Аж ахуйн нэгжийн орлогын дэмжлэгүүд оруулсан. Байхгүй. Зөвхөн НӨАТ бол одоо хэрэглээн дээр хөнгөлөлт үзүүлж байгаа л нэг хэлбэр шүү дээ.

Тэгэхээр энэ тогтоолын үүрэг гүйцэтгэл ямар байдлаар явж байгаа вэ гээд энэ хоёр дээр бас нэг тодорхой хариулт өгөөрэй гэж хүсье. Баярлалаа.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Тийм. Х.Ганхуяг дарга нэг ийм юм болоод байх юм.

Манайх 54 дүгээр тогтоолыг танилцуулах үүрэгтэй байхгүй юу. Тэрийгээ танилцуулаад асуулт хариулт тавьж байсан. Сая П.Ганзориг гишүүн, мөн өмнөх гишүүн нь 52 дугаар тогтоолоос асуугаад. Дараагийн асуудал руу яваад орчихлоо.

52-ыг тусад нь танилцуулаад санал асуулт явах юм уу, эсвэл ингээд үргэлжлүүлэх юм уу? Эдийн засаг, хөгжлийн сайд 52 дугаар тогтоолыг тусад нь танилцуулга хийх ёстой байхгүй юу.

Эдийн засаг, хөгжлийн сайд түр байхгүй байгаа учраас би уншчихаж болно.

Х.Ганхуяг: Тийм. Энэ тусдаа хэлэлцүүлэхээр тавигдсан байгаа болохоор шууд явж болохгүй л дээ. Тусдаа л явна л даа. Болохгүй. Тийм. Хоёр тусдаа асуудал юм. 54 дээр 54-ийн асуудлаа л ярина. Б.Мөнхсоёл гишүүн ээ.

Юутай холбоотойгоор би хоёр гуравхан асуулт, саналаа хамт хэлэх гэсэн юм.

Засгийн газрын тусгай сангуудын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн бариач ээ гээд Улсын Их Хурлын тогтоолд орсон байгаа. Хаврын чуулганд багтаагаад. Тэгсэн энэ Хэрэг эрхлэх газрын хэн билээ? Тэр дарга. Танай энэ тайлан дээр чинь ерөөсөө энэ чинь жоохон болохгүй байна шүү. Сангийн яамны бэлтгэсэн тайлангууд бол бас боломжийн хэмжээнд хүн ойлгохоор байна. Таны энэ тайлан чинь үгүй ээ нэг ийм юу боловсруулаад Х.Булгантуяад танилцуулсан гэдэг юм явж байх юм. Энэ чинь Их Хуралд өргөн мэдүүлэгддэг ийм тогтоолын юу орсон шүү дээ. Заалт.

Засгийн газрын тусгай сангууд дээрээ аль нь үр өгөөжтэй байгаа юм, аль нь үр өгөөжгүй байгаа юм. Тэгээд энэ зарцуулалт дээр нь тэр яаж хянах юм. Шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлын хаврын чуулганд өргөн барь гэж байхад Х.Булгантуяа гишүүнд танилцуулсан гээд тавьсан байгаа юм.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг та арай жоохон өөрөөр ойлгоод байна уу? Энэ дээр нэг тайлбар авъя.

Хоёрдугаар асуудал. Аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудал тус бүрийн хариуцлагын асуудлыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нарийвчлан зохицуулах, холбогдох хууль хоорондын уялдааг хангах, хил зөрчлийг арилгах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх гэсэн асуудал тогтоолын төсөлд орсон. Тогтоолд орсон. Тогтоол батлагдсан.

Сая нөгөө төрийн аудитор чинь нэг жигтэйхэн том том дүнтэй зөрчил илрүүлсэн л юм яриад байсан.

Тэгээд эргээд ямар хариуцлага тооцсон талаарх бид нарт ямар нэгэн мэдээлэл байхгүй. Хэн нэгний одоо мууг үзэх гээд яриад байгаад биш. Энэ Улсын Их Хурлын тогтоолыг та биелүүлэх ёстой шүү дээ. Хэрэг эрхлэх газар үүнийг шаардах ёстой. Өргөн мэдүүл гэсэн бол өргөн мэдүүлэх ёстой. Түүнээс биш хэн нэгэн таныг танилцуул гэдэг бид ерөөсөө ийм тогтоол үйлдээгүй шүү дээ. Тэгээд хэн нэгэн танилцуулаад үзэмжээр хасаад яваад байх юм уу?

Гуравдугаар асуудал. Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх боломжийг бүрдүүлэх, үүнд шаардагдах нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг нь олгоорой гээд 2025 оны энэ Улсын Их Хурлын төсөв батлагдахад тогтоолд бас орсон.

Тэгээд сая хэдэн хоногийн өмнө бас тэр навигацийн орлогоос энэ нислэгийг үйлдэхэд шаардлагатай санхүүжилтийг навигацийн орлого шийдэж өгөөч ээ гээд бичиг нь бас ирээд байгаа юм. Тэгээд энэ дээр бас нэг тайлбар авъя.

1 номер.

Ш.Мөнхцэрэн: Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Би түрүүн тайлбарласан. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас танилцуулсан мэдээлэл, ирсэн мэдээллийг Улсын Их Хурлын Байнгын хороонд хүргүүлсэн байгаа.

Яг өнөөдөр нэгтгэлийг хариуцсан яамдууд өөрсдөө биелэлтүүдийг тус тусдаа өөр өөрийн чиглэлээр гаргаж байгаа учраас Х.Булгантуяад гишүүнд хэлсэн энэ асуудлыг бид тодруулъя.

Хоёрдугаарт нь, аудитын шалгалтын хүрээнд Засгийн газар дээр Үндэсний аудитын газраас гарсан дүгнэлтийн мөрөөр Засгийн газар дээр бүр ажлын хэсэг гаргасан. Заалт бүрээр нь ажиллаж байгаа. Ажлын хэсгийн дүн одоо удахгүй эцэслээд танилцуулагдах ёстой байгаа.

Хуульд өөрчлөлт оруулах асуудал нь ажлын хэсгийн дүгнэлттэй уялдаж бас боловсруулагдахаар байгаа. Энэ хаврын чуулганд амжихааргүй. Яагаад гэвэл Үндэсний аудитын газрын дүгнэлт нь өөрөө Үндсэн аудитын газраас яг Их Хуралд танилцуулсан дүнгээ задалж ирүүлэхэд бол тэр том дүн өөрөө нэг бүрчлэн задрахгүй бас нэлээд хугацаа шаардсан асуудал үүссэн байгаа.

Навигацийн асуудал дээр Зам, тээврээс хариулах уу?

Х.Ганхуяг: 8 номерын микрофон өгье.

Г.Батбаяр: Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр байна. Асуултад хариулъя.

Америкийн Нэгдсэн Улс руу шууд нислэг үйлдэхтэй холбоотойгоор бид нарт Америкийн Нэгдсэн Улсын иргэний нисэхийн байгууллага болон олон улсын нисэхийн байгууллагуудын бид шалгалтад орох ёстой. Энд зайлшгүй шаардлагатай төсвийг навигацийн орлогоосоо төсөвт суулгахгүйгээр яамандаа үлдээж үүндээ зарцуулж өгөөч ээ гэсэн хүсэлтийг бид Сангийн яаманд болон төсөвт суулгахгүйгээр шийдэж өгөөч ээ гэдэг хүсэлтүүдийг өгч байгаа.

2026 оны төсвийн төлөвлөгөөнд бас энэ орлогыг хасаж өгөөч ээ. Бид зохих журмын дагуу зарцуулъя. Иргэний нисэхийн тэр аюулгүй байдлын ажиллагаанд зарцуулъя гэдэг хүсэлтээ өгч байгаа.

Үүнтэй холбоотойгоор бол Ерөнхий сайдаас захирамж гараад ажлын хэсэг гарч ажилласан. Сангийн яамнаас болон Зам, тээврийн яамнаас холбогдох бусад байгууллагуудаас Хууль зүйн яамнаас хүмүүс ороод ажлын хэсэг гаргаад санал, дүгнэлт гаргасан.

Үүнийг Засгийн газрын хуралдаанаар бол шийдвэрлэхээр материалаа хүргүүлсэн хүлээгдэж байгаа ийм байдалтай байна.

Х.Ганхуяг: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

“Монгол Улсын 2025 оны төсвийн дагуу хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар Сангийн сайдын мэдээллийг сонсож дууслаа.

Дараагийн асуудлыг Б.Жавхлан сайд яах вэ? Н.Учрал байхгүй юм байна шүү дээ. Тийм ээ. Та яах уу?

**Дөрөв. “Засгийн газарт чиглэл өгөх тухай”
Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд
болон Сангийн сайдын мэдээллийг сонсох**

Дөрөв дэх асуудал. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Сангийн сайдын мэдээллийг сонсьё.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг хэвээрээ юм байна. Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

52 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор би хоёр танилцуулга унших юм. Сангийн яамтай холбоотой болон бусад яамтай холбоотой хэрэгжилтийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас гаргасан. Н.Учрал сайдынхыг бас мөн би давхар танилцуулаад явчихъя.

Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 52 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг танилцуулж байна.

Танилцуулгатай холбоотой мэдээллийг бас мөн дэлгэцээр давхар явуулна. Одоо гарч байна.

▷ **Нэгдүгээрт,** Ашигт малтмалын улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлж, харилцан мэдээлэл солилцох ажиллагааг сайжруулах арга хэмжээний хүрээнд.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, техник, эдийн засгийн үндэслэл, төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг мэдээллийг багтаасан улсын нэгдсэн бүртгэлийн цахим сан бүрдүүлж, Татварын ерөнхий газар болон Ашигт малтмал, газрын тосны газар мэдээлэл солилцох гэрээг байгуулсан.

Татварын ерөнхий газар мэдээлэл дамжуулах системийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, Харилцаа холбоо, цахим хөгжлийн яамнаас сервис ашиглах эрх авч, татвар төлөгчийн үндсэн мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн.

Мөн хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн тайлан төлөвлөгөөг харах эрхийг Ашигт малтмал, газрын тосны газраас аваад байна. Ашигт малтмал, газрын тосны газар ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн цахим санд хөгжүүлэлт хийж байгаа бөгөөд цахим сангийн хөгжүүлэлт 2025 оны 11 дүгээр сард дуусах төлөвлөгөөтэй байна.

Ингэснээр харилцаа, мэдээ холбоо солилцох бүрэн боломжтой байна. Эдгээр мэдээллүүдийг бид хавар бас хүргүүлж байсныг давхар хэлье.

Тэгэхээр одоо ер нь бол гүйцэтгэлийн хувь хэмжээ 80 хувьтай явж байгаа гэж болно.

▷ **Хоёрдугаарт,** НӨАТ суутган төлөгчөөр бүртгэх босгыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, хууль өргөн мэдүүлэх арга хэмжээний хүрээнд.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан татварын шинэчлэлийг татвар төлөгч эрдэмтэн, судлаач, худалдааны танхим, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг оролцуулан улс орон даяар өргөн хүрээтэй хэлэлцүүлж, санал аван, татвар төлөгчдөөс ирүүлсэн саналуудыг нарийвчлан судлан үзсэний үр дүнд татварын шинэчлэлийн үзэл баримтлал, хуулийн төслүүдийг урьдчилсан байдлаар боловсруулаад 09 сарын 01-нд 2026 оны төсөв өргөн барихтай зэрэгцүүлээд D-Parliament.mn дээр хууль тогтоомжийн хуулийн дагуу нийтэд танилцуулж эхлээд байгаа.

Ингээд 60 хоног D-Parliament.mn дээр тавьж хэлэлцүүлсний дараа өргөн барих эрх нээгдэнэ.

Тэгэхээр энэ зохицуулалт дотор НӨАТ-ын төлөгчөөр бүртгүүлэх ажлын борлуулалтын орлого нь 400.0 сая төгрөгөөс доош бизнес эрхлэгчид хялбаршуулсан горимд шилжиж, улирлаар тайлагнах боломжтой зохицуулалтыг тусгасан байгаа.

Тэгэхээр биелүүлэлт 100 хувь.

Бид өргөн барих хүртэл бидний ажил учир 100 хувь хийгдсэн байгаа. Цаашаа яаж хэрхэн батлагдах нь бол Улсын Их Хурлын эрх мэдлийн асуудал.

▷ **Гуравдугаарт,** улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга, байгууламжийн төсөвт өртөг магадлал хийх, аудитын дүгнэлт гаргуулах арга хэмжээний хувьд гээд.

Үүнийг түрүүн бас танилцуулсан байгаа. Харин одоо энд байгаа яамдаас энэ дэд бүтцийн яамдуудын нөхдүүд өөрсдийн дэргэд байдаг энэ хөгжлийн төвүүдтэй холбоотой. Та бүхэн тэрийг яаж хянадаг юм. Тэр өртгөө тодорхойлж байгаа дүнд нь хэр итгэл үнэмшилтэй байдаг юм. Тэрийгээ нэг сонсгочихмоор байна.

Танайхаас ирсэн дүнг ер нь Сангийн яаман дээр ер нь бид хянах ямар ч боломжгүй байдаг шүү дээ. Тэгээд л тэр чигийг нь цааш нь явуулахаас өөр арга байхгүй. Ганц явуулдаг газар нь одоо Үндэсний аудитын газар.

Дараагийн асуудлууд. Тэгвэл Авлигатай тэмцэх газар болон цагдаагийн байгууллага руу бид явуулахаар бэлдчихээд байгаа.

▷ **Дөрөвдүгээрт,** Төрийн банк болон санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн ногоон хөгжлийг дэмжих чиглэлд шилжүүлэх арга хэмжээний хүрээнд.

Төрийн банк нь олон улсын стандартын жишигт нийцүүлж, банкны бүтэц, тогтвортой хөгжлийн албыг бие даасан нэгжээр зохион байгуулж, байгууллагын дунд хугацааны стратеги болон 2025 оны бизнес төлөвлөгөөндөө тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн асуудлыг дэмжсэн зорилго, зорилтуудыг тусган дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа.

Тус банк нь ногоон санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд малчны ногоон зээл, ногоон бэлтгэн нийлүүлэгчийн зээл, бизнесийн ногоон зээл, ногоон орон сууцын зээл, ногоон даатгал зэрэг нийт 8 бүтээгдэхүүний үйлчилгээг зах зээлд шинээр нэвтрүүлээд байгаа.

Үүний үр дүнд тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн багц 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 250 гаруй тэрбум төгрөгт хүрч, өмнө жилтэй харьцуулахад 47 хувиар нэмэгдсэн бөгөөд үүнээс ногоон зээлийн багц 96 тэрбум төгрөгт хүрч, 98 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үүнтэй холбогдуулан ногоон бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээлийн идэвхжилийг дэмжих, санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 12 дугаар сард дотоодын зах зээлд 10 тэрбум төгрөгийн ногоон бондыг хаалттай хүрээнд

гаргасан бол ойрын хугацаанд 50 сая ам.долларын нэрлэсэн дүнтэй ногоон бондыг олон улсын зах зээлд гаргахаар ажиллаж байна.

“Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компани хөрөнгийн зах зээлд олон улсын жишигт нийцсэн ил тод байдлын стандартыг нэвтрүүлэх хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглал, тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг боловсруулан холбогдох зохицуулалтыг мөрдүүлж байна.

Энэ хүрээнд биржид бүртгэлтэй 34 компани байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналаа ирүүлснийг олон нийтэд нээлттэй байршуулаад байна.

Дотоодын ногоон бондын зах зээлийг дэмжих, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх хүрээнд Монголын хөрөнгийн бирж хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлийн журам үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, хувьцаат компанийн үнэт цаасны хадгаламжийн журамд тус тус өөрчлөлт оруулах замаар ногоон бондын бүртгэлийн болон хадгаламжийн хураамжийг 50 хүртэл хувиар бууруулахаар ажиллаж байна.

Засгийн газрын хүүгийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдийг уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, байгаль орчинд ээлтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэх зорилтод нийцүүлэн “Цагаан алт”, “Атар-4” аян үндэсний хөтөлбөрүүдийн санхүүжилтийн гэрээнд ногоон зээлийн зохицуулалтыг тусгасан.

Улмаар тус хоёр хөтөлбөрүүдийн хүрээнд банкны ногоон зээлийн шаардлагыг хангасан зээлдэгчийн төлөх хүүгийн хэмжээг 1-ээс 2 хувиар бууруулсан. Мөн цаашид “Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөтөлбөрийн санхүүжилтийн гэрээнд өөрчлөлт оруулах замаар ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

“Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд ногоон зээлийн эх үүсвэрээр 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс хойш 8 сарын хугацаанд 42 зээлдэгчид 248 тэрбум төгрөг, “Атар-4” хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс хойш 6 сарын хугацаанд 29 зээлдэгчид 45.9 тэрбум төгрөгийн ногоон зээл олгоод байна.

➤ **Тавдугаарт,** бусдаар гүйцэтгүүлэх зардлын ангиллын нарийвчлан шинэчлэх арга хэмжээний хүрээнд.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын харьяа байгууллагуудын 2024 оны төсвийн бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бусад зардлын дэлгэрэнгүй дата өгөгдөл, зардлын эдийн засгийн ангилал болон зориулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ангиллаар нарийвчлан тодорхойлох, хамрах хүрээг Засгийн газрын санхүүгийн статистик гаргах арга загварт нийцүүлэх зорилгын хүрээнд Санхүүгийн мэдээллийн төвтэй хамтран дата өгөгдөл, анализ судалгааг хийсэн.

Судалгааны үр дүнд үндэслэн 7 шинэ эдийн засгийн ангилал үүсгэж, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж, зардлаас холбогдох зардлуудыг задалж, нарийвчилж шинэчиллээ.

Ингэхдээ эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг судалгаа, хөгжүүлэлт, байр ашиглалтын үйлчилгээ болон харуул хамгаалалтын зардлыг хөрөнгийн ашиглалтын менежмент, улс орноо гадаадад сурталчлах зардлыг мэдээлэл, сурталчилгааны зардал, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зардлыг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ, хот тохижилттой холбоотой зардлыг тохижилт, үйлчилгээ, эдийн засгийн ангилалд тус тус шилжүүлсэн.

Эдийн засгийн ангиллын шинэчлэн Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 тоот тушаалаар батлан 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр ажиллалаа.

Түүнчлэн Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа шинэчилсэн ангиллын дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

➤ **Зургадугаарт**, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлж буй хууль тогтоомжийг судалж, танилцуулга, арга хэмжээний хүрээнд.

Төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн нэгдсэн судалгааг хийж гүйцэтгээд байна.

Өөрөөр хэлбэл нэгдсэн төсвийн тэнцэлд нөлөө үзүүлэхүйц хэмжээний улсын төсвөөс зардлыг нь санхүүжүүлэхээр хууль тогтоомжид тодорхой тусгасан 208 хуулийн 1028 заалт улсын төсвөөс зардлыг нь санхүүжүүлэх болон зардлыг нь дотоодын нийт бүтээгдэхүүний тодорхой хувьтай тэнцэхээр тодорхойлсон Улсын Их Хурлын хурлын 4 тогтоол байна.

Төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудыг нэгтгэн судалж, Улсын Их Хурлын холбогдох ажлын хэсэг болон түүний дэд ажлын хэсэгт 2025 оны 03 дугаар сарын 26, 27-ны өдрүүд, 04 дүгээр сарын 28-ны өдөр мөн Төрийн хэмнэлт, бүтээмжийн үндэсний зөвлөлд танилцуулсан болно.

➤ **Долдугаарт**, төсвөөс олгож байгаа бүх төрлийн татаас урамшууллын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн судалгааны хүрээнд.

Тоон мэдээллийн баазыг бүрдүүлж, олон улсад түгээмэл ашиглагддаг загвар аргачлалд үндэслэн татаас урамшууллын зардлын үржүүлэгчийн нөлөөг үнэлсэн.

Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас шаардлагатай зарим тоон мэдээллүүдийг цуглуулж хөдөө аж ахуйн салбар гол татаас урамшуулал, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хамтран тооцоолоод байна.

Цаашид нийт татаас урамшууллын дийлэнх хувийг бүрдүүлж буй тэтгэврийн сангийн татаас болон эрчим хүчний салбарын татаас урамшууллын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох. Ингэхдээ холбогдох яамдын оролцоог ханган ажиллахаар ажиллаж байна.

Тэгэхээр одоо гүйцэтгэл бол энэ жилийн туршид гарна. Одоогоор Хүнс, хөдөө аж ахуйн яам буюу хамгийн том татаас авч байгаа яамтай гүйцэтгэл 70-аас 80 хувьтай явж байна.

Бусад яамдын хувьд эхлэлийн шатад байна.

▷ **Наймдугаарт**, хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төвүүдийг татан буулгаж, чиг үүргийн холбогдох яамдад шилжүүлэх арга хэмжээний хүрээнд.

Энэ өмнөх заалт буюу 7 дугаар заалттай холбоотой энэ татаасны үр дүн, үүнийг тооцох аргачлалтай холбоотой мэдээллүүдийг Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан өөрсдөө бэлдэж байгаарай. Хүмүүс байгаа биз. Хөдөө аж ахуйн яамнаас хүмүүс байна уу? Хэрэг эрхлэхээс Хөдөө аж ахуйн яамнаас дуудахгүй яасан юм бэ? Хамгийн том татаас авдаг яам шүү дээ.

Тэгээд ер нь бол хамгийн үр дүн гарч байгаа татаас шүү. Тэгээд яамнаас нь хүмүүсийг байлгачихгүй дээ.

Эрчим хүчний яам болон бусад яамд мөн энэ асуултдаа бэлэн байгаарай.

Наймдугаар асуудал руугаа эргээд орьё. “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан 46 үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлд дүн шинжилгээ хийх, зарим үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийг татан буулгахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.

Тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад хүргүүлээд байна.

Улмаар Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор нийт 29 үндэсний хороо, зөвлөл, комиссыг татан буулгахаар шийдвэрлэсэн.

Ажил үндсэндээ хийгдсэн гэсэн үг. Одоо яг процесс нь явж байгаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарах. Дээрх тус тогтоолын шүү. Найман чиглэлээр өгөгдсөн Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн талаар танилцууллаа.

Цаашид эдгээрийн ажлын үр дүнг улам гүнзгийрүүлж дараа дараа дараагийн шатын тайлагналуудыг Төсвийн байнгын хороондоо танилцуулж байх болно.

Тус тогтоолтой холбоотой бусад яамдын хэрэгжилтийг Эдийн засаг, хөгжлийн яаман дээр базаж гаргасан байгаа.

Энэ танилцуулгыг мөн тусад нь хүргүүлъя. Танилцуулъя.

Эрхэм Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн 2025 оны 3 дугаар улирлын байдлын байдлын талаар мэдээллийг танилцуулъя.

Тус тогтоолд:

Нэг.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж иргэн арга хэмжээ. Энэ чинь юу нь байна шүү дээ. Тогтоол нь байна шүү дээ. энэ тайлангаас нь шууд уншъя.

1 дүгээр заалттай холбоотой.

Нэг.Ашигт малтмал болон татварын мэдээллийн сангийн уялдаа холбоо бүрэн хангагдаж, холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр харилцан солилцох боломжтой болсон нь төрийн байгууллагуудын ил тод байдлыг сайжруулахад чухал алхам болсон.

Төрийн өмчит компаниудын бүтцийн өөрчлөлтийг эхлүүлж “Эрчис Монгол” Ххк болон эрчим хүчний салбарын зарим компанийг нэгтгэсэн нь төрийн өмчит компаниудын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ боллоо гэж байна.

Энэ хэрэгжилтийн хувийн хэмжээг нь танилцуулах ёстой юм байна шүү. Манай Хэрэг эрхлэх газрынхан эндээ бэлэн байгаарай.

Эдийн засаг, хөгжлийн яамныхан бэлэн байгаарай.

2 дугаар заалттай холбоотой. Мөн Шилэн дансны хууль хэрэгжих хүрээг өргөтгөж ил тод байдлыг хангах цахим системийг бүрдүүлсэн бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь шинэчлэлийг хэрэгжүүлэх эрх зүйн шинэчлэлийг тавихад чухал алхам болно гэж үзэж байна.

Гурав.Үүнээс гадна Төрийн банк болон Хөрөнгийн биржийн түвшинд ногоон санхүүжилт ESG /Environmental, Social, Governance/-гийн олон улсын стандартыг нэвтрүүлж эхэлсэн нь тогтвортой хөгжилд чиглэсэн алхам боллоо.

Төсвийн зарцуулалтын ангиллын шинэчилж үр ашиг, шаардлагад суурилсан төсөв боловсруулах тогтолцоог бий болгосон нь тогтоолын хэрэгжилтийн чухал үр дүн юм.

Засгийн газар бүх шатад төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх зорилтын хүрээнд Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор 29 үндэсний хороо, зөвлөлийг татан буулгалаа.

Ингэснээр жил бүр 41.6 тэрбум төгрөг хэмнэхээр тооцоо гарсан болно. Татан буулгасан хороо, зөвлөлийн чиг үүргийг төрийн холбогдох байгууллагууд хуульд заасны дагуу хэрэгжүүлэх боломжтой болно.

Үр дүн хүлээгдэж байгаа заалтуудын тухайд.

Нэмэгдсэн өртгийн албан татварын босго хэмжээг нэмэгдүүлэх хуулийн төслийг боловсруулсан боловч 2025 оны 11 дүгээр сард өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн тул хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна.

Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын түвшинд боловсруулсан бөгөөд хараахан Улсын Их Хуралд танилцуулагдаагүй байгаа нь бас нэгэн хүлээгдэж буй ажил юм.

Мөн төрийн өмчит компанийн засаглалын үнэлгээ болон олон улсын байгууллагуудын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажил үргэлжилж байгаа ч эцсийн үр дүн гараагүй байна.

Харин төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим барилга, байгууламжийн өртөг нэмэгдсэнтэй холбоотой аудитын дүгнэлтийг хугацаанд нь Улсын Их Хуралд танилцуулаагүй нь хэрэгжээгүй гэж дүгнэгдэх гол шалтгаан болж байна.

Цаашид авах арга хэмжээний талаар. Цаашдаа хугацаа болоогүй ажлуудыг төлөвлөсөн хугацаанд нь боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлгийг шуурхай зохион байгуулах шаардлагатай байна.

Мөн төрийн өмчит компаниудын засаглалын шинэчлэлийг олон улсын сайн туршлагад нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлж, зөвлөмжүүдийг бодит үр дүнд хүргэх шаардлагатай байна. Үүнээс гадна ногоон хөгжил болон тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийг өргөжүүлж, банкны салбарын нийт зээлийн багцад эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой байна. Тогтоолоор өгөгдсөн заалтуудыг бүрэн хэрэгжүүлэх хүрээнд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, үйл ажиллагааны зохицуулалт, хэрэгжилтэд Засгийн газрын зүгээс бүх талаар дэмжлэг үзүүлэн ажиллах болно.

Тогтоолоор өгөгдсөн 19 заалтын хэрэгжилтийн явц дунджаар 87.5 хувьтай байна.

Та бүхэнд 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тараасан байгаа болно.

Байнгын хорооны хуралд салбарын холбогдох албан тушаалтнууд ирсэн байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Давхцаад асууж болно. Одоо энэ яг 52 дугаар тогтоолтой холбоотой. Түрүүн хариулт өгөөгүй юм чинь. Тийм ээ. П.Ганзориг гишүүнээр тасаллаа. Д.Үүрийнтуяа гишүүн. П.Сайнзориг гишүүнийг нэмээрэй.

Д.Үүрийнтуяа: 52 дугаар тогтоол мөн ялгаагүй хэрэгжилтийн хувь, гүйцэтгэл алга байна.

Тэгээд Сангийн яамны хариуцаж байгаа асуудлаар гээд Б.Жавхлан сайд танилцуулчихлаа. Эдийн засаг, хөгжлийн сайдынхыг гээд уншихлаа. Одоо тэгэхээр яах юм? Бусад яаманд нь бас тус тусдаа ярих юм уу? Засгийн газар нэгтгээд оруулж ирж байгаа гэж ойлгоод байх юм. Үгүй юм уу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Нэг.

Хоёрдугаарт, 52 дугаар тогтоолын хэрэгжилтийг энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлууд дээр тэр нэг магадлал хийх

асуудал. Энэ тогтоолыг орж байхад та бид хоёр бас нэлээдгүй сайдаж, муудаж байсан. Б.Жавхлан сайд аа.

Нийтдээ төсвийн ерөнхийлөн захирагчдаас 315 төсөл, арга хэмжээний нэмэгдүүлэх саналыг 2025 оны улсын төсөв дээр өгсөн. Үүнээс та магадлал нь хийгдсэн гээд 249-ийг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

Тэгэхээр 66 төсөл, арга хэмжээ, магадлал хийгдээгүй байхад 2025 оны төсөвт туссан гэсэн үг үү? Нэг.

Хоёрдугаарт, энэ 249 ажлын төсөл, арга хэмжээний 100 арга хэмжээн дээр нь Үндэсний аудитын газар 194.5 тэрбум төгрөгийг хянаж ирүүлсэн гэжээ.

Тэгэхээр магадлал хийгдсэн ажлуудаас энэ 149 төсөл нь аудитаар хянагдаагүй гэж ойлгох уу?

Гуравдугаарт, энд хянагдсан 100 төслийн 194.5 тэрбум төгрөг гэдэг энэ дүн магадлал хийгдсэн дүн юм уу, эсвэл аудитлагдсан дүн юм уу?

Дөрөвт нь, үүнийг судлаад улсын төсөвт 2026 оны төсөвт тусгасан гэжээ. Энэ Үндэсний аудитын газраас хийгдсэн энэ Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолын хүрээнд хийгдсэн аудитын дүнгээр улсын төсөвт ямар өөрчлөлтүүд 2026 оны төсөв дээр орж ирж тусгагдаж байгаа юм бэ? Тэгээд яг ийм байдлаар асуувал их олон асуултууд байна. Гэхдээ энэ бол цаг хугацааны хувьд үнэхээр багтахааргүй байна.

Тийм учраас би хамгийн их ач холбогдол өгч өнгөрсөн оны төсөв дээр ярьж байсан асуудлынхаа хүрээнд энэ дөрвөн асуултыг яг нэг үүрэг даалгавартай холбоотой асууж байна.

Тэр тайлагналтын хувьд яах вэ. Бусад яамтай холбоотой асуудлыг бусад яамдаас асуух ёстой юм уу? Энэ дээр тодорхой хариулт өгчих.

Х.Ганхуяг: Ажлын хэсгийн 5 номерын микрофон нээгээрэй.

Ж.Дэлгэржаргал: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Ж.Дэлгэржаргал.

2023 оноос эхлээд ер нь төсөвт өртгийн нэмэгдэл эхлээд яг үндсэн үндэслэл нь магадлалын ерөнхий дүгнэлт гарч байгаа. 3 хөгжлийн төвөөс. Энэ магадлалын ерөнхий дүгнэлтэд аудит хийлгэж байгаа.

Тэгэхээр 2024 онд тавигдсан нэмэгдлүүд. 2025 онд бол бид төсөвт өртгийн нэмэгдлийг огт хууль дээр тавиагүй. Үүнтэй холбогдуулаад энэ тогтоол гарсан. 12 сараас эхлээд яг энэ магадлалын ерөнхий дүгнэлт нь гарсан. Нэмэгдэх саналууд нийтдээ яамдаас ирсэн дүн 1.7 их наяд байгаа.

1.7 их наядаас 644 тэрбумын нэмэгдлийн саналыг аудитад хүргүүлсэн. Үүн дотор 35 тэрбум нь цэвэр яг энэ барилгын компаниудын цалин, тарифтай холбоотой ажилчид дээр үүссэн асуудал байгаад байгаа. Яг 644 тэрбумаас төсөв өргөн барихын өмнө Үндэсний аудитын газраас 6 удаагийн албан бичгээр нийтдээ 194 тэрбумыг хянаж ирүүлснийг төсвийн төсөлд тухайн төслүүд дээр нь тусгаад ингээд өргөн барьсан байгаа.

Тэгэхээр ер нь аудитын дүгнэлт бол яг магадлалд хөгжлийн төвүүдээр гарсан. Дээрээс нь тухайн яамдаас энэ нэмэлт санхүүжилтийг хянаж өгнө үү гэсэн хүсэлтэд үндэслээд аудит хийгдэж байгаа.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд гүйцээж хариулья.

Б.Жавхлан: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад зүгээр нэмэлт мэдээлэл өгье.

Магадлан хийгдсэн юм уу, эсвэл аудитаар аудитлагдсан юм уу гэж асуусан асуух шиг болсон. Тийм ээ. Энэ чинь дарааллаараа процессоороо магадлан хийгдээд ирсэн энэ төслүүдийг, энэ нэмэгдлүүдийг төсөвт нэмж тусгаад өргөн барих үүрэгтэй юм. Засгийн газар. Ерөөсөө дүлий нэг ийм үүрэгтэй байхгүй юу.

Тэрний өмнө одоо дахиад нэг ийм хяналтын шат гаргаад үүнийг нэг аудитлаад өгөөч ээ. Үндэсний төвүүдийн энэ нөхдүүдийн гаргаад байгаа энэ өндөр нэмэгдлүүд чинь зөв юм уу, буруу юм уу. Та нар нэг хянаад өгөөч гээд. Ингээд Үндэсний аудитын газар луу явуулах үүргийг Их Хурлаас өгсөн.

Тэгэхээр тэр жагсаалт дээр бол бид ямар ч эргэлзээгүй нэгийг нь ч үлдээлгүй бүгдийг нь явуулаад, түүн дээр нь аудит хийгдээд ингээд бид нарт нэг цувуулаад ирдэг юм. Одоо яаж тэрийгээ эрэмбэлж яаж аудиталж байгааг нь бид хэлж мэдэхгүй.

Ингээд ямар ч байсан 09 сарын 01-нд төсөв өргөн барихад хүртэл ирсэн нь энэ 100 төслийн 194... /минут дуусав/

Х.Ганхуяг: 6 номер нэмж өгөөрэй.

Б.Жавхлан: 194 тэрбум төгрөгийн энэ 100 төслийн энэ магадлан дээр аудитлагдсан тайлантайнуудыг нь одоо 2026 оны төсөвт тусгасан байгаа гэсэн үг.

Өөр нэг ерөнхий асуултыг хэрвээ би буруу ойлгоогүй бол Үндэсний аудитын газрын санал, дүгнэлттэй холбоотой 26-ны төсөв дээр ямар нэгэн өөрчлөлт байгаа юу гэж байна. Дарааллын хувьд бид 09 сарын 01-нд өргөн барьдаг. Өргөн барьснаас хойш Засгийн газар оролцохгүй. 09 сарын 01 өргөн

барихтайгаа зэрэгцээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Үндэсний аудитын газарт бид төслөө хүргүүлдэг.

Ингээд өчигдөр чуулган нээгдэхтэй холбогдуулаад хоёр институт маань өөрсдийнхөө дүгнэлтүүдийг зэрэгцээд уншсан. Тэрний дагуу өөрчлөлт хийх эсэх нь төсөв батлах бүрэн эрх бүхий институт Улсын Их Хурлын хэлэлцэх шатанд л яригдах асуудал.

Х.Ганхуяг: Нэмж тодруулъя. Д.Үүрийнзаяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Хэдүүлээ нэг хэлээр ярья. Ж.Дэлгэржаргал аа, би тодорхой тоонууд асуусан. Нэгдүгээрт. Асуултуудаа би их ойлгомжтой тодорхой тавиад байгаа гэж ойлгоод байгаа. Их олон тайлбар хэлэхгүй байгаа.

Тэгээд яг миний тод асуултуудад тодорхой хариулж өгөөч ээ. Би яг нэг тодорхой тоонууд л асуугаад байгаа шүү дээ. Яг энэ дөрвөн асуултад тодорхой хариулт авмаар байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Б.Жавхлан сайд аа, энэ 52 дугаар тогтоолоор өгсөн үүргийг хугацаа заасан. 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй. 2025 оны нэгдүгээр улиралд танилцуулсан бол юун 9 сар. Төсөвт орох ёстой шүү дээ.

Таны ирүүлчхээд байгаа энэ тайлагнаад байгаа тайлан дээр чинь 2026 оны төсөвт тусгаад байна гээд ороод байгаа байхгүй юу. Гэтэл одоо таны тайлбар тусгаагүй юм шиг юм яриад байна. Тэгээд энэ тайлагнаж байгаа хэлбэр, хариулж байгаа хэлбэр, үүнийг ер нь яаж ойлгох ёстой юм бэ? Ёстой жинхэнэ бантан боллоо энэ чинь.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Д.Үүрийнтуяа гишүүн ээ, өөрт чинь маш ойлгомжтой л уг нь яриад байна даа.

Энэ тогтоолоор өгсөн үүргийн дагуу нэгдүгээр улиралдаа багтаагаад бид тухайн үеийнхээ тайлагнасан байгаа. Явцыг. Бүр хоёр ч удаа хүргүүлсэн. Ингээд өнөөдөр Байнгын хороон дээр хэлэлцэж байгаа л асуудал.

Энэ төслүүдийг аудит руу бүр хэзээ хүргүүллээ. Өнгөрсөн оны 12 сараас эхлээд хүргүүлсэн байгаа. Бүх төслүүдийг нь. Ингээд аудитлаад ирж байгаа төслүүдийг л бид 2026 оны төсөвт оруулна шүү дээ. Улсын Их Хурлаас үүрэг өгчхөөд байхад аудитлаагүй төслүүдийг бид оруулах эрх байхгүй. Бүр бантан болно.

Тэгэхээр ямар ч байсан Улсын Их Хурлаас өгсөн үүргийн дагуу аудитлагдсан төслүүдийг 2026 оны төсөвт тусгалаа гэж байна.

Х.Ганхуяг: Д.Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: 2026 онд тусгасан дүнг би асуугаад байгаа шүү дээ. Б.Жавхлан сайд аа.

194 тэрбум гэж та хэлээд байна. Энэ чинь магадлал хийгдээд баталгаажсан дүнгээ хэлээд байгаа юм уу, аудит орсон юм уу? Энэ дээр зөрүү үүссэн юм уу? Зөрүү үүссэн бол та зөрүүг нь хэлээд өг л дөө.

Би тэр хэдэн арга хэмжээгээр тодорхой асуусан шүү дээ. 315 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас танайх 249-ийг нь аудитын газар луу явуулсан байна. 66 нь яагаад яваагүй юм? Эсвэл энэ магадлал хийгдээгүй юм орчихсон байсан юм уу? 249-өөс аудит 100 төсөл, арга хэмжээнд л дүгнэлт ирүүлсэн байна. 149-ийг нь хийх боломжтой гэсэн юм уу? Боломжгүй гэсэн юм уу?

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд хариулах уу? 6 номерын микрофон өгье.

Б.Жавхлан: Үгүй ээ, одоо би ойлгомжгүй яриад байна уу. Энэ чинь 100 төсөл дээр 194 тэрбум төгрөгийн төсөвт өртгийг нь магадлаад ингээд ирүүлсэн нь л дүн нь шүү дээ. Зөрүү гараагүй ирүүлсэн байна.

Бусад цаана нь үлдсэн 149-ийг ямар байдалтай яаж эрэмбэлээд аваад үлдсэнийг нь Үндэсний аудитын газраас өөрөөс нь асуух хэрэгтэй.

Тэр 66 төслүүд чинь төслүүд нь дуусчихсан, дахиж аудит хийх шаардлагагүй ийм төслүүд байна. Өөр ямар ямар төслүүд байна гэлээ. Хууль дээр суусан боловч хэрэгжиж эхлээгүй, хэрэгжээгүй хасагдсан ийм төслүүд байгаа юм байна. Тэр 66 дотор чинь. Хэрэгжихгүй төслүүд гэсэн үг байхгүй юу.

Х.Ганхуяг: Да.Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Та бүхний оройн мэндийг айлтгая.

Энэ мэдээллүүд харьцангуй сүүлдэж ирээд байгаа гэдгийг Байнгын хорооны дарга бас анхаараад цаашдаа мэдээллүүдээ эртхэн өгч байвал сайн байна.

Тэгээд хоёрдугаарт 52 дугаар тогтоолын 2.6 дээр заасан байгаа. Бид нэг ийм эрх банктай болсон. Эрх банкны захирал нь Монгол Ардын намын нэг даргын үеэл. Тэгээд энэ үеэл нь өөрөө ажлаа хийдэггүй. Одоо Сангийн сайдаар ажлаа хийлгээд сууж байдаг болсон.

2.6-д нь Төрийн банк гэж байгаа. Бүр заагаад өгсөн. Санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээд үйл ажиллагааг нь олон улсын жишигт нийцүүлэн ногоон хөгжлийг дэмжих тусгайлан чиг үүргээр

шинэчлэн зохион байгуулж гээд ингээд баахан үүрэг даалгавар өгсөн. Тэгээд энэчээ хийгдэж байгаа ажлууд нь одоо Сангийн сайд гүйцэд мэдэхгүй л яриад байх шиг байна л даа. Энэ чинь ногоон даатгал, ногоон бэлтгэн нийлүүлэгч гэж яг юу байх вэ? Бизнесийн ногоон зээлийг бол ойлгочихъё. Ногоон харилцах данс, ногоон орон сууц гэж. Өнгийн ногооноор будчихаар ногоон болчих юм уу? Яг ямар бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлчхээд Төрийн банк энэ үйл ажиллагаагаа явуулчихлаа гэж одоо энэ тайлан болгож оруулж ирээд байгаа юм?

Тэгээд Сангийн сайд ер нь ингээд нэг ийм Монгол Ардын намын дарга нар битүү даргыг нь хийж байгаа энэ банкаа одоо яг зах зээлийнх нь зарчмаар төрд ачаа болгоод байхгүйхэн шиг хувьчлаад явуулчихвал өшөө илүү энэ эдийн засаг хүнд байгаа нөхцөлд ч гэдэг юм уу, үр дүнтэй байх биш үү?

Тэгээд одоо энэ хийсэн тайланг нь та өөрөө сая дутуу л уншсан байх л даа. 2025 оны энэ он сараараа бүр түрүүлээд явсан байгаа юм. 12 сарын 16-нд зах зээлд 6 ногоон бүтээгдэхүүн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсэн гээд. Бид одоо 2025 оны 9 сард амьдраад байна. 12 сард энэ бүтээгдэхүүнээ танилцуулсан болоод байна шүү дээ.

Тэгээд ийм эрх банкны өмнөөс та энд 70, 80 тэрбум төгрөгийн эх үүсвэр л татсан юм байна. Тэгтэл тэнд Хөгжлийн банк гээд нэг банк дахиад нэг эрх банк сууж байгаа. Ямар ч нэмэр болдоггүй. Энэ 2 банк. Энэ 2 банкныхаа үйл ажиллагааг та биш таны удирдаж байгаа, эсвэл нөгөө Эдийн засаг, хөгжлийн яам нэг банкныг нь удирдаж байгаа байх. Банкных нь захирлууд орж ирээд бид яг ийм юм хийлээ. Энэ дээр нь ийм алдаа дутагдал гарсан. Энэ дээр нь ийм сайшаалтай үйл ажиллагаа гарсан. Энэ дээр бид 52 дугаар тогтоолыг ингээд хангаад ажиллалаа гээд тайлан тавьж болохгүй юу.

Одоо энэ эрхлүүлээд байгаа энэ дарга нараа бас нэг цөөлөөд явуулъя гэвэл Төрийн банкн дээр бэлээхэн жишээ байна гэж би бол харах гээд байгаа юм. Энэ дээр таны саналыг сонсьё.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Тэр хамаатан садны асуудлыг би анх удаа сонсож байна. Тэрийг та өөрөө бас хариуцлагатай гишүүн хүн. Үүнийгээ өөрөө хөөцөлдөөд батлаад нотлоод явна биз.

Тус банкн дээр ажиллаж байгаа удирдах баг бол ТУЗ-ийн тавьж байгаа шаардлага, хувь нийлүүлэгчдийн тавьж байгаа шаардлагыг хангаад сонгон шалгаруулалтынхаа процессыг даваад ингээд тогтвортой сүүлийн хэмжээнд бараг 4 жил ажиллаж байгаа ийм удирдах баг. Гэнэт гараад ирсэн нөхдүүд биш шүү.

Тэгээд энэ ногоон хөгжил, ногоон бүтээгдэхүүн гэдэг энэ санхүүгийн зах зээл дээр гарч ирж байгаа энэ бол дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрөгдөж нэвтэрч байгаа үг хэллэгүүд, томьёоллууд, бүтээгдэхүүний нэршлүүд.

Заримыг нь шууд орчуулсан ч байгаа байх. Зарим нь манайд тохирсон ийм шинэлэг бүтээгдэхүүнүүд ч байгаа.

Манай арилжааны банкнууд ер нь бүгдээрээ ийм ногоон бүтээгдэхүүнүүд гаргаж эхэлсэн байдаг. Харилцан адилгүй байгаа. Энэ дээр одоо төр эзэмшиж байгаа банкны хувьд энэ төрийн болон нийтлэг дэлхий нийтийн чиг хандлагатай тохируулж энэ шилжилтийн процессыг түүчээлэх, манлайлал үзүүлэх ёстой гэдэг үүднээс өмнөх Засгийн газрын үед ч тэр, одоо ногоон бүтээгдэхүүнээ түлхүү гаргах ийм үүрэг авсан байдаг.

Бүтэн шилжинэ гэдэг ойлголт бол аль ч банкны түвшинд байхгүй. Арилжааны аль ч банк ер нь нэг 10-аас 20 хувь хэмжээнд л байгаа. Бүтээгдэхүүнүүд дотор нь. Төрийн банк ч гэсэн стандарт энэ хэмжээнд байгаа.

Төрийн банк хувь эзэмшлийн хувьд бол энэ хувьцаат компани болсон шүү. Гишүүн ээ. Хуучных шиг цүнхээр хувьчилдаг гэсэн ойлголт бол байхгүй. Тус банкны менежментийг сайжруулах, үр өгөөжийг нь дээшлүүлэх хүрээнд энэ Засгийн газрын дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнүүд ч гарсан байдаг.

Үүнийхээ дагуу тус банкны 4.5 хувь нь олон нийтийнх болсон байгаа. Мөн үүнийг нэмэхээр төлөвлөгөө байгаа. Зах зээлийн хамгийн боломжтой, тохиромжтой цонх үеийг хүлээж байна.

Хувьцаат компани болсноосоо хойш тус компанийн үр өгөөж нэмэгдсэн байгаа. Сайн ажиллаж байгаа гэж дүгнэж байгаа. Олон нийт ч тэгж дүгнэж байгаа. Хувьцааных нь үр өгөөж нь ч тогтвортой байгаа. Хувь нийлүүлэгчдийнхээ хурлаар ч ингэж дүгнэсэн байгаа.

Тэгэхээр хувьцаат компанийн үйл ажиллагаанд дүгнэлт хийхдээ бас их яаравчлан үнэлэлт, дүгнэлт өгөхөөсөө өмнө хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурал, ТУЗ-ийн хурлын энэ үнэлгээ мэдээллүүд, олон нийтийн өмнө одоо маш тодорхой ил тод байж байдаг энэ бирж дээрх мэдээлэл энэ үнийн хөдөлгөөнүүдийг нь бас судалгаа шинжилгээ хийж үзээд тэгээд дүгнэлт хийж байвал бас зүгээр шүү.

Тийм учраас энэ тусгай банкны үйл ажиллагаатай холбоотой ийм сөрөг мэдээллүүдийг бас нэлээн тал талаас нь харж байж ингэж дүгнэлт өгөөрэй гэж хүсэх байна.

Х.Ганхуяг: Да.Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Хувьцаат компани болсоныг нь мэдэж байгаа. Сайд аа. Тэгээд хувьцаат компанийн мэдээллүүд чинь ил тод байх ёстой. Тэгээд дээрээс нь энэ чинь төрийн өмчит аж ахуйн нэгж. Нийтийн албан тушаалтан гээд Авлигатай тэмцэх газарт хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлээд явж байгаа албан тушаалтнууд ажиллаж байх ёстой.

2024 онд байх аа. Бас төсөв хэлэлцэж байх үеэр би энэ Төрийн банктэй холбоотой шаардлагатай мэдээллүүдийг авъя гээд Төрийн банк руу хандсан. Нууц мэдээлэл гээд нэг ч мэдээлэл ирүүлээгүй.

Тэлмэн билүү, Тэлмүүн билүү Сангийн яамны бас нэг газрын дарга нь ТУЗ-ийн дарга хийж байгаа. Би энэ коридорт тааралдаад би нэг ийм ойр зуурын мэдээллүүд авах гэсэн юм. Мэдээллээ өгөөч гэсэн. Бас өгөөгүй. Нуугаад байгаа юм. Хувьцаат компани дээр нуугаад байх юм. Тэгээд төрийн өмчит аж ахуйн нэгж дээр нуугаад байх юм юу байгаа юм. Нуугаад байгаа мэдээлэл нь бол миний хараад байгаагаар одоо ёстой жинхэнэ хамаарал бүхий хүмүүс байгаа учраас л нуугаад байна гэж харах гээд байгаа юм. Түүнээс би зориудаар гүтгээд, доромжлох гээд байгаа юм байхгүй.

Топ 5 банкны хамгийн мууд явж байгаа нь Төрийн банк л байгаа. Арилжааны 14 банк одоо энэ... /минут дуусав/

Х.Ганхуяг: Асуулт байсан уу, санал байсан уу? Санал хэллээ.

П.Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Нөгөө түрүүчийнхээ асуултуудыг давтаад асууя. Энэ 52 дугаар тогтоолын 3 дугаар бүлгийн 16 дээр байгаа. Төсвөөс олгож байгаа бүх төрлийн татаас урамшуулал гээд тавьчихсан. Үүний эдийн засагт үзүүлж байгаа үр нөлөөний судалгааг хийгээд, 2025 оны 2 дугаар улиралд багтаагаад саналуудаа оруулж ирэх гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ олон төрлийн татаасыг ер нь яаж хэрэгжүүлбэл илүү оновчтой юм бэ?

Тэгэхээр одоо явж байгаа бүх төрлийн татаас орно. Энд. Одоо нэг төрлийн татаас нь энэ зээлийн хүүгийн татаас байж байгаа. Тэгээд би түрүүн асуусан. “Шинэ хоршоо” гээд зөвхөн нэг зээлийн хүүгийн татаасанд 2023, 2024 онд “Шинэ хоршоо”-нд нийтдээ 840 тэрбум төгрөгийн зээл банкууд өгсөн. Хүүгийн татаасыг нь бас төсөв дээр суулгасан. Энэ үргэлжлээд 2026 оны төсөв дээр дахиад орж ирж байгаа. 500 тэрбум төгрөг нэмж олгоно гээд хүүгийн татаас нь 109 тэрбум төгрөг тавьчихсан явж байгаа.

Энэ хэр одоо байгаа онож байгаа юм бэ? Энэ чинь одоо хэрэглээ болоод гаргаад байгаа юм биш үү. Одоо бид нарын яг яриад байдаг буцаад л гадаад валютын нөөцөд нөлөөлдөг, инфляц импортолдог. Тэгээд эргээд энэ нь инфляц өсөөд иргэдийн амьжиргаа, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлдөг ийм

асуудлууд байна. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч ээ. Ямар санал, шийдэлтэй байгаа юм бэ?

Хоёрт, энэ төсвийн ил тод байдал, үр ашигтай байдал, түүний хяналт, хариуцлагыг сайжруулна гээд. Энэ асуудлыг бас хоёрдугаар улиралд багтаагаад танилцуулахыг Засгийн газарт даалгасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт сайд 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан танилцуулахдаа 15 их наядын зөрчил илэрсэн. Түүнээсээ 6 их наядыг нь арилгуулж, 9 их наядын зөрчлийг хянуулахаар ингээд нягталж байна гээд тавьсан. Тухайлбал, одоо энэ яг юу болсон бэ? Одоо яг энэ агуулгатай шууд хамааралтай заалт.

Гурав дахь асуулт бол хамгийн эхний асуудал дээр тавьсан байж байгаа. Энэ татварын асуудал. Татварын дарамтыг бууруулна. Тэгээд одоо энэ 2026 оны улсын төсөв сая өргөн барихдаа бол ганцхан НӨАТ-ын татвартай холбоотой асуудлыг л дурдсан. 2024 оны шинэ парламент бүрдэхдээ 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг нь батлахдаа бизнесийн орчныг таатай болгоно, эдийн засагт хувийн оролцоог нэмэгдүүлнэ, татварын дарамт ачааллыг бууруулна гээд баахан сайхан сайхан заалтуудыг бид оруулсан. Тэгэхдээ бодит байдал дээрээ өдий болтол бодитой хэрэгжиж байгаа татварын хөнгөлөлт чөлөөлөлт бараг алга.

Улсын Их Хурлаас бас ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Уг нь Сангийн яам энэ тэртэй нэлээн ажиллаад ойлголцоод тэгээд 4 төрлийн татвар буюу НӨАТ, хүн амын орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гээд холбогдох татварууд дээр үе шаттай хөнгөлөлтүүд үзүүлэхээр ингээд тавьсан. Бүх ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүст хамаатай юм. Илүү их хөдөлмөрлөж байгаа хүмүүсээ дэмжье, аж ахуйн нэгж, ажлын байр бий болгож байгаа компаниудаа дэмжье ээ гээд. Гэтэл одоо энэ 2026 оны төсөв дээр огт энэ асуудал дурдаж тусгагдаагүй байна.

Тэгээд уг нь энэ тогтоолоор бас энэ агуулгадаа бас үүрэг өгсөн байгаа. Энэ яагаад ингээд бас бүрэн гүйцэт хэрэгжихгүй байна аа? Засгийн газар энэ дээр яагаад санаачилга гаргаж ажиллахгүй байна вэ? Энэ гурван асуултад тодорхой хариулт авъя.

Х.Ганхуяг: Хэн хариулах вэ? Хөдөө аж ахуйн яамнаас хүн байна уу? Байхгүй байна. Эрчим хүчний яамнаас хүн байна уу? Одоо хамгийн их л татаас авдаг яамдуудын нэг дээ бас.

Тэр дугаар дээр очоод суучих. Тэр 4 номер дээр очоод суучих. 4 номерын микрофон өгье.

Ш.Ганзориг: Эрчим хүчний яамны Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга Ш.Ганзориг хариулъя.

Татаас дээр Эрчим хүчний яам төрийн өмчит компаниудын татаасын асуудал Орөнхийдөө яг нарийн тоог нь бас яг хэлж сайн мэдэхгүй байна л даа. Татаасны асуудлуудыг. Тийм. Мэдээллийг нь нарийвчлаад хүргүүлье.

Х.Ганхуяг: Тэргүүн Шадар сайд байдаггүй. Тэгээд асуудал хариуцсан хүн нь асуудлаа мэдэхгүй. Нөгөө асуудал хариуцсан хүн нь ирээгүй. Ингээд л бүх ингээд л өмнөх парламент дээр ч гэсэн ингээд л ганцхан Сангийн сайдаа суулгачхаад л энд тэндээс нь мэрээд л суудаг байсан. Одоо ингээд л яг үргэлжлээд л явж байгаа байхгүй юу.

Энэ чинь одоо ганцхан сайдтай Засгийн газар уу? 5 номер.

С.Тулга: Сайн байна уу? С.Тулгаа. Сангийн яам.

“Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд ерөнхийдөө Монголбанк, Хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, тэгээд арилжааны банкууд хамтраад зээлийн ерөнхий гэрээ байгуулсан байгаа.

Тэгээд зээлийн ерөнхий гэрээгээр бол яг ямар бүтээгдэхүүн дээр зээл гаргах вэ гэдгийг нь тодорхой заасан байдаг. Энэ чинь 14 бүтээгдэхүүн байгаа. Тухайлбал, бэлчээрт худаг ус гаргах, ус хангамжийн байгууллага байгуулах, бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн үйлдвэр, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, мал бордох аж ахуй байгуулах гээд ерөнхийдөө дандаа ийм зориулсан тусгайлсан ийм хөтөлбөрүүд гаргасан байгаа.

Энэ хүрээнд одоогийн байдлаар бол 840 орчим тэрбум зээл гарсан байна. Энэ нь болохоор 24 мянган зээлдэгчид очсон. Сангийн яамны гэрээгээр хүлээсэн үүрэг бол хүүгийн татаасыг төсөвт тусгах байгаа. Ингээд 109 тэрбум гээд 2026 он дээр тавьсан дүнг асууж байна. Энэ болохоор 840 тэрбум буюу одоо олгосон дээр 2026 онд шинээр гарах 500 тэрбум. Энэ том зээлийн хүрээнд одоо олгож байгаа татаас юм.

Төв банкнаас бид тогтмол мэдээлэл авдаг нь энэ зээл чанаргүйжиж байна уу, үгүй юу гэдэг дээр мэдээлэл авч байгаа. Хамгийн сүүлийн бидний авсан мэдээллээр чанаргүйжсэн зээлийн 840 тэрбум дотор байхгүй. Анхаарал хандуулах зээл бол 7 зээлдэгч дээр 200 сая төгрөг дээр байгаа гэсэн ийм мэдээлэл авсан байгаа.

Яг ямар үр дүн гаргаж байгаа вэ гэдгийг яг салбарын яамнаас нь асуусан нь дээр байх.

Х.Ганхуяг: Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас таны тавьсан асуултыг Байнгын хорооноос ер нь мэдээлэл авахаар явуулъя. Тэгээд мэдээллийг нь авч өгье. Тийм. П.Ганзориг гишүүн тодруулъя.

П.Ганзориг: Энэ Байнгын хороон дээр бас энэ Их Хурлын чухал тогтоолын хэрэгжилтийг ингээд хэлэлцэж байхад бас асууж байгаа асуулт энэ тэрийг бас тодорхой тогтоож авч байгаад зөв хариулмаар байна.

Энэ тогтоолын чинь агуулга дээр заачхаад байна шүү дээ. Маш тодорхой. Энэ олон төрлийн хүү татаас байгаа. Аль нь эдийн засагт илүү үр дүнтэй, оновчтой юм бэ? Тэрийг нь судлаад шинжлээд эрэмбэлээд гаргаад ир ээ. Танилцуул гэсэн байгаа байхгүй юу. Тэгээд зүгээр жишээ болгоод “Шинэ хоршоо”-г асуулаа шүү дээ. Тэгэхдээ би таны хэлээд байгаа тоог чинь урдаас чинь хэлсэн шүү дээ. 840 тэрбум олгосон. Ирэх жил 500-г олгох гээд дахиад 100 тэрбумыг жишээ нь тавьж байна. Бусад нь яах юм бэ? Яаж эрэмбэлж, яаж харж байгаа юм бэ?

Одоо энэ зээлийн багцын асуудлаа хар л даа. Хувийн хэвшил чинь эх үүсвэрийн дутагдалд ороод татвараа ч төлж чадахгүй... /минут дуусав/

Х.Ганхуяг: Хугацаа нэмүүлэх үү. Дахиад 1 минут сунгачихъя.

П.Ганзориг: Тэгэхээр энэ олон төрлийн зээл, татаас, хүүгийн татаасуудаа энэ төсөл хөтөлбөр болгоноор нь ангилаад аль нь оновчтой, алийг нь зохих юм, алийг ямар төрлийн шинэ зээлийн бүтээгдэхүүн татаасуудыг нэмж оруулж ирэх юм гэдэг л зүйл энэ дээр орж ирэх ёстой шүү дээ. Засгийн газарт өгсөн үүрэг нь маш тодорхой байна шүү дээ. Их Хурлаас.

Тэгэхээр жишээ болгож асуусан шинэ хоршоог урдаас тайлбарлаад суугаад байхаар чинь одоо юу гэж ойлгох вэ? Тэгээд ингээд нэг цаг нөхцөөсөн, залхаасан ийм байдлаар л ер нь энэ Их Хурлын ч, Байнгын хорооны юм явах юм. Тэгээд асуух ч хэцүү. Сүүлд бүр асуух ч бараг хэрэг байна уу даа гэж бодогдох юм.

Тэгэхээр энэ дээр жоохон хариуцлагатай хандмаар байна.

Х.Ганхуяг: Санал хэллээ. П.Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Яах вэ, би энэ төсөв батлагдсантай холбоотой авах зарим арга хэмжээний тогтоол дээр бас хоёр зарчмын зөрүүтэй саналыг яг санал гаргаж оруулж байсан юм.

Яах вэ, зүгээр нэг нь бол одоо бас ч яах вэ явж байна. Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төвүүдийг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яаманд шилжүүлэх гээд.

Нөгөөдөх нь цэвэр эрчим хүч үйлдвэрлэх, хогноос сэргээгдэх эрчим хүч гаргаж авах асуудлыг зохицуулах, ногоон эрчим хүч эдийн засгийг дэмжих хууль тогтоомжийн төслийг боловсруулж өргөн барь гээд.

Тэгээд энэ дээр яах вэ хоёр дахь энэ эрчим хүчтэй холбоотой энэ асуудал дээр ерөөсөө хариулт, тайлбарууд хангалтгүй байна. Хоёр, гуравхан зүгээр нэг хэрэгжиж байгаа төслүүд. Яг наад Хог, хаягдлын тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний хуулиар зарим юм чинь явахааргүй юм байна лээ.

Тэгэхээр энэ зүйлүүдийг уг нь бодлогын хувьд тодорхой болгоод, цаашдаа энэ цэвэр эрчим хүч буюу газрын гүний дулаан ашиглах, цаашилбал ураны асуудал, атомын цахилгаан станцын суурь асуудлыг зүгээр тавьчихмаар байгаа байхгүй юу.

Энэ асуудал дээр зүгээр тодорхой хэмжээний зүгээр шийдлүүдийг гаргаад ороод ирвэл хөрөнгө оруулагч нар хууль эрх зүйн орчныг маань харж байж орж ирэх байхгүй юу. Ерөөсөө юу ч байхгүй.

Тэгээд ерөөсөө энэ асуудлууд явдаггүй. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг шийдье гэвэл уг нь дулааны асуудал юм байгаа юм. Дулааны асуудлыг шийдэхэд энэ газрын гүний тулаан байхгүй юу. Монгол Улсын бараг төв суурин газруудын ирээдүй байгаа. Магадгүй энэ Архангай. Хуучин тэр галт уулын байж байсан. Одоо ч энэ халуун рашаан гардаг газрууд чинь энэ асуудлыг бид судалж чадаж бодлогын түвшинд чадвал уг нь асуудлуудаа шийдье гэсэн юм. Тэгээд юу ч байхгүй. Тэгээд одоо ийм л сонин байдалтай л ийм л хариултууд байна. Тэгээд энэ дээр бол би жоохон сэтгэл дундуур байна. Нэг талдаа.

Тэгээд эргээд яг энэ хоёр асуудал дээр ямар Б.Жавхлан сайд хариулах биш. Холбогдох яамдын хүмүүс нь бас нэг тодорхой мэдээллээр хангаач ээ гэж зүйлийг хүсэж байна.

Хоёрдугаарт, би Байнгын хороо бас анхаараасай гэж бодож байгаа юм. Уг нь энэ төсөв батлагдсантай ч гэдэг юм уу, тодорхой хууль батлагдсантай холбоотой арга хэмжээний тогтоолуудыг бас наана нь энэ дараа жилийн төсөв батлахаас өмнө энэ юмнуудыг ба бас нэг бодлогын хувьд оруулж ирээч ээ, анхаараач ээ гэдэг зүйл байгаа юм. Гэтэл сүүлийн үед ер нь энд орж ирж байгаа ч юм алга. Зүгээр ерөнхийдөө нэг хэрэгжилт ийм байна гэж байна.

Одоо би сая өргөн барьсан 2026 оны төсвийг бүр ойлгохгүй байгаа. Өргөн баригдаагүй байгаа. Төсөв маань бол өргөн баригдчихсан. 2026 оны төсөв. 2026 оны төсөв дээр өргөн баригдаагүй боловсруулж байгаа хуулиудынхаа концепц дээр тулгуурлаад ингэж ингэж татварын орлогыг бууруулна, ингэж ингэж татварын одоо төсвийн орлогыг нэмэгдүүлнэ гээд яриад байгаа байхгүй юу. Тэр хууль чинь орж ирэх юм уу. Тэр хууль орж ирээд батлагдана гэсэн зүйл байгаа юм уу. Эсвэл яг орж ирээд одоо яг тэр чигээрээ батлагдана гэсэн зүйл байх юм уу, үгүй юу гээд.

Жишээ нь, НӨАТ-ыг жишээ аваад л яриад байгаа байхгүй юу. Өргөн баригдаагүй. Гэтэл НӨАТ-ын буцаан олголтыг л бид дараа жил одоо 5 хувьд хүргэнэ гээд төсөвтэйгөө уяж яриад. Гэр бүлийн өрхийн орлого дээр ийм ийм дэмжлэг ингэж орж ирнэ. Төсөв уг нь ингэдэггүй л байсан. Бусад үед хамтдаа өргөн баригдаад юмнуудаа явдаг байсан боловч одоо ингээд бид өргөн баригдаагүй хуулиудыг чиглэл болгоод ингээд явж болох юм уу? Энэ анхнаасаа энэ төсөв боловсруулах үйл ажиллагаа чинь ингээд болохгүй байна шүү дээ.

Тэгээд он дамжсан төслүүдийг ингээд л хэрүүл уруултай баахан ярих юм. Магадлал хийсэн юм уу, аудит хийлгэсэн юм уу гээд. Тэгээд гол гажиг дээрээ яримаар байна шүү дээ. Тендерийн хуулиа янзалмаар байна. Энэ салбаруудын стандартыг янзалмаар байна. 6 мянган стандартаас чинь ихэнх стандартууд чинь буюу дандаа түгжээ болсон социализмын үед батлагдсан, зах зээлийн шилжилтийн үед батлагдсан ийм зүйлүүд байгаа шүү дээ.

Энэ стандартыг жишээ нь сайжруулж чадвал бид зүгээр барилгын салбарыг би ярья л даа. Барилгын салбарын стандартыг өөрчилж чадвал бид барилгын өртгийг бууруулж чадна.

Ер нь тэгээд одоо ингээд хэмжээ хязгаартай юмаа тавьж сурмаар байгаа байхгүй юу. Тэгээд баахан ингээд амсуулаад амсуулаад тавьчихна.

Х.Ганхуяг: П.Сайнзориг гишүүний минутыг өгье.

П.Сайнзориг: Амсуулаад, амсуулаад мөнгийг нь тавьдаг тэгээд 3 жил 6 сар болж байж нэг сургууль барьж байгаа статистиктай Монгол Улс бид хэд бол? Үнэндээ хэлэхэд бол одоо ийм байхаар угаасаа явахгүй. Тэгээд энэ төсвийн реформ ч явахгүй. Үе үе ингээд аргалаад л өнгөрнө.

Тэгэхээр уг нь энэ дээр Б.Жавхлан сайд тодорхой судалгаа хийгээд ийм хувилбарууд байна гээд бас нэг яримаар байна. Тэгээд ер нь зүгээр энэ хуулиудын тоог хэлээд байх шиг байна. 208 хуулийн 1020 хэдэн заалтаар төсөв хуваарилж байна гээд байгаа боловч үүнийг эрэмбэлмээр байна.

Яг гол хэдэн заалтууд л байгаа шүү дээ. Халамжийн хэдэн заалт. Эргээд энэ улс төрийн сонгуулийн өмнөх популизмын буюу энэ санал татах зорилгоор хийсэн хэдэн нийгмийн халамжийн хуулиуд л байгаа шүү дээ. Энэ дээрээ зоригтой шийдлүүдээ яриад, хувилбаруудаа гаргаад ирмээр байгаа байхгүй юу. Юу ч ярьдаггүй тэгээд л баахан ингээд л 208 хуулийн мянга хэдэн заалт байна. Энэ ингээд болохгүй байна л гээд байдаг. Яг эцсийн дүндээ тэр олон заалтууд чинь нэг их төсөвт дарамтлаад байгаа юм байхгүй. Хоёр, гуравхан хуулийн асуудлыг л бид хэд эргээд ярьж болно шүү дээ.

Тэгэхээр энэ дээр ингээд бодитой... /минут дуусав/

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Тэр байгаль орчин, цэвэр эрчим хүч эд нар гээд түүн дээр нь энэ тогтоол дээр нь хүртэл заачихсан байна шүү. Энэ Шадар сайд, Эрчим хүчний яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам хариуцна гээд. Тэгэхээр энэ яамдууд нь хариулна биз.

Дараагийн асуулт нь яах вэ, шууд тогтоолтой холбоогүй ч гэсэн дээ би асуултуудад нь хариулъя.

П.Сайнзориг гишүүн өөрөө одоо хуульч хүн. Төсвийн хуулиудаа гүйцэж үзэх байлгүй дээ. Бас цаг хугацаа нэлээн давчуу байгаа учраас амжаагүй байгаа юм шиг байна. НӨАТ-тай холбоотой заалтыг чинь нэмэлт, өөрчлөлтөөр таслаад төсөвтэйгөө цуг дагуулаад өргөн барьчихсан байгаа шүү дээ. Тийм 2-ыг 5 хувь болгохыг таслаад цуг өргөн барьчихсан байгаа. Бусад нь D-Parliament дээр танилцуулахаар явж байгаа.

Яагаад тасалсан бэ вэ гэхээр энэ багц өөрчлөлт маань өөрөө багадаа 3.6 их наядын төсөвт нөлөөлдөг юм. Өөрөөр бол ийм өртөгтэй гэсэн үг. Нэг удаагийн төсөв дээр энэ дийлэхгүй.

Тийм учраас 2026, 2027, 2028 онуудад дунд хугацаанд шат дараатай ингэж хэрэгжүүлнэ.

Тийм учраас хамгийн эхний ээлжид одоо хамгийн их хүлээлттэй байгаа хэрэгжүүлж болохоор систем бэлэн болсон байгаа. Энэ НӨАТ-ын буцаан олголтыг эхлүүлж байгаа. Энэ маань ч өөрөө бас багагүй өртөгтэй. 1 их наяд 85 тэрбум төгрөгийн өртөгтэй ийм НӨАТ-ын өөрчлөлт болж байгаа шүү.

Гэхдээ 2026, 2027, 2028 онуудад бусад татварын багц өөрчлөлтүүдийг ч гэсэн хэрэгжүүлэхдээ саяын таны хэлдэг 208 хуультай холбоотой мянга гаруй заалтыг зэрэгцүүлж явахгүй бол энэ татварын өөрчлөлтийг бас хэрэгжүүлж чадахгүй. Чадахгүй.

Тэгэхээр одоо таны хаагуур нь яваад бид явуулчихсан байгаа юм. Уучлаарай. Одоо танд дахиад тэгвэл бид танилцуулъя, хүргүүлье. Та үүнийг бас өөрөө дэмжиж байгаа учраас бас бидэн дээр хүч нэмнэ байх гэж хүлээж байна.

Х.Булгантуяа дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг гараад, тэр ажлын хэсэг дээр бид бүх материалуудыг бэлдэж өгсөн. Эрэмбэлж байгаад бүр. Жишээ нь, одоо 2025 оны төсөвт, 2024 оны төсөвт энэ ямар ямар хэмжээгээр яаж туссан байдаг юм. Аль нь тогтоолоор юм, аль нь хуулиар юм. Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоолоор гээд маш олон ийм эрх зүйн бичиг баримтууд байгаа. Нэг бүрчлэн гаргаад, хүчингүй болгох, хойшлуулах гээд. Ингэж ингэж байгаад бид сая 7 сард тодотголоор ганцыг нь аваад орсон шүү

дээ. Төрийн албан хаагч нартай холбоотой, нэмэгдлүүдтэй холбоотой ганцхан хуулийг нь аваад ороход л тас алгадуулаад л буцаад л бид өргөн барихаас, бүр өргөн бариад хэлэлцэхээс нь өмнө бүр буцаж авах ийм байдалд ирсэн. Буцаахгүй бүр Улсын Их Хурал тодотголыг маань бүр хэлэлцэхгүй шатад очсон шүү дээ.

Тэгээд юун 208 хууль. Ганц хуулийг өргөн барихад л тэгсэн. Тэгээд энэ удаа ер нь бол бид бас өргөн барихад бэлэн байсан.

Тэгэхдээ бас ийм эгзэгтэй гадаад нөхцөл тодорхойгүй, төсвийн орлого... /минут дуусав/

Х.Ганхуяг: Гүйцээгээд хариулчихъя.

Б.Жавхлан: Төсөв хэлэлцэх, улмаар батлах явцад бас эрсдэл учирч болзошгүй учраас тусад нь өргөн барья гээд бэлдсэн байгаа.

Тэгэхдээ үүнийг Улсын Их Хурал дээр өргөн барихаасаа өмнө Улсын Их Хурал дээрээс дахиж ажлын хэсэг юм уу, эсвэл Х.Булгантуяа даргын ахлуулсан ажлын хэсгийг дахиж үргэлжлүүлж бид танилцуулаад энэ дээр их зөв ойлголцож байж. Ялангуяа яг салбар салбарын төлөөллүүдтэй, яамдтай маш сайн ойлголцож байж өргөн барихгүй бол салбар салбарын бие хамгаалагч нар, төлөөлөгч нар маань гарч ирээд энэ хуулиудыг чинь ерөөсөө огт явуулахгүй юм байна лээ. Тийм. Нэг ийм л зовлон байна даа.

Х.Ганхуяг: П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би зовлонг нь ойлгож байна. Б.Жавхлан сайд аа. Тэгээд яах вэ зүгээр би энэ шинэ Засгийн газар бүрдэж байхдаа бас нэг санал болгосон асуудал энэ хууль тогтоомжийн агентлаг байхгүй юу. Харахад нэг байгууллага байгуулах гээд байгаа юм шиг мөртлөө яг наад ажлыг чинь хийх юм.

Монгол Улсын Үндсэн хуулиар зааснаар Ерөнхий сайд энэ Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй. Аль хууль хэрэгжээд, нийгэм ямар үр нөлөө үзүүлж байгаа юм бэ гэдгийг салбар яамд үнэхээр өнөөдрийн хүний нөөцөөрөө хийж чадахгүй. Энэ чинь бас мэргэшсэн бөгөөд байнгын тогтмол дата цуглуулж байж анализ хийж байдаг асуудал.

Хууль чинь өөрөө эргээд процессын шинжтэй хууль нь өдөр тутам анализ хийж болж байхад, энэ материаллаг гэдэг юм уу холимог хуулиуд чинь тодорхой хэмжээнд дата цуглуулж байж үнэлэлт өгөөд энэ татаасыг үргэлжлүүлж болно, энэ хүүхдийн мөнгийг ингэж болно, энэ төрийн албаны нэмэгдлийг ингэж болно гээд тодорхой шийдэлтэй орж ирээд Ерөнхий сайд кабинет дээрээ танилцуулаад уг энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байх ёстой юм.

Тэгээд сүүлдээ энэ ингээд төсвийн зовлон болж байна, хуулийн түгжрэлийн зовлон болж байна. Энэ салбарууд чинь эндээ хүрч чадахгүй байгаа юм. Яг уг нь салбар салбар нь ангилаад явъя. Ийм агентлагаас уг нь нэг гар татаад байгаад би бас гайхаад байгаа юм.

Тэгэхээр энэ уг нь төсвийн реформ дээр чинь ингээд түлхэц үзүүлэх... /минут дуусав/

Х.Ганхуяг: Ер нь бол ортой л юм ярьж байна. Тэгээд ер нь цаашдаа Улсын Их Хурлын төсөв дагаж гарсан энэ тогтоолын хэрэгжилтийг бүр зүйл бүрээр нь тус тусад нь авч хэлэлцдэг л болмоор юм байна. Энэ чинь ингээд бөөнд нь ярьчихаар нөгөө улс гишүүд сайд нар нь ч ирэхгүй. Тэгээд ганцхан Б.Жавхлан сайдын ажил юм шиг болчихоод байна шүү дээ. Яг эцэстээ бол. Тэгээд энэ дээр бол анхаармаар юм байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсож дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Хуралдаан 3 цаг 23 минут үргэлжилж, 17 цаг 15 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД